


MONGOLIAN STOCK EXCHANGE

2020 -08- 24

БҮРТГЭВ-03

2020



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

Хаяг: УБ хот, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсийн байр, 2 давхар

Утас: 77078080, Гар утас: 88114679

И-мэйл: info@ardmanagement.mn, Вэбсайт: www.ardmanagement.mn



“УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь олон нийтэд нэгж эрхээ санал болгон гаргаж, зах зээлийн үнээр худалдаалдаг, өөрийн гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдаж авах үүрэг хүлээдэггүй хаалттай хөрөнгө оруулалтын сан юм. Хөрөнгө оруулалтын сан нь улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчийн компаниудын хувьчлалд оролцох, Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад арилжаалагдаж буй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бонд зэрэгт хөрөнгө оруулалт хийх зорилгоор олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж байгаа болно. Сан нь 10 жил үйл ажиллагаа явуулах бөгөөд үйл ажиллагаа дуусгавар болсоны дараа нийт хөрөнгөө хөрөнгө оруулагчдадаа хуваарилна. Энэхүү нэгж эрхийн танилцуулга нь хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга, хөрөнгө оруулалтын бодлого, тооцоолол, төлөвлөгөө, хамтран ажиллах байгууллагуудын талаар мэдээллийг багтаасан гол бичиг баримт мөн.

НЭГЖ ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг нэгж эрх гаргаж, үүний 95 хувийг буюу 47,500,000 ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгон арилжаална. Хөрөнгө оруулагчид харилцагч үнэт цаасны компаниараа дамжуулан Монгол Хөрөнгийн Биржээс “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Нэгж эрх гаргагч	“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС
Нэгж эрхийн санал болгох үнэ.....	100 төгрөг
Олон нийтэд санал болгох нэгж эрхийн тоо.....	47,500,000 ширхэг
Санал болгох хүрээ	Олон нийт
Арилжааг зохион байгуулах байгууллага.....	Монголын Хөрөнгийн Бирж

“АРД МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК

“Ард Менежмент УЦК” ХХК нь “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сангүүсгэн байгуулагч бөгөөд нэгж эрхийн танилцуулгыг боловсруулсан болно.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж, “Ард Санхүүгийн Нэ гдэл” ХК-ийн байр. Утас: 976-77078080, Вэб сайт:

www.ardmanagement.mn

“БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС” ХХН

“Батбаяр Энд Партнэрс” ХХН нь “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах бичиг баримтыг боловсруулж, хууль зүйн зөвлөгөө үзүүлэх чиглэлээр хамтран ажилласан болно.

“ГОЛОМТ БАНК” ХХК

“Голомт Банк” ХХК-ийн кастодиан банкны хэлтэс нь сангийн хөрөнгийг хадгалах гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийг хадгалах үйлчилгээ үзүүлнэ.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн холбогдо журмуудын дагуу нэгж эрхээ олон нийтэд анх удаа нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

**ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БҮРТГЭСЭН НЬ УГ НЭГЖ ЭРХИЙН ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ
БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ БОЛОН ТҮҮНИЙ УДИРДАЖ БАЙСАН БУСАД САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ЭНЭХҮҮ НЭГЖ ЭРХИЙГ ГАРГАЖ БҮЙ САНГИЙН
ИРЭЭДҮЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА БОЛОХГҮЙ. ЭНЭХҮҮ НЭГЖ ЭРХИЙГ ХУДАЛДАН АВАХ
ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ
ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА, НЭГЖ
ЭРХ ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү нэгж эрхийн танилцуулгад хөрөнгө оруулагч Танд тус нэгж эрхийг худалдан авах шийдвэр гаргахад туслах бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагчид шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйл гарвал хөрөнгө оруулалтын менежментийн компани болох Ард Менежмент УЦК-д хандана уу.





УНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



2020 -08 - 24

МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ
БИРЖ-02

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ӨГӨӨЖ ХҮРТЭЦГЭЭ.

Өнгөрсөн 15 жилд Монгол Улсын хөрөнгийн зах зээл дэх хувьцааны ханшийн өсөлт, бууралтыг харуулдаг ТОП-20 индекс жилд дунджаар 54.3 хувиар өссөн байна. Энэ нь жилд 54.3 хувийн өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх боломж байсныг харуулж байна. Харин энэ хугацаанд хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүү 12.5% байсан.

ТОП-20 индексийн жилийн өгөөж ба хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүү



Тайлбар: ТОП-20 индексийн түүхэн үзүүлэлтээс сар бүрийн дунджийг тооцож улмаар жилийн дараах үетэй нь харьцуулан жилийн өгөөжийг тооцсон бол хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүүг сар бүрээр Монголбанкны статистикаас авсан.

Харамсалтай нь ихэнх иргэд хөрөнгийн зах зээлд оролцож, хөрөнгө оруулалт хийх нь бага байна. Учир нь хувьцаа, бонд зэрэгт хөрөнгө оруулалт хийхийн тулд судалгаа шинжилгээ хийх, эрсдэл тооцох зэргээр тодорхой мэдлэг, мэдээллийг шаардаж байдаг бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад хүндрэлтэй байдаг билээ. Тэгвэл өөрсдийн мэдлэг, туршлага дээр үндэслэн хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулалт хийхээр зорьж буй Монголын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагдаад байна.

Ундэсний Хувьчralын Сан нь зуу эсхүл хэдэн мянган хөрөнгө оруулагчдын хөрөнгийг нэгтгэн томоохон компаниуд эсхүл ирээдүйд хурдтай өсөх үйлдвэр, бүтээн байгуулалт зэрэгт хөрөнгө оруулалт хийхээр зорьж байна. Ингэснээр жилд дунджаар 17.6 хувийн¹ өгөөж (зардал хассан)-тэй хөрөнгө оруулалт хийнэ.

Жилийн дундаж өгөөж

17.6%

¹ Өгөөжийн талаар 7 дугаар хуудаснаас дэлгэрэнгүй танилцана уу.





Бид мэргэжлийн судалгаа шинжилгээнд тулгуурлан хөрөнгө оруулалт хийх тул хөрөнгө оруулагчдыг Сангаар дамжуулан хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийхийг санал болгож байна.

ЭХ ОРОНДОО БҮТЭЭЖ БҮЙ БАЯЛАГААС ХУВЬ ХҮРТЭЦГЭЭЕ.


Үндэсний Хувьчлалын Сан нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн болон орон нутгийн өмчит компаниудын хувьчлалд оролцоо зарыж байгаа бөгөөд түүнээс бий болох өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилна.

Хувьчлал

Монгол Улс 1991 оноос хувийн өмчийг бий болгох, хөрөнгийн дахин хуваарилалтыг хийх зорилгоор төрийн өмчит үйлдвэр, аж ахуй нэгжүүдийг хувьчилж, иргэд өмчийн эзэн болсон юм. Харамсалтай нь мэдлэг, мэдээлэл дутмаг байсан иргэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшсэн хувьцаагаа хямд үнээр мэдээлэлд ойр, туршлагатай гэх цөөн хүмүүст зарж, үүний үр дүнд цөөн гэр бүл компаниудын хувьцааны хяналтын багцыг эзэмшсэн байдаг.

Энэхүү хувьчлалын үр дүнд Монгол Улс богино хугацаанд төрийн өмчийг хувийн өмчид шилжүүлж чадсан ч иргэд хувьчлалын урт хугацааны үр өгөөжийг хүртэж, баялагийн эзэн болж чадаагүй алдсан юм. Иймд Үндэсний Хувьчлалын Сан нь хувьчлахаар хүлээгдэж буй томоохон төрийн өмчит компанийн хувьчлалд оролцож, урт хугацаанд хөрөнгө оруулагчдадаа өгөөж хүртээхээр зорыж байна.

Монголын Хөрөнгийн Биржээр хувьчлагдсан компаниудын нийт үнэлгээ тэрбум төгрөг



Хувьчлагдсан
компаниудын
зах зээлийн
үнэлгээ 28
жилийн дотор
224 дахин
өсчээ.

Тухайн үеийн хувьчлалд 1.2 сая иргэн оролцож, 475 улсын үйлдвэрийн хувьцааг МХБ-ээр дамжуулан ижил тэгш нөхцлөөр эзэмшсэн боловч 2019 оны байдлаар 483 иргэн, аж ахуй нэгж



СЭХ
он сар . елдс
БҮРТГЭВ
№ 01

2020 -08- 24
БҮРТГЭВ-03

уг хувьчлагдсан компанийн хувьцааны 90.1 хувь буюу 1.7 их наяд төгрөгийн хувьцааг эзэмшиж үлдсэн байна.

МОНГОЛЫН АНХНЫ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Монгол Улс болон дэлхий даяар арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилахаар зорьж байна.

Сангийн хуулийн хэлбэр

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС нь Хөрөнгө Оруулалтын Сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани юм.

Хөрөнгө оруулалт

Үндэсний Хувьчлалын Сан нь урт хугацаандаа Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчит томоохон компани, объектуудын хувьчлалд оролцох, дунд хугацаандаа нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бонд зэрэг зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийнэ.

Өгөөж²

Ta “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийснээр жилд дунджаар 17.6 хувийн өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх боломжтой. Хөрөнгө оруулалтын хамгийн сайн нөхцөл байдалд Сангийн жилийн өгөөж 37.5 хувь, харин хамгийн муудаа 8.4 хувь байхаар бид төсөөлж байна.

² Өгөөжийн талаар 7 дугаар хуудаснаас дэлгэрэнгүй танилцана уу.

00000005



ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН ХЭРХЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ВЭ?

Үндэсний Хувьчлалын Сан нь нэн тэргүүнд хөрөнгийн зах зээлийн өндөр өгөөжийг хөрөнгө оруулагч нартад хүртээх цаашлаад урт хугацаанд хувьчлалд оролцох зорилготой билээ.

Бидний зорилго

Улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компанийн хувьчлалд оролцох

Сан нь урт хугацаанд үлс орны төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үнэлгээг өсгөх замаар урт хугацаанд өгөөж хүртэхээр зорьж байна.

Монгол Улс төдийгүй дэлхий даяар арилжаалдаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх

Дунд хугацаанд Сан нь өндөр өгөөжийг голчлох бөгөөд хурдтай өсөх, ирээдүйтэй компанийд эсхүл зах зээлийн нөхцөл байдал муу үед хувьцаа нь унасан томоохон компанийд хөрөнгө оруулалт хийнэ.

Тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх

Мөнгөн ургал, хөрвөх чадварыг тогтвортой байлгахын тулд нээлттэй өрийн хэрэгсэл, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.

Үндэсний Хувьчлалын Сан нь үйл ажиллагаагаа 5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр эхлүүлэх бөгөөд дотоод болон гадны зах зээлд хөрөнгө оруулалт хийж ажиллана. Ингэхдээ Сангийн нийт хөрөнгийн 70 хүртэл хувиар компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийх бөгөөд жилд дунджаар 17.6 хувийн өгөөж (зардал хассан)-тэй хөрөнгө оруулалт хийж ажиллахаар төлөвлөөд байна. Сан нь 2029 онд 20.2 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй болох бөгөөд үүнийгээ хөрөнгө оруулагч нартад хуваарилах юм. Өөрөөр хэлбэл, Сангийн цэвэр хөрөнгө 9 жилд 4 дахин өснө гэж төлөвлөж байна. Харин хөрөнгө оруулагч нарын хувьд Сан нь нэгж эрхээ анх 100 төгрөгөөр санал болгох бөгөөд 2029 онд нэг нэгж эрхийн үнэлгээ 404.4 төгрөг болж, анхны санал болгосон үнээс 4 дахин өснө гэсэн үг юм. Энэхүү тооцооллоос гадна Үндэсний Хувьчлалын Сангийн төлөвлөгөөнд Мэдрэмжийн шинжилгээ хийсэн бөгөөд эдийн засаг сайн нөхцөлд Сан нь жилд дунджаар 37.5 хувь, муу нөхцөлд 8.4 хувийн өгөөжтэй ажиллах боломжтой юм.

Үндэсний Хувьчлалын Сангийн төлөвлөгөөний мэдрэмжийн шинжилгээ

Зах зээлийн нөхцөл

Сайн
Дундаж
Муу

Жилийн өгөөж

37.5%
17.6%
8.4%

Нэгж эрхийн үнэлгээ 2029 онд, төгрөг

1,653.4
404.4
196.0



2020 -08- 24

ARD
БҮРГГЭВ №03
МЕНЕЖМЕНТ КОМПАНИИ

Сангийн өгөөж нь Сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэмжигдэхүүн бөгөөд Сангийн цэвэр хөрөнгийн өсөлт бууралтаар илэрхийлэгдэнэ. Ингэхдээ Сангийн хөрөнгө оруулалтыг анх авсан үнээсээ өссөн буурсныг харуулдаг бөгөөд тухайн хөрөнгө оруулалтыг зарах хүртэл хэрэгжихгүй. Бид Сангийн өгөөжийг тооцоходо ТОП-20 индексийн 2010-2019 оны хоорондох түүхэн дундаж өгөөжийг ашигласан билээ. Статистик ач холбогдолын хувьд түүхэн тоон мэдээлэл нь илүү урт, олон жилийн мэдээлэл байх тусам ирээдүйн таамаглал хийх чадвар нэмэгддэг боловч ирээдүйд Сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийн баталгаа болохгүйг хөрөнгө оруулагчдад анхааруулж байна.





ТА ЯАГААД ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хөрөнгийн зах
зээлээс өгөөж
хүртэнэ.

Сан нь өндөр өгөөж
бүхий хөрөнгийн зах
зээлийн
бүтээгдэхүүнүүдэд
хөрөнгө оруулалт
хийнэ. Сан нь
дунджаар жилийн
17.6%-ийн өгөөжтэй
ажиллахаар
төлөвлөөд байна.

Татварын хөнгөлөлт
эдэлнэ.

Та банкны
хадгаламжийн
хүүгийн орлогоос
10%-ийн орлогын
татвар төлдөг бол
Сангийн ногдол
ашиг, ханшийн
зөрүүний орлогоос
5%-ийн орлогын
албан татвар төлнө.

Бага мөнгөөр
хөрөнгө оруулах
боломжтой.

Эрсдэлээ бууруулах
боломжтой.

Сан нь хөрөнгө
оруулалтын багцаа
олон төрлийн
хувьцаагаар
бүрдүүлдэг тул
дангаараа хөрөнгө
оруулалт хийсэнтэй
харьцуулахад
хөрөнгө оруулалтын
савалгааг багасгадаг.

17.6%
Жилийн
дундаж
өгөөж

5%
Орлогын
албан
татвар

100 төгрөг
Нэгж
эрхийн үнэ

Үндэсний Хувьчлалын Сан нь банкны хадгаламжтай харьцуулахад өндөр өгөөжтэй хэдий ч эрсдэлтэй хөрөнгө оруулалт сонирхож байгаа хөрөнгө оруулагчдад зориулсан юм.



ӨНДӨР УР ЧАДВАРТАЙ ТУРШЛАГАТАЙ БАГ САНГ УДИРДАНА.

Ард менежмент УЦК-ийн олон жилийн туршлагатай, мэргэжийн баг Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, хөрөнгө оруулалт хийнэ. Бид Ард Менежмент УЦК-ийн хөрөнгө оруулалтын мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүд Санг өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх зөв чиглэлд удирдана гэдэгт итгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын хороо



Ч.Ганхуяг
Хөрөнгө
оруулалтын
хорооны гишүүн



Г.Цогбадрах
Хөрөнгө
оруулалтын
хорооны гишүүн



Б.Золбоо
Хөрөнгө
оруулалтын
хорооны дарга



Ч.Хандаа
Сангийн менежер

26 жилийн
туршлагатай

24 жилийн
туршлагатай

4 жилийн
туршлагатай

14 жилийн
туршлагатай

Хувьцаа бүр ашигтай биш: Тухайн компанийн нөхцөл байдал эсхүл зах зээл, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан хувьцааны ханш өсч, буурч байдаг. Бид өндөр өгөөж өгөх боломжтой хувьцаа, хөрөнгө оруулалтаас үүсч болох эрсдэл зэргийг багтаасан өргөн цар хүрээтэй судалгаа хийж, хөрөнгө оруулалт хийнэ.


Бие дааж хөрөнгө оруулалт хийх нь зардлын хувьд өндөр байдаг: Бага мөнгөөр хөрөнгийн зах зээлд хувьцаа авч зарж буй жижиг хөрөнгө оруулагчдын гаргаж буй зардал их мөнгөөр арилжаанд оролцож буй мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас өндөр байдаг. Бидний үйл ажиллагааны цар хүрээ зах зээлийн арилжаанд оролцох үнийн дүн зэрэг нь бага зардлаар хөрөнгө оруулалт хийх боломжуудыг олгох болно.

Судалгаанд сууринсан хөрөнгө оруулалт: Зах зээлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, компанийн суурь шинжилгээнд анхаарлаа хандуулснаар бид хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, эрсдэлийг илүү үр дүнтэй удирдаж чадна. Бид зах зээлийн судалгаа, компанийн суурь судалгаа, одоогийн болон ирээдүйн мөнгөн урсгал зэрэгт үнэлэлт дүгнэлт хийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийнэ.



БИДНИЙГ ТӨСӨӨЛСНӨӨС ИЛҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ХҮЛЭЭЖ БАЙНА.


Үндэсний Хувьчлалын Сан байгуулагдаж буй энэ цаг үед хямралын үе таарч буй нь **БОЛОМЖ** юм. Учир нь Сангийн хөрөнгөөр сайн компанийн үнэт цаасыг хямд үнээр худалдан авах боломж үүсэж байна.



Зах зээлийн уналт биднийг айлгадаггүй. Уналт бол сайн менежменттэй сайн компаниудын хувьцааг хямд үнээр авах боломж юм.

Warren Buffet

Хөрөнгийн зах зээлд уналт, сэргэлт ээлжилж байдаг. Хөрөнгө оруулагчдын хувьд уналт, сэргэлтийн мөчлөгийг зөв таамаглаж чадах нь маш чухал юм. Сэргэлтийн үеийн оргил цэгт хөрөнгө оруулснаар та маш их мөнгөө алдах эрсдэлтэй бол уналтын үеийн ёроолын цэгт та хөрөнгө оруулснаар богино хугацаанд хөрөнгөө хэд дахин өсгөх боломжтой юм. Тэгвэл, 2019 оны сүүлээс эхэлсэн түүхийн эдийн үнийн уналт болон КОВИД-19 вирусээс шалтгаалан ТОП-20 индекс хүчтэй унаад байна. Тухайлбал, ТОП-20 индекс 2020 оны 4 сарын 16-ны өдрийн байдлаар оны эхнээс 15% унаад байна. Үндэсний Хувьчлалын Сан нь энхүү уналтын үед үйл ажиллагаагаа эхэлж хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь сайн компаниудын хувьцааг хямд үнээр авах боломж юм.



ГАРЧИГ

ХУСНЭГТ	12
ГРАФИК	13
СХЕМ	14
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	15
ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР	18
1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН	19
1.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТҮҮХ	19
1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ	20
1.3 ДЭЛХИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	23
2. УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА	25
2.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	25
2.2 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	27
2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ХУГАЦАА	34
2.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО	36
2.5 ТӨЛӨВЛӨГӨӨ	42
2.6 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО	50
2.7 ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, НЭГЖ ЭРХИЙН ҮНЭ	51
3. АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА	53
3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	53
3.2 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	54
3.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА	60
3.4 САНХҮҮ	60
4. ЗАХ ЗЭЭЛ	62
4.1 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ	62
4.2 МONGOL УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ	69
4.3 МONGOL УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ	76
4.4 ТОП-20 ИНДЕКС	83
4.5 МONGOL УЛСЫН ХУВЬЧЛАЛ	86
5. НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА	90
5.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА	90
5.2 НЭГЖ ЭРХИЙГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ШИЙДВЭР	90
5.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ	90
5.4 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ	91
5.5 НЭГЖ ЭРХ АРИЛЖИХ	91
5.6 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	93
6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ	94
7. ХАВСРАЛТ	100
7.1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, БҮТЭЦ	100
7.2. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ" ТУХАЙ 20/10 ТООТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ	101
7.3. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН ДУРМИЙН НАЙРУУЛГА	103
7.4. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ	118
7.5. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ, КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ	130
7.6. ARIMA ЗАГВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ	143
7.7. "ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ҮҮСГЭН БАЙГУУЛАХ" ТУХАЙ 19/05 ТООТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ	147
7.8. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ	149
7.9. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН ДҮРЭМ	151



ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Дотоод хяналтын хорооны гишүүд.....	31
Хүснэгт 2. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө	34
Хүснэгт 3. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-г үүстгэн байгуулах зардлын задаргаа.....	39
Хүснэгт 4. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалт босгохтой холбоотой зардал.....	39
Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын багцын харьцаа, өгөөж	42
Хүснэгт 6. ТОП-20 индексийн жилийн дундаж өгөөж	42
Хүснэгт 7. ТОП-20 индексийн компаниудын ногдол ашиг, тэрбум төгрөг	43
Хүснэгт 8. Хөрөнгийн хэмжээ, сая төгрөг	43
Хүснэгт 9 Хөрөнгө оруулалтаас олох орлого, сая төгрөг	44
Хүснэгт 10. Орлогын тайлан, сая төгрөг	45
Хүснэгт 11. Баланс, сая төгрөг	46
Хүснэгт 12. Харьцаа үзүүлэлтүүд	46
Хүснэгт 13. Мөнгөн хөрөнгийн тайлан, сая төгрөг	47
Хүснэгт 14. Төлөвлөгөөний боломжит хувилбарууд, 2020-2029 оны хооронд, тэрбум төгрөг ..	48
Хүснэгт 15. Ногдол ашгийн төлөвлөгөө, сая төгрөг	50
Хүснэгт 16. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	55
Хүснэгт 17. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн хөрөнгө оруулалтын хорооны гишүүд	57
Хүснэгт 18. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн дотоод хяналтын албаны гишүүд	58
Хүснэгт 19. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн ажилтан	59
Хүснэгт 20. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн баланс, аудитлагдсан, сая төгрөг	60
Хүснэгт 21. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт, сая төгрөг	61
Хүснэгт 22. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн орлогын тайлан, аудитлагдсан, сая төгрөг	61
Хүснэгт 23. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь	62
Хүснэгт 24. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, салбараар, хувь	69
Хүснэгт 25. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, түүний задаргаа, хувь	69
Хүснэгт 26. Гадаад худалдаа, сая доллар	70
Хүснэгт 27. Төлбөрийн тэнцэл, сая доллар	71
Хүснэгт 28. Улсын төсөв, тэрбум төгрөг	71
Хүснэгт 29. Мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөг	72
Хүснэгт 30. Инфляцийн бүлгүүдийн оролцооны түвшин, жилийн эцсээр	73



ГРАФИК

График 1. Дэлхийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө, их наяд доллар	23
График 2. Хөрөнгө Оруулалтын Санд хөрөнгө оруулалт хийсэн АНУ-ын өрхийн тоо, сая	24
График 3. Сангийн нийт хөрөнгө, сая төгрөг.....	51
График 4. Сангийн цэвэр хөрөнгө, сая төгрөг	52
График 5. Сангийн нэгж эрхийн үнэлгээ, төгрөг.....	52
График 6. Зэсийн үнэ, доллар/тн	65
График 7. Алтны ханш, доллар/твой унц.....	66
График 8. Нүүрсний үнэ, доллар/тн.....	66
График 9. Төмрийн хүдрийн үнэ, доллар/тн	67
График 10. Инфляци, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувь	73
График 11. Доллар болон юанийн ханш	74
График 12. Зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөг	76
График 13. Зах зээлийн үнэлгээ/ДНБ, хувь	76
График 14. ТОП-20 индекс	77
График 15. Хувьцааны арилжаа, тэрбум төгрөг	77
График 16. Зах зээлийн хөрвөх чадвар, хувь	78
График 17. Засгийн Газрын үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөг	78
График 18. Компанийн бондын арилжаа, тэрбум төгрөг	79
График 19. Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо (Монголын Хөрөнгийн Бирж)	79
График 20. Ногдол ашиг тараасан компанийн тоо болон ногдол ашигийн хэмжээ, тэрбум төгрөг	80
График 21. IPO хийсэн компанийн тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгө, тэрбум төгрөг	80
График 22. Нэмж хувьцаа гаргасан компани, татан төвлөрүүлсэн хөрөнгө, тэрбум төгрөг	81
График 23. Үнэт цаасны данс, мянган ширхэг	81
График 24. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь	82
График 25. 2010-2019 оны хоорондох жилийн өсөлт 200 өдрийн гулсах дунджаар ба дундаж өсөлт	83
График 26. ТОП-20 индексийн ирэх 10 жилийн таамаглал, 2020-2029	84
График 27. "Монгол Шуудан" ХК-ийн хувьцааны эрэлт нийлүүлэлт	86
График 28. "Монгол Шуудан" ХК-ийн хувьцааны хаалтын ханш, төгрөг	87
График 29. "Монгол Шуудан" ХК-ийн татварын дараах цэвэр ашиг, сая төгрөг	87
График 30. "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн хөрөнгө, тэрбум төгрөг	88
График 31. Төрийн банк, нийт хөрөнгө, тэрбум төгрөг	88
График 32. Олон улсын агаарын тээврийн зах зээл, мянган хүн	89





СХЕМ

Схем 1. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн бүтэц, зохион байгуулалт.....	27
Схем 2. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт.....	54
Схем 3. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц.....	54



НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хөрөнгө оруулалтын сан	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.32-т заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компаниар сангийн хөрөнгийг удирдуулж, үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой тусгай зохицуулалттай компанийг;
Хамтын хөрөнгө оруулалтын сан	Нэгж эрхээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.21-д заасны дагуу нийтэд санал болго замаар хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын санг;
Нэгж эрх	Хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийн өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;
Сангийн цэвэр актив/хөрөнгө	Сангийн цэвэр актив буюу хөрөнгө нь олон улсад NAV гэж тэмгдэглэгддэг бөгөөд Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийг хэлнэ;
Нэрлэсэн үнэ	Нэгж эрх нь хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байна.
Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн нэгж эрхийн нэрлэсэн үнийн дүнг;
Зарласан нэгж эрх	Хөрөнгө оруулалтын сангийн энгийн болон давуу эрхийн нэгж эрхийн тоог хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан нэгж эрх гэнэ.
Гаргасан нэгж эрх	Нэгж эрх эзэмшигчдэд худалдсан нэгж эрх бөгөөд энэ нэгж эрхийн хэмжээгээр хөрөнгө оруулалтын сангийн эзэмшил тодорхойлогоно.
Ногдол ашиг	Жил бүрийн цэвэр ашгийн хуваарилалт юм. Компанийн тухай хуулийн 46.1 заалтын дагуу ТУЗ нь нэгж эрх эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргадаг. Ногдол ашигийг сангийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.
Нэгж эрхийг анх удаа нийтэд санал болгох	Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авахыг анх удаа нийтэд санал болгох ажиллагааг;
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээдийг;
Хөрөнгө оруулалтын сангийн гишүүн	Хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж сангийн нэгж эрхийг эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг;
Хөрөнгө оруулалтын менежментийн компани	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасны дагуу хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний



Кастодиан	хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зохицуулалттай хуулийн этгээдийг; Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр тооцоог гүйцэтгэн хөрөнгийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг хууль болон хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийг;
Үнэт цаас	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1 зүйлд заасан санхүүгийн хэрэгслийг;
Санхүүгийн Зохицуулах Хороо	Улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.
Хувьцаа	Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ.
Энгийн хувьцаа	Саналын эрхтэй, ногдол ашиг хүртэх /ашигтай ажилласан үед/, бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгөөс давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дараа нэхэмжлэх эрхтэй гаргасан хувьцаа.
Хөрөнгө оруулалт	Ашиг олох зорилгоор үнэт цаас, эд хөрөнгө худалдан авах, эсхүл ямар нэг бараа, үйлдвэрийн тоног төхөөрөмж, байшин барилга худалдаж авах зэрэг нь хөрөнгө оруулалт болно.
Анхдагч зах зээл	Үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгон арилжих үйл явц;
Хоёрдогч зах зээл	Анхдагч зах зээлээс худалдан авсан үнэт цаасыг дахин худалдах, худалдан авч буй зах зээл;
Өрийн бичиг эсхүл бонд	Өрийн бичиг гэдэг нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа тодорхой хүүтэйгээр эргүүлэн төлөхийг амлаж байгааг баталсан үнэт цаас юм.
Нийтэд санал болгох (IPO)	Үнэт цаасны анхдагч зах зээл дээр үнэт цаас гаргагчаас үнэт цаасаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан нийтэд санал болгож худалдах ажиллагаа;
Их хэмжээний хэлцэл	Компанийн өөрийн хөрөнгийн 25.0 хувиас дээш хэмжээтэй тэнцэхүйц үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Компанийн тухай хуулийн 89.1 зүйлд заасныг ойлгоно.



Нэгж эрх эзэмшигчдийн хурал	Хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага нь Нэгж эрх эзэмшигчдийн хурал байна. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хөрөнгө оруулалтын санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.
Төлөөлөн удирдах зөвлөл	Хөрөнгө оруулалтын санг удирдлагаар хангаж, стратеги, хэтийн төлөвийг тодорхойлох, нэгж эрх эзэмшигчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх байгууллага;
Олон Улсын Валютын Сан	Олон Улсын Валютын Сан (ОУВС) нь олон улсын санхүүгийн тогтвортой байдал болон хамтын ажиллагааг дэмждэг, эдийн засгийн тогтвортой өсөлт болон ажлын байр бий болгохыг дэмжиж, дэлхий дахинаа ядуурлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг байгууллага;
Дотоодын нийт бүтээгдэхүүн	Тодорхой хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрт шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр;
M2 мөнгө	Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, төгрөг болон валютын хадгаламж, хадгаламжийн сертификатын нийлбэр;
M1 мөнгө	Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэр;
Нөөц мөнгө	Хадгаламжийн байгууллагуудын касст байгаа бэлэн мөнгө, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын Монголбанк дахь төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэр;
Зах зээлийн үнэлгээ	Хувьцаат компанийн нийт гаргасан үнэт цаасны тоо ширхгийн тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар үргүүлж гаргасан үзүүлэлт;
Индекс	Тухай индекс тооцох багцад орсон компаниудын үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлтийг;
Өгөөж	Сангийн гүйцэтгэлийн хэмжигдэхүүн бөгөөд сангийн цэвэр хөрөнгийн өсөлт бууралтаар илэрхийлэгдэнэ. Ингэхдээ Сангийн хөрөнгө оруулалтыг анх авсан үнээсээ өссөн буурсныг харуулдаг бөгөөд тухайн хөрөнгө оруулалтыг зарах хүртэл хэрэгжихгүй.





ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
IPO	Initial public offering буюу хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх
FPO	Follow on Public Offering буюу нэмэлт хувьцаа гаргах замаар дахин хөрөнгө татан төвлөрүүлэх
ГВАН	Гадаад валютын албан нөөц
НББ	Нягтлан бодох бүртгэл
Сан эсхүл Үндэсний Хувьчлалын Сан	“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
МХБ эсхүл Монголын Хөрөнгийн Бирж	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Менежментийн компани эсхүл Ард	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Менежмент	
ҮЦТХТ ХХК эсхүл Үнэт Цаасны Төвлөрсөн	“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн
Хадгаламжийн Төв	Төв” ХХК
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ОХУ	Оросын Холбооны улс
АНУ	Америкийн Нэгдсэн улс
ОУВС	Олон улсын валютын сан
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо





1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Хүмүүс ашиг орлогоо нэмэгдүүлэх, санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулах зорилгоор өндөр өгөөжтэй, эрсдэл багатай санхүүгийн хэрэгслүүдийг байнга эрэлхийлж, хөрөнгө мөнгөө өсгөхийг зорьж ирсэн билээ. Тухайлбал, зарим хүмүүс мөнгөө банкинд хадгалж, жил бүр хүү авдаг бол зарим нь хувьцаа, бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг худалдан авч, ногдол ашиг авах эсхүл ханшийн зөрүүнээс ашиг хүртэх зэргээр мөнгөө өсгөж байна. Гэхдээ хүмүүсийн мөнгөн хөрөнгөө хадгалах, түүнээс өгөөж хүртэх чиг хандлага өөрчлөгдж байна. Тухайлбал, өндөр хөгжилтэй орнуудад хүмүүс Хөрөнгө Оруулалтын Санд хөрөнгө оруулалт хийж, түүнээсээ өгөөж хүртэх чиг хандлагатай болсон. 2018 оны байдлаар АНУ-ын нийт өрхийн 43.9 хувь буюу 57.2 сая өрх **хөрөнгө оруулалтын санд** хөрөнгө оруулалт хийсэн байна. Эдгээр өрхүүдийн 93 хувь нь тэтгэврт гарахдаа санхүүгийн хувьд баталгаатай, бусдаас хараат бус байх зорилгоор хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийдэг гэсэн судалгааг Хөрөнгө Оруулалтын Компанийн Институт (Investment Company Institute) гаргажээ. Мөн гэнэтийн төлөвлөөгүй үйл явдалд эсхүл хүүхдийнхээ ирээдүйн боловсролын төлбөрийг төлөх зорилгоор ч хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийж байна. Гэтэл Монголын ард иргэд хадгаламж эсхүл хувьцаа, бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг мэддэг боловч хөрөнгө оруулалтын сангийн талаар тун цөөн хүн мэдэж байна. Иймд “Ард Менежмент УЦК” ХХК нь хөрөнгө оруулалтын сангийн талаар товч танилцуулж байгаа болно.

1.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТҮҮХ

Хөрөнгө оруулалтын сангийн үүсэл

Анх 1770 онд Европод банк, санхүүгийн хямрал болсон нь **хөрөнгө оруулалтын сангийн үүсч**, бий болох эхлэлийг тавьсан гэж үздэг. Тухайн үед 20-иод банк, хэдэн зуун компани дампуурсан бөгөөд Жентэлмэн сэтгүүлд “өнгөрсөн 50 жилд худалдаа болон санхүүгийн салбарт ийм үхлийн цохилт өгсөн хямрал болж байсныг санахгүй байна” гэж бичиж байв. Хямралд өртэж, алдагдал хүлээсэн хөрөнгө оруулагчид эрсдэл багатай, өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл хайж эхэлсэн бөгөөд Голландын худалдаачин Адриан Ван Кэтвич “Мөнгөө хэд хэдэн үнэт цаасанд тархаан байршуулах нь эрсдэлийг бууруулах боломж олгоно” гэдгийг ойлгож, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахаар шийдсэн байна. 1774 онд тэрээр анхны хөрөнгө оруулалтын сан болох Эндрагт Макт Mart (Eendragt Maakt Magt) хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулсан бөгөөд тус сангийн нэр нь “эв нэгдэл хүч чадлыг бий болгоно” гэсэн утгатай юм. Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж, уг хөрөнгөөр 50-н өөр төрлийн бондод хөрөнгө оруулалт хийсэн. Ингэснээр хөрөнгө оруулагчид бага мөнгөтэй байсан ч хамаагүй сангийн хувьцаа худалдан авснаар хөрөнгө оруулалтаа төрөлжсөн багцаар бүрдүүлэх боломжийг олгосон юм.

Орчин үеийн хөрөнгө оруулалтын сангийн эрин

Үүнээс хойш хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсч Европ болон АНУ-д ихээр дэлгэрсэн бөгөөд 1924 онд Массачусэтсийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан нь сангийн дараагийн давалгааг эхлүүлсэн байна. Тус хөрөнгө оруулалтын сан нь байгуулагдсанаасаа хойш нэг



жилийн дотор нийт хөрөнгөө 50 мянган доллараас 392 мянган доллар хүртэл өсгөж чадсанаар олон нийтийн анхаарлыг ихээр татсан байна.

Хөрөнгө оруулалтын сангийн сүүлийн үеийн хөгжил

Хөрөнгө оруулалтын сангийн сүүлийн үеийн хувьслуудыг дурдвал Индекс Сан, Арилжааны Сан (ETF буюу Exchange traded fund)-үүд юм. Тухайлбал, 1971 онд Виллям Фоус, Жонн Мак Коун нар анхны Индекс Санг байгуулсан бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын сангийн сэргэн мандалтын эрин үеийг эхлүүлсэн. Анхны индекс хөрөнгө оруулалтын сан нь Стандарт энд Пүүрс 500 (S&P 500) индекст суурилсан байсан нь туршлагагүй, мэргэжлийн бус хөрөнгө оруулагчдад бүхэл бүтэн зах зээлийн бүрдүүлж буй хувьцаанд хөрөнгө оруулах боломж олгосон юм. Индекс Сан нь санхүүгийн зах зээлийн индексийг бүрдүүлдэг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд хөрөнгө оруулалтын өгөөж нь уг индексийн гүйцэтгэлийг дагадаг онцлогтой. Домогт хөрөнгө оруулагч Варран Баффет “Индекс Сан нь амьдралын нар жаргах үеийн диваажинд зориулсан хүримтлал юм” гэж нэгэнтээ хэлж байсан билээ. Энэ ч үүднээс хувийн тэтгэврийн сангүүд ихэнх хөрөнгө оруулалтаа уг хөрөнгө оруулалтын санд хийдэг байна.

1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ

Хөрөнгө Оруулалтын Сан

Хөрөнгө оруулалтын сан нь хүмүүсийн сүл чөлөөтэй мөнгийг татан төвлөрүүлж, үнэт цаас болон бусад төрлийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх замаар ашиг орлоготой ажиллаж, түүнийхээ өгөөжийг хөрөнгө оруулагчдад хүртээдэг мэргэжлийн байгууллага юм. Хөрөнгө оруулалтын сан зүү эсхүл хэдэн мянган хөрөнгө оруулагчдын хөрөнгийг нэгтгэн ирээдүйд хурдтай өсөх томоохон үйлдвэр, бүтээн байгуулалт зэргийг санхүүжүүлдэг. Ингэснээр түүнээс бий болох ашиг, үр шимийг хөрөнгө оруулагчдад хуваарилдаг байна. Олон хүмүүс хэрэглээнээсээ илүү гарсан багахан хэмжээний мөнгө хүримтлуулах боломжтой боловч уг мөнгөөр томоохон үйлдвэр, бүтээн байгуулалт зэрэг өндөр үр ашигтай газруудад дангаараа хөрөнгө оруулалт хийх боломжгүй байдаг. Тухайлбал, та 100 төгрөгөөр хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийхэд хөрөнгө оруулалтын сан нь бусад олон хөрөнгө оруулагчдын мөнгийг нэгтгэн хувьчлагдах гэж буй томоохон компанийд хөрөнгө оруулалт хийх эсхүл өөр томоохон бүтээн байгуулалтад оролцож байдаг.

Хөрөнгө оруулалтын сангийн төрөл

Хөрөнгө оруулалтын сан нь доор дурдсан хэлбэртэй байдаг. Үүнд:

- Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан;
- Хувийн Хөрөнгө Оруулалтын Сан.

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь олон нийтээс мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлж, уг мөнгөн хөрөнгөөр хөрөнгийн биржээр арилжаалагддаг компаниудын хувьцаа, бонд зэрэг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг. Харин Хувийн хөрөнгө оруулалтын сан нь хаалттай хүрээнд мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлж түүгээрээ зөвхөн хувьцаа бонд зэрэгээс гадна алт, үл хөдлөх хөрөнгө гэх мэт олон төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийдэг.



2019 оны байдлаар дэлхийн даяар 122,538 хамтын хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн 54.8 их наяд долларын хөрөнгийг удирдаж байна. Харин Монгол Улсад “Ард Менежмент УЦК” ХХК нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн болон орон нутгийн өмчит компаниудын хувьчлалд оролцох зорилгоор 2019 онд “Үндэсний Хувьчалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулсан билээ. Тус хөрөнгө оруулалтын сан нь Монгол Улсын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан юм.

Хөрөнгө оруулалтын санг сонгох гол шалтгаан

Хөрөнгө оруулалтын сан нь бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдтэй харьцуулахад дараах давуу талуудтай:

1. Эрсдэл багатай

- Хөрөнгө оруулалтын сан нь олон төрлийн хувьцаа, бондуудад хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгө оруулалтаа төрөлжүүлж эрсдэлийг бууруулдаг.
- Хөрөнгө оруулалтын санг мэргэжлийн менежментийн баг удирдаж, холбогдох судалгаа шинжилгээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрүүд гаргадаг учир эрсдэл бага байдаг.

2. Хөрвөх чадвар сайтай

- Хөрөнгө оруулагчдын хувьд хөрвөх чадвар сайтай байх буюу яаралтай үед хөрөнгө оруулалтаа бэлэн мөнгө болгох боломж чухал байдаг. Тэгвэл хөрөнгийн биржээр дамжуулан хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд түүний нэгж эрх нь хувьцаа, бондтой нэгэн адил хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалагддаг тул хөрвөх чадвар сайтай байдаг.

3. Зардал багатай

- Хөрөнгө оруулагчид эрсдэлээ бууруулахын тулд олон төрлийн хувьцаа, бонд авдаг бөгөөд үүндээ их зардал, цаг хугацаа зарцуулдаг. Тухайлбал, хөрөнгө оруулагчид тус тусдаа бага үнийн дүнгээр хувьцаа, бонд зэргийг худалдаж авахад үнэт цаасны компанид өндөр шимтгэл төлдөг. Харин хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын сан нь эдгээр хүмүүсийн мөнгийг нэгтгэн өндөр үнийн дүнгээр хувьцаа, бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг тул илүү бага зардал гаргадаг.
- Хөрөнгийн зах зээл дээр өндөр өгөөжтэй ажиллахын тулд судалгаа шинжилгээ хийх шаардлага гардаг бөгөөд хөрөнгө оруулагчид үүнд их мөнгө, цаг хугацаа зарцуулдаг. Энэ нь ихэнх хөрөнгө оруулагчид ялангуяа жижиг хөрөнгө оруулагчдын хувьд хүндрэлтэй байдаг. Харин хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулснаар мэргэжлийн менежментийн баг судалгаа шинжилгээ хийн, хүмүүсээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийдэг билээ.



4. Татварын хөнгөлөлт: Хүмүүс хадгаламжинд мөнгөө хадгалуулсан тохиолдолд хүүгийн орлогоос 10 хувийн орлогын татвар төлдөг бол хөрөнгө оруулалтын сангаас олгож буй ногдол ашгаас 5 хувийн орлогын албан татвар төлдөг. Мөн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх худалдах, худалдан авах явцад үүсэх ханшийн зөрүүний орлогоос 5 хувийн орлогын албан татвар төлдөг.
5. Доорх хөрөнгө оруулагчдад тохиромжтой
 - Бага мөнгөөр арилжаанд ордог жижиг хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдаж авах боломжтой. Бага мөнгөөр арилжаанд ороход хөрөнгө оруулалтаа төрөлжүүлж олон төрлийн хувьцаа авахад хүндрэлтэй байдаг учир хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулсан нь илүү тохиромжтой байдаг.
 - Санхүүгийн зах зээлийн мэдлэг, туршлага байхгүй эсхүл суурь мэдлэгтэй хэдий ч судалгаа шинжилгээ хийх цаг хугацаагүй хөрөнгө оруулагчдад илүү тохиромжтой болно.

Хөрөнгө оруулалтын санд хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ

Хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулахын тулд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдаж авдаг. Нэгж эрх нь хөрөнгө оруулалтын сангийн бий болгосон орлого эсхүл капиталын ашгийг хувь тэнцүүлэн авах эрхийг гэрчилнэ. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг авч хөрөнгө оруулагч болсон тохиолдолд та нэгж эрхээ хөрөнгийн бирж дээр арилжаалах боломжтой. Нэгж эрхийн үнэ нь хөрөнгийн бирж дээр зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тогтоно.

Хөрөнгө Оруулалтын Сангийн удирдлага

Хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын мэргэшсэн менежерүүд удирдаж явуулдаг. Хөрөнгө оруулалтын менежерүүд нь санхүү, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хүмүүс байх ба тухайн сангийн хөрөнгийг зах зээлд хамгийн ашигтай бөгөөд эрсдэл багатайгаар тараан байршуулах (portfolio management), холбогдох судалгааг хийх зэрэг үйл ажиллагааг эрхлэх замаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлдэг.

Хөрөнгө оруулалтын сангийн эдийн засагт үзүүлэх нөлөө


Хөрөнгө оруулалтын сангууд бий болсноор санхүүгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчид бий болох, улмаар томоохон хөрөнгө оруулалтын эх үүсвэр дотоодын аж ахуйн нэгжүүдэд бий болох, бизнесүүд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломж нэмэгдэх, бизнесүүд өсөж томрох боломж бүрдэх, эдийн засгийн өсөлтөд тулхэц болох зэрэг макро эдийн засгийн үр өгөөж өндөр юм. Тухайлбал, Франц Улсын хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийт хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний 73.8 хувьтай тэнцдэг байна.



1.3 ДЭЛХИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2019 оны байдлаар дэлхий даяар 122,538 хөрөнгө оруулалтын сан (зохицуулалттай) 54.8 их наяд долларын хөрөнгийг удирдаж байна. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө сүүлийн 10 жилд хурдтай өсөн нэмэгдэж, бараг 2 дахин өссөн байна.

График 1. Дэлхийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө, их наяд доллар




Нийт хөрөнгийн талаас илүү хувь буюу 28.7 их наяд долларын хөрөнгийг АНУ-ын хөрөнгө оруулалтын сангүүд удирдаж байна. Үүний гол шалтгаан нь хөрөнгө оруулагчдын итгэлийг даасан хууль зүйн зохицуулалт, хөрөнгө оруулалтын сантай холбоотой татварын хөнгөлөлт, хөрөнгийн зах зээлийн өсөлт зэрэг юм.

Нөгөөтэйгүүр, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах өрх, иргэдийн тоо сүүлийн 30 гаруй жилд 11.4 дахин өсч, 57.2 сая өрх болсон талаар Хөрөнгө Оруулалтын Компанийн Институт (Investment Company Institute) мэдээлсэн байна. Энэ нь 2018 онд нийт 101.6 сая АНУ-ын иргэн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийсэн гэсэн үг юм. Энэ нь хөрөнгө оруулалтын сан хөрөнгө оруулагчдын мөнгийг мэргэжлийн түвшинд үр ашигтай удирдаж, өндөр өгөөж өгч байгаатай холбоотой юм. Тухайлбал, 2018 онд томоохон сангүүд болох БлакРок-ын уул уурхайн сан (DSP BlackRock World mining Fund) болон Эдэлвэйсийн Хятадын хувьцааны сан (Edelweiss Greater China Equity Off Shore Fund) зэрэг хөрөнгө оруулалтын сангүүд жилийн 40 орчим хувийн өгөөжийг хөрөнгө оруулагчдад өгчээ³.

³ www.economictimes.indiatimes.com



График 2. Хөрөнгө Оруулалтын Санд хөрөнгө оруулалт хийсэн АНУ-ын өрхийн тоо, сая



Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгийн зах зээл дэх хувьцаа, бондод хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгийн зах зээлийн гол тоглогчдын нэг юм. Тухайлбал, дэлхийн хөрөнгийн зах зээлийн хувьцаа болон бондын үнэлгээ 2018 онд нийтдээ 187 их наяд долларт хүрсэн бөгөөд үүний 25 хувийг хөрөнгө оруулалтын сан эзэмшиж байв. Харин үлдэх 75 хувийг төв банк, засгийн газрын сан, банк, даатгал зэрэг томоохон хөрөнгө оруулагчид эзэмшиж байна.



2. УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэр	"Ундэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын сан эсхүл "Ундэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС
Сангийн хэлбэр	Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан
Бүртгэл	<ul style="list-style-type: none"> - УБД: 9011801136 - РД: 6457983
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	<p>Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2019-8-7</p> <p>Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил</p>
Удирдлага	<ul style="list-style-type: none"> - Нэгж эрх эзэмшигчдийн хурал - Төлөөлөн удирдах зөвлөл - Гүйцэтгэх удирдлага: "Ард Менежмент УЦК" ХХК
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	"Ард Менежмент УЦК" ХХК
Хөрөнгө хадгалах компани	"Голомт Банк" ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Хаяг	<ul style="list-style-type: none"> - Монгол Улс, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн байр, 2 давхар - Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: ardmanagement.mn

"Ундэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн мэдлэг, туршлага, судалгаанд үндэслэн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгслийдэд байршуулан өсгөх зорилготой болно. Ундэсний Хувьчлалын Сан урт хугацаандаа Монгол Улсын томоохон төрийн болон орон нутгийн өмчит компани, объектуудын хувьчлалд оролцох, түүнээс өгөөж хүртэх зорилготой бол дунд хугацаандаа Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бондод хөрөнгө оруулалт хийхээр зорьж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчид нэгдэн нийлж, Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг компаниудад хөрөнгө оруулах боломж бүрдэхээс гадна түүний бүтээж буй баялагаас хувь хүртэх боломжтой болох юм.

"Ундэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм. "Ард Менежмент УЦК" ХХК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн 2019 оны 7 сарын 17-ны өдөр "Ундэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-г үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны 8 сарын 7-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа 2029 оны 8 сарын 6-ны өдрөөр дуусгавар болгоно. Сан нь үйл ажиллагаагаа 5 тэрбум төгрөгөөр эхлэх бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаандаа хөрөнгөө 20.2 тэрбум төгрөг хүртэл өсгөж



ажиллахаар төлөвлөж байна. Улмаар сангийн үйл ажиллагаа дуусгавар болоход бүх хөрөнгө оруулалтаа зарж мөнгөн хөрөнгө болгон (зардал хассан) нэгж эрх эзэмшигчдэдээ хуваарилна.

"Ундэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС нь олон нийтэд нэгж эрхээ санал болгон гаргаж, зах зээлийн үнээр худалдаалдаг, өөрийн гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдаж авах үүрэг хүлээдэггүй хаалттай хөрөнгө оруулалтын сан юм. Ундэсний Хувьчлалын Сан нь МХБ-д бүртгэлтэй бөгөөд хөрөнгө оруулагчид сангийн нэгж эрхийг үнэт цаасны компаниараа дамжуулан худалдах, худалдан авах боломжтой.

Ундэсний Хувьчлалын Сангийн нийт хөрөнгө нь 5.0 тэрбум төгрөг байх бөгөөд үүний 4.75 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлнэ. Үлдэх 250 сая төгрөгийг "Ард Менежмент УЦК" ХХК-аас хөрөнгө оруулалт хэлбэрээр хийсэн болно.

"Ард Менежмент УЦК" ХХК нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр Ундэсний Хувьчлалын Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэнэ.

"Голомт Банк"-ны кастодиан банкны хэлтэс нь хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр Ундэсний Хувьчлалын Сангийн хөрөнгийг хадгалах үйлчилгээ үзүүлнэ.




2.2 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бүтэц зохион байгуулалт

Үндэсний Хувьчлалын Сан нь засаглалын хувьд хувьцаат компанийн онцлогийг агуулсан бүтэц зохион байгуулалттай хуулийн этгээд юм. Тухайлбал, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээдэг бөгөөд нэгж эрх эзэмшигчдийн хурлаараа дамжуулан саналаа өгдөг. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу Үндэсний Хувьчлалын Сан нь ажилтан авч ажиллуулахгүй бөгөөд үндсэн үйл ажиллагаа болох хөрөнгө оруулалт хийхдээ мэргэжлийн байгууллагуудаар дамжуулан гүйцэтгүүлэх болно. Тухайлбал, "Ард Менежмент УЦК" ХХК нь Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулах, Сангийн хөрөнгийг удирдаж, хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг гүйцэтгэх бол "Голомт Банк"-ны кастодиан банкны хэлтэс нь Сангийн хөрөнгийг хадгалах үйл ажиллагааг холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх болно.

Схем 1. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн бүтэц, зохион байгуулалт



Нэгж эрх эзэмшигчдийн хурал

"Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн эрх барих дээд байгууллага нь нэгж эрх эзэмшигчдийн хурал бөгөөд уг хурал нь Сангийн онцгой шийдвэрийг гаргахад оролцох, Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох зэрэг боломжуудыг нэгж эрх эзэмшигчдэд олгодог болно. "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Сангийн дүрмээр тодорхойлсон бөгөөд уг дүрэмд доорх бүрэн эрхийг тусгасан байна. Үүнд:

- Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Сангийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- Санг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;
- Сангийн өрийг нэгж эрхээр солих, нэмж гаргах нэгж эрхийн тоог тогтоох;



- Сангийн нэгж эрхийг хуваах болон нэгтгэх;
- Санг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй их хэмжээний хэлцлийг батлах;
- Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн болон менежментийн компанийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ-аас оруулсан асуудлууд;
- Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль бусад холобгдох журам заасан бусад асуудлууд.

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал нь санхүүгийн жил дууссанаас хойш хуульд заасан хугацаанд жилд нэг удаа хуралдах бөгөөд нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, шийдвэр гаргахтай холбоотой харилцаанд Компанийн тухай хуулийн холбогдох заалт нэг адил үйлчилнэ. Сангийн нэгж эрхийн 50-аас дээш хувийг эзэмшиж буй нэгж эрх эзэмшигчид нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэгж эрх тус бүр нэг саналын эрхтэй байх бөгөөд нэгж эрх эзэмшигчийн саналын эрх нь нэгж эрх эзэмшигчийн өмчлөл, эзэмшил дэх нийт нэгж эрхийн тоогоор тодорхойлогдоно.

Төлөөлөн удирдах зөвлөл

Сангийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь хамтын удирдлага бүхий бүтэц бөгөөд Сангийн гишүүдийн хурлын чөлөөт цагт Сангийн эрх барих дээд байгууллага юм. Төлөөлөн удирдах зөвлөл нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, Санг үр ашигтай шийдвэр гаргах, Сангийн үйл ажиллагааг хянах, стратегийг тодорхойлж ажилладаг болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд өөрийн үйл ажиллагааг зохицуулсан журамтай байна.

Үндэсний Хувьчлалын Сангийн ТУЗ-ийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийг үндэслэн Сангийн дүрмээр тодорхойлсон болно. Үүнд:

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах;
- Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
- Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан гүйцэтгэх удирдлагын дүгнэлтийг хэлэлцэх;
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
- Сангийн аудиторыг сонгох, гэрээний нөхцлийг тогтоох;



- Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Санг нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах талаар сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Сангийн дотоод хяналтын хорооны гишүүдийг томилох;
- Дүрэмд заасан зарласан нэгж эрхийн тоонд багтаан нэгж эрх гаргах;
- Дүрэм болон Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулга болон итгэмжлэн удирдах гэрээнд тусгагдаагүй зардлыг гаргах зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн Зохицуулах Хорооны журамд заасан бусад асуудлууд.

Ундэсний Хувьчлалын Сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд гишүүд нь банк, даатгал, үнэт цаас зэрэг санхүүгийн салбарт ажиллаж байсан арвин туршлага, өндөр чадвартай болно.



Чулүүны Ганхуяг

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Эдийн засагч, банк санхүүгийн менежмент

Давхар албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн,
Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга

Ч.Ганхуяг нь 1991 онд Монголын Хөрөнгийн Биржээс хөдөлмөрийн гараагаа эхэлсэн бөгөөд 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэж, Монголбанкинд хянан шалгагчаар орсон. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр санхүүгийн менежерээр ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан гүйцэтгэх захираар нь томилогдсон. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсан бөгөөд 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн Хас Банк байгуулагдсан юм. Ганхуяг нь Хас Банкийг байгуулагдсан цагаас нь хойш 2009 оныг хүртэл гүйцэтгэх захираа ажилласан бөгөөд 2009-2010 онд Хас Банкны толгой компани болох “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал байжээ. 2010-2012 онд Монгол Улсын Сангийн дэд сайдын албанд томилогдон ажилласан байна.

Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Монголын Оюутны Холбооны ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны ерөнхийлөгч зэрэг албан тушаал хashiж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж, “СИДАН” ХХХ-ны удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг дэлхийн залуу манлайлагчаар өргөмжилсөн байна.





Галбадрахын Цогбадрах

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Давхар албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Г.Цогбадрах нь 1997 онд Монгол Улсын Их Сургуулийг банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд ажлын гараагаа суралцаж байх хугацаандaa буюу 1996 онд Голомт Банкинд ажиллаж эхлүүлсэн байна. Тэрээр 2000 оноос Хас Банкны санхүү, дотоод аудит, салбарын удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар тус тус ажиллаж байгаад 2009-2010 онд АНУ-ын Үндэсний Их Сургуульд бизнес удирдлага мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. 2010 онд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2011 оноос 2014 оны хооронд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажилласан. 2016 оноос “Ард Даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Батбилэгийн Золбоо

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Эдийн засагч

Давхар албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн санхүү эрхэлсэн захирал, “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Б.Золбоо нь 2012 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд олон улсын нягтлан бодогч мэргэжлээр сурч байгаад 2013-2016 онд АНУ-ын Платсбург Коллеж (Plattsburgh college)-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. 2016-2017 онд “Ард Секюритиз УЦК” ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээч, 2017 оноос “Ард Менежмент УЦК”-ХХК-ийн ўйл ажиллагаа хариуцсан захирлаар тус тус ажиллаж байгаад 2019 оноос “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-д санхүү хариуцсан захирлаар ажиллаж эхэлсэн байна.



Пүрзэвийн Баянсан

“Үндэсний Хувьчлалын Сан” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Давхар албан тушаал: “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, МУИС-ийн Бизнесийн Сургуульд ахлах багш

П.Баянсан нь 1995-1999 онд бизнесийн удирдлагын бакалавр, 1999-2001 онд бизнесийн удирдлагын магистр, 2004 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд “Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулагчдын бүтцийг оновчлох асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Одоо Монголын Хөрөнгийн Биржид ТУЗ-ийн хараат бус гишүүн, Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Бизнесийн Сургуульд санхүүгийн тэнхимийн ахлах багшаар ажиллаж байна.





Баяраагийн Баасандорж

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн ТҮЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Эрх зүйч

Давхар албан тушаал: “Батбаяр Энд Партнэрс” ХХН-д өмгөөлөгч

Б.Баасандорж нь 2005-2010 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийг олон улсын эрх зүйч, 2012-2015 онд БНХАУ-ын Төв Хятадын Хууль Зүйн Сургуулийг хууль зүйн магистраар төгссөн. Ажлын туршлагын хувьд 2010-2011 оны хооронд “Энержи Ресурс” ХХК-д хуулийн мэргэжилтэн, 2013 оноос одоог хүртэл өмгөөллийн “Батбаяр энд Партнэрс” ХХН-д өмгөөлөгчөөр ажиллаж байна.

Дотоод хяналтын хороо

Дотоод хяналтын хороо (цаашид ДХХ гэх) нь Сангийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд явж байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагаагаа ТҮЗ-д тайлагнадаг, өөрийн үйл ажиллагааны журамтай нэгж юм. Тус нэгж нь ээлжит болон ээлжит бус шалгалтыг Сангийн санхүү, хөрөнгийн удирдлага, дотоод үйл ажиллагаа гэсэн чиглэлээр тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг. ДХХ нь З гишүүнтэй бөгөөд гишүүдийн нэг нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр ажилладаг туршлагатай болно.

Хүснэгт 1. Дотоод хяналтын хорооны гишүүд

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил	Дотоод аудиторын гэрчилгээ
1.	М.Мөнх Эрдэнэ	ДХХ-ны дарга	Санхүү, НББ	No.15063570
2.	Б. Баасандорж	ДХХ-ны гишүүн	Хуульч, өмгөөлөгч	
3.	Б. Оюутцэцэн	ДХХ-ны гишүүн	Санхүү, нягтлан бодогч	

ДХХ-ны дарга Мөнхбатын Мөнх-Эрдэнэ

М.Мөнх-Эрдэнэ нь Мандах Бүртгэл Их Сургуулийг 2011 онд банк, санхүү, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2011-2012 онд “АПУ” ХК-д нягтлан бодогч, 2012-2014 онд “Хүлэгт Хүннү Аудит” ХХК-д туслах аудит, 2016 оноос хойш “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн дотоод аудитороор ажиллаж байна. 2015 онд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх, 2015 онд татварын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх, 2019 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттээс аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрх бүхий аудиторын гэрчилгээ авсан болно.

ДХХ-ны гишүүн Баяраагийн Баасандорж

Б.Баасандорж нь 2005-2010 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийг олон улсын эрх зүйч, 2012-2015 онд БНХАУ-ын Төв Хятадын Хууль Зүйн Сургуулийг хууль зүйн магистраар төгссөн. Ажлын туршлагын хувьд 2010-2011 оны хооронд “Энержи Ресурс” ХХК-д



хуулийн мэргэжилтэн, 2013 оноос одоог хүртэл өмгөөллийн “Батбаяр энд Партиэрс” ХХН-д өмгөөлөгчөөр ажиллаж байна.

ДХХ-ны гишүүн: Баярсайханы Оюутцэцэн

Б.Оюутцэцэн нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг 2016 онд бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөний дараа Их Британий Лондон хотод ВРР Их Сургуульд магистрын зэргээ санхүү, нягтлан бодох бүртгэлээр хамгаалсан. 2018 онд АССА буюу Олон Улсын Мэргэшсэн Няглан Бодогчийн шалгууруудыг хангаж АССА зэргийг хүртсэн. 2018-2019 онд Голомт Банкны нөөцийн удирдлагын газарт дилерээр ажиллаж байсан ба 2020 оны 3 сараас “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-д эрсдэлийн менежерээр ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлага

“Ард Менежмент УЦК” ХХК нь “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Ард Менежмент нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр доорх үйл ажиллагааг санд үзүүлнэ. Үүнд:

- Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, оффис, хүний нөөц, харилцаа холбоогоор хангах;
- Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу Сангийн хөрөнгийг удирдаж, хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах, хөрөнгө оруулалт худалдах, худалдан авах;
- Санг төлөөлөх, бусадтай гэрээ байгуулах, Сангийн хөрөнгийг захиран зарцуулах хэлцэл хийх;
- Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тусгасан зардлыг Сангийн хөрөнгөөс гаргаж зардлыг төлөх;
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах;
- Шаардлагатай бол ТҮЗ-ийн ээлжит бүс хурлыг зарлан хуралдуулах;
- Санг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох;
- Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл тайлан бэлтгэх;
- Сангийн хөрөнгийг тусгаарлаж, Сангийн нэр дээр нээсэн тусдаа дансанд байршуулж, эрх бүхий Кастодиан банкинд хадгалуулах;
- Сангийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнах;
- Сантай байгуулсан гэрээнд тусгасан нөхцлийн дагуу нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах;
- Сангийн үйл ажиллагааг дуусгавар болгосон өдрөөс эхлэн Сангийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах, Сангийн хөрөнгийг хууль журмын хүрээнд нэгж эрх эзэмшигчдэд хуваарилах;
- Сангийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх;
- Сангийн нэгж эрхийн бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалуулах ажлыг зохион байгуулах;





- Сангийн зар сурталчилгаа болон Сангийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх зэрэг маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тусган бусад асуудал.

Хавсралтаар Ард Менежмент болон Сангийн хороонд 2020 оны 6 сарын 2-ны өдөр байгуулсан 20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг оруулсан болно. Та Санд хөрөнгө оруулалт хийхэс өмнө Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээтэй сайтар танилцана уу.

“Ард Менежмент УЦК” ХХК-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Кастодиан

Голомт Банкны кастодиан банкны хэлтэс нь 2015 оны 9 сарын 24-ний өдөр албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн, харилцагчийн үнэт цаас, санхүүгийн бусад хөрөнгийг найдвартай хадгалж, өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасны төлбөр тооцоо, компанийн үйл ажиллагаа, орлого цуглуулалт, татварын тооцоолол зэрэг хөрөнгийн зах зээлийн арилжааны дараах мэргэшсэн цогц үйлчилгээг бүрэн хэмжээгээр үзүүлж ажилладаг компани болно.

Тус кастодиан нь доорх үйлчилгээг Санд үзүүлэх болно. Үүнд:

- Сангийн хөрөнгийг хадгалах;
- Нэгж эрхийн цэвэр үнэ цэнийг тооцох;
- Тайлан мэдээ гаргах.
- Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээнд заасан бусад;

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 12-1, Очир төв, 503 тоот, Улаанбаатар 14220,

Монгол Улс

Утас: 7011 1646 /1401/

И-мэйл: custody@golomtbank.com

Хавсралтаар Голомт банк болон Сангийн хороонд 2020 оны 6 сарын 9-ны өдөр байгуулсан 2020/12 тоот Хөрөнгө хадгалах кастодианы үйлчилгээний гэрээг оруулсан болно. Та Санд хөрөнгө оруулалт хийхэс өмнө Хөрөнгө хадгалах кастодианы үйлчилгээний гэрээтэй сайтар танилцана уу.



2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ХУГАЦАА

Хөрөнгө оруулалтын сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тусгай зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үүнтэй холбоотойгоор Санг үүсгэн байгуулж, үйл ажиллагаа эхлүүлэхдэд хэд хэдэн шат дараатай үйл ажиллагааг хууль журмын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүнд:

- Санг үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн үлсын бүртгэлд бүртгүүлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж, Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах, нийтээс хөрөнгө төвлөрүүлэх;
- Сангийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авах, уг сангийн үйл ажиллагааг эхлэх.

Санг үүсгэн байгуулах ажлын хүрээнд үүсгэн байгуулах бичиг баримтыг хууль журмын хүрээнд боловсруулах, холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай бөгөөд Ард Менежмент нь Үндэсний Хувьчлалын Сангийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой доорх шат дараатай үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна.

Хүснэгт 2. “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө

	2018 1-12	2019 1-6	2019 7-12	2020			
				1	2	3	4
Бичиг баримт боловсруулах	Бичиг баримт бэлтгэх СЗХ-нд бүртгүүлэх						
Үүсгэн байгуулах	Үүсгэн байгуулах УБЕГ-т бүртгүүлэх						
	Хамтран ажиллах гэрээ						
Нэгж эрхийг бүртгүүлж, хөрөнгө татах	Нэгж эрхийн танилцуулга СЗХ, МХБ-д бүртгүүлэх						
	Санг танилцуулж, хөрөнгө татах						
Үйл ажиллагаа эхлүүлэх	СЗХ-ноос зөвшөөрөл Сангийн ү.а-г эхлүүлэх						

Бичиг баримт боловсруулах

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтад “Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэнэ.” гэж заасан байдаг бөгөөд үүний дагуу “Ард Менежмент УЦК” ХХК нь Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулах бичиг баримтыг 2018 онд боловсруулсан бол “Батбаяр энд Партерс” ХХН нь Үндэсний Хувьчлалын Сангийн холбогдох дүрэм, журмыг хуульд нийцүүлэн боловсруулсан. “Ард Менежмент УЦК” ХХК нь “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-г үүсгэн байгуулах бичиг баримтыг 2019 оны 7 сарын 8-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн билээ.



Үүсгэн байгуулах

Ард Менежмент нь 2019 оны 7 сарын 17-ны өдөр төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаа хийж, уг хурлаараа “Үндэсний Хувчалалын Сан” хамтын ХОС-г үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн. “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТУЗ-ийн 19/05 тоот тогтоол, СЗХ-ны 192 тоот тогтоолыг үндэслэн “Үндэсний Хувчалалын Сан” хамтын ХОС-г 2019 оны 8 сарын 7-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, албан ёсоор үүсгэн байгуулсан байна.

Нэгж эрхийг бүртгүүлж, хөрөнгө татах

Ард Менежмент нь Үндэсний Хувчалалын Сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулсан бөгөөд уг танилцуулгыг 2020 оны нэгдүгээр улиралд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэхээр зорьж байна. Энэхүү ажлын хүрээнд доорх багц ажлыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- Нэгж эрхийн танилцуулгыг боловсруулах;
- Нэгж эрхийг СЗХ болон МХБ-д бүртгүүлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулж, МХБ-ээр дамжуулан нэгж эрхийг арилжаалах;

Үндэсний Хувчалалын Сан нь 2020 оны 5 сараас албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөөд байгаа бөгөөд холбогдох байгууллагуудын бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдон үйл ажиллагаа эхлэх хугацаа хойшлох боломжтой.





2.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийнэ. Хөрөнгө оруулалтын бодлого нь Сангийн зорилго, хөрөнгө оруулалт хийх хэрэгсэл, түүнд тавих хязгаарлалт, Сангийн хөрөнгөд тавигдах шаардлага зэрэг мэдээллийг тусгасан бодлогын бичиг баримт юм.

Зорилго

- Улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчit компаниудын хувьчлалд оролцож, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үнэлгээг өсгөх замаар урт хугацаанд өгөөж хүртэх;
- Дунд хугацаанд Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа, бондод хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх;
- Мөнгөн урсгал, хөрвөх чадварыг тогтвортой байлгаж, эрсдэлийг багасгахын тулд засгийн газрын үнэт цаас, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийн өгөөж хүртэх.

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл

Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулах замаар хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэх болно. Үүнд:

- Засгийн газрын өрийн хэрэгсэл;
- Аймаг нийслэлийн засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
- Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.

Үндэсний Хувьчлалын Сан нь зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг холбогдох хууль журамд тусгагдсан бусад хэрэгслүүдэд хөрөнгө оруулж болно.

Хөрөнгө оруулалтын бодлого

Үндэсний Хувьчлалын Сан нь Сангийн нийт хөрөнгийн 70 хүртэл хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийх болно. Сан нь хөрөнгө оруулалт хийхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах болно. Хувьцаанд хөрөнгө оруулалт хийхдээ Монгол Улсын эдийн засгийн гол тоглогч, бүрдүүлэгч компанийн хувьчлалд оролцох эсхүл Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн төрөл (өсөлттэй, бодит үнэ цэнээс бага үнэлэгдсэн, холимог), зах зээлийн үнэлгээ (өндөр, бага), мөнгөн урсгалын тогтвортой байдал, хүлээгдэж буй өсөлт зэрэг шалгуур үзүүлэлтүүдээс тухайн компани, салбарт тохирох шалгууруудыг харгалзан үзэж, хөрөнгө оруулалт хийх болно. Мөн хөрөнгө оруулалтын





менежерүүд нь компанийн засаглал, татварын бодлого, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зэрэг компанийн мөнгөн үргалд нөлөөлөх хүчин зүйлст гол анхаарлаа хандуулж ажиллах болно. Ингэснээр урт хугацаанд тогтвортой өсөлт авчрах компанид хөрөнгө оруулалт хийх бололцоо бүрдэх юм.

Боломжит хөрөнгө оруулагчид

Сангийн хөрөнгө оруулалт хийх бүтээгдэхүүн нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй өргөн цар хүрээтэй хувьцаа, бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэл байх юм. Сан нь дунд болон урт хугацаанд өгөөж хүртэх зорилготойгоор судалгаа шинжилгээнд үндэслэн хэд хэдэн салбарт хөрөнгө оруулалт хийх тул урт хугацааны капиталын өсөлтийг бий болгох эсхүл банкны хүйтэй харьцуулахад өндөр өгөөж бий болгох зорилготой хөрөнгө оруулагч нарт тохиромжтой.

Үндэсний Хувьчлалын Сан нь санхүүгийн зах зээлийн мэдлэг, туршлага байхгүй эсхүл суурь мэдлэгтэй хэдий ч судалгаа шинжилгээ хийх боломжгүй хөрөнгө оруулагчдад илүү тохиромжтой болно. Сан нь урт хугацаанд капиталын өсөлтийг бий болгох, банкны хүүнээс өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх зорилготой тул хөрөнгө оруулагчид өөрсдийн зорилготойгоо уялдаж байгаа эсэхийг нягталсны үндсэн дээр Санд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй гэж зөвлөж байна. Үндэсний Хувьчлалын Сангийн хөрөнгө оруулалт хийх хэрэгслүүд нь Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл байх бөгөөд мэргэжлийн судлаачдын судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалтын багцаа хэд хэдэн салбараас бүрдүүлэх тул эрсдэлээ тархаан байршуулах болно. Ингэснээр Сан нь нэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, судалгаа шинжилгээгүй хөрөнгө оруулалт хийх нь ямагт эрсдэлтэй байдаг тул хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгө оруулалтын зорилгоо Сангийн зорилготой үялдуулан эрсдэл даах чадвараа тооцоолсны үндсэн дээр Санд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй юм.

Сан нь доорх хөрөнгө оруулагчдад илүү тохиромжтой болно. Үүнд:

- Төрийн өмчийн хувьчлалд оролцон хөрөнгө оруулалт хийх сонирхолтой;
- Урт болон дунд хугацаанд эрсдэл даах чадвартай хөрөнгө оруулагч;
- Урт хугацаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой;
- Урт хугацааны хөрөнгийн өсөлт сонирхож байгаа;

Хязгаарлалт

Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг СЗХ-оос тогтоодог бөгөөд Үндэсний Хувьчлалын Сан нь уг хууль, эрх зүйн нийтлэг шаардлагад нийцүүлэн ажиллана. Үүнд:

- Өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн хэмжээ нь Сангийн нийт активын 70%-аас хэтрэхгүй байна.
- Эдийн засгийн нэг салбарт хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар нь Сангийн нийт активын 25%-аас хэтрэхгүй байна.



- Нэг компанийн хувьцааны 10-аас дээш хувийг дангаараа эзэмшихгүй байна.
- Компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эсхүл зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг бусад хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийнэ.

Судалгаа

Ард Менежмент нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр Сангийн хөрөнгө оруулалтыг хийх бөгөөд аливаа хөрөнгө оруулалт хийхдээ түүнд тохирох судалгаа шинжилгээний аргыг ашиглах, боловсруулах болно. Үүнд:

Top-down шинжилгээ

Энэхүү арга нь жижиг, нарийвчилсан бүрэлдэхүүнд анхаарал хандуулахаас илүүтэй эхлээд том зургийг харахыг хичээдэг шинжилгээ юм. Энэхүү шинжилгээний арга нь ерөнхий судалгаанаас нарийвчилсан судалгаа руу шилжиж судалдаг шинжилгээний арга юм. Тухайлбал, эдийн засаг, салбар, компани гэсэн дарааллаар шинжилгээг явуулдаг байна.

Bottom-up шинжилгээ

Энэхүү шинжилгээний арга нь тухайлсан хувьцаа болон компанийн тоон шинжилгээнд сууриссан арга юм.

Суурь шинжилгээ

Энэхүү судалгаа нь компанийн ирээдүйд олох ашиг орлогын өөрчлөлтийг урьдчилан таамаглахын тулд эдийн засгийн шинжилгээ болон үнэлгээний хувьсагчуудыг ашигладаг.

Дээрх судалгаа, шинжилгээг Ард Менежментийн мэргэшсэн туршлагатай, мэргэжлийн ёс зүйтэй хөрөнгө оруулалтын менежерүүд хийхээс гадна үнэт цаасны зах зээлд мэргэшсэн компаниудын судалгааг ашиглах юм.

Зардал, шимтгэл

Сан нь хөрөнгө итгэмжлэн удирдах, хөрөнгө хадгалах, үнэт цаас арилжаалах, нягтлан бодох бүртгэл зэрэг үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор доорх зардлууд гарна гэж төлөвлөж байна. Ард Менежмент нь Сангийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой гарах болон гарч болзошгүй зардлуудыг багцлан доор дурдсан боловч дутуу орхигдуулсан, дурдаагүй гэнэтийн зайлшгүй зардал байх боломжтой юм. Үүнд:

- Үүсгэн байгуулах зардал;
- Хөрөнгө босгохтой холбоотой зардал;
- Менежментийн үйлчилгээний зардал;
- Кастводианы үйлчилгээний зардал;
- Арилжаа эрхлэх байгууллагын үйлчилгээний хөлс;
- Аудитын хөлс;
- Үнэт цаасны компанийн шимтгэл;
- Бусад зардал.



Үүсгэн байгуулах зардал: Хөрөнгө оруулалтын сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тусгай зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үүнтэй холбоотойгоор Санг үүсгэн байгуулж, үйл ажиллагаа эхлүүлэхэд хэд хэдэн шат дараатай үйл ажиллагааг хууль журмын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:

- Санг үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж СЗХ-нд бүртгүүлэх;
- Сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах, нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх;
- Сангийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авах, уг сангийн үйл ажиллагааг эхлэх.

Санг үүсгэн байгуулах ажлын хүрээнд үүсгэн байгуулах бичиг баримтыг хууль журмын хүрээнд боловсруулах, холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай бөгөөд “Ард Менежмент УЦК” ХХК нь энэхүү үйл ажиллагааг 2018 оноос хойш хэрэгжүүлж, 2019 оны 8 сард “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ыг албан ёсоор үүсгэн байгуулсан юм. “Ард Менежмент УЦК” ХХК нь энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор 40 сая төгрөгийн зардал тооцсон ба Сан нь уг зардлыг нөхөж олгоно.

Хүснэгт 3. “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-г үүсгэн байгуулах зардлын задаргаа

Үйл ажиллагаа	Үнийн дүн (сая төгрөг)
Ерөнхий бичиг баримт боловсруулах	27.8
Санг үүсгэн байгуулах хурал зохион байгуулах	1.0
СЗХ-д бүртгүүлэх	0.2
Хамтрагч байгууллагуудтай холбогдох гэрээг байгуулах	11.0
Санг хуулийн этгээдэд бүртгүүлэх	0.0
Санг үүсгэн байгуулах нийт зардал	40.0

Хөрөнгө оруулалт босгохтой холбоотой зардал: “Ард Менежмент УЦК” ХХК нь Сангийн нэгж эрхийг бүртгүүлэх, хөрөнгө оруулалт босгохтой холбоотойгоор доорх багц ажлуудыг хийх бөгөөд үүнтэй холбоотойгоор 309.5 сая төгрөгийн зардал гарахаар төлөвлөсөн байна. Энэхүү зардал нь нэг удаа гарах зардал юм.

Хүснэгт 4. “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалт босгохтой холбоотой зардал

Үйл ажиллагаа	Үнийн дүн (сая төгрөг)
Нэгж эрхийн танилцуулга боловсруулах	20.0
Нэгж эрхийн танилцуулгыг Арилжаа эрхлэх байгууллагад хянуулах	2.0
Нэгж эрхийн танилцуулгыг Арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх	50.0
Нэгж эрхийг нийтэд танилцуулах, хөрөнгө татан төвлөрүүлэх	237.5
Сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах	0.0
Сангийн нэгж эрх бүртгүүлэх	309.5





Менежментийн үйлчилгээний зардал: “Ард Менежмент УЦК” ХХК нь Сангийн үйл ажиллагааг эрхэлж, хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд үүнтэй холбоотой үйлчилгээний төлбөрийг жил бүр Сангаас төлнө. Энэхүү зардал нь Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, нягтлан бodoх бүртгэлийг хөтлөх, мэдээ, тайланг СЗХ болон гишүүдэд цаг тухайд нь мэдээлэх, бичиг баримт боловсруулах зэрэг Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой гарч буй зардлыг санхүүжүүлэх ба Сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн дундаж үлдэгдлийн 2.5 хувьтай тэнцүү байна. “Ард Менежмент УЦК” ХХК нь ХОС-ийн активын үлдэгдэл болон менежментийн зардлын хэмжээг өдөр бүр тооцож гаргах бөгөөд сар бүр ХОС-оос нэхэмжлэн авна. “Ард Менежмент УЦК” ХХК нь Сангийн хөрөнгийн бүртгэлийг нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөх болно. Мөн хэрэв Сангийн гүйцэтгэл нь энэхүү нэгж эрхийн танилцуулгад тусгасан зорилтот хэмжээ буюу төлөвлөгөөнд тусгасан ашгаас давсан ашигтай гарсан тохиолдолд гүйцэтгэлийн урамшууллыг Ард Менежментэд олгох бөгөөд энэ нь зорилтот хэмжээнээс давсан нийт ашгийн 20 хувь байна.

Кастодианы үйлчилгээний зардал: Голомт банкны Кастодианын банкны хэлтэс нь Сангийн хөрөнгийг хадгалж, төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбоотойгоор Сан нь Кастодиан банкинд үйлчилгээний хэлс жил бүр төлнө. Энэхүү хэлс нь Сангийн тухайн жилийн хөрөнгийн 0.35 хүртэл хувьтай тэнцүү байна. Хадгалах үйлчилгээний шимтгэлийг өдөр бүрийн эцэст нийт хадгалж буй хөрөнгийн үнэлгээнээс хуримтуулан тооцно. Энэхүү хэлс нь Сангийн хөрөнгийг тухайн Сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгийн үнэлгээг тооцох, Сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг мэдэгдэхтэй холбоотой үйл ажиллагааны зардал юм. Үүнээс гадна Кастодиан банкнаас нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэл хөтлөх болон бусад нэмэлт үйлчилгээнүүд үзүүлэх боломжтой.

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын үйлчилгээний хэлс: Сан нь Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бөгөөд Арилжаа эрхлэх байгууллага нь Сангийн нэгж эрхийг худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нэхцлийг бүрдүүлэх, нэгж эрхийн арилжааг зохион байгуулах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд жил бүр үйлчилгээний хэлс авах болно. Энэхүү хэлс нь Сангийн нийт зах зээлийн үнэлгээний 0.1 хувьтай тэнцүү байна.

Аудитын хэлс: Сан нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг сарын дотор СЗХ-нд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулах бөгөөд жил бүр нягтлан бodoх бүртгэлийн тухай хуульд заасны дагуу аудит хийлгэх болно. Сан нь аудитын компанийн ажлын хэлсийг төлнө.

Үнэт цаасны компанийн шимтгэл: Сангийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт хийх буюу үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааны шимтгэлийн хэлс дунджаар үнэт цаасны арилжааны 0.8 хувьтай тэнцүү байхаар төлөвлөсөн. Энэ зардал нь зах зээлийн нэхцэл байдал, харилцагч компанийн байр суурь зэргээс үүдэн өөрчлөгдөх боломжтой болно.



Бусад зардал: Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах ажлын хүрээнд Санг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хариуцагчаар оролцох эрхтэй тул уг үйл ажиллагаатай холбоотой аливаа шаардлага гарсан тохиолдолд хууль зүйн зөвлөгөө авах шаардлага үүсэх боломжтой юм. Энэхүү үйлчилгээ болон бусад дурдаагүй боловч гарах боломжтой үйл ажиллагаатай холбоотой гарч болох зардлыг бусад зардал гэж үзсэн болно. Уг зардал нь Сангийн нийт активын 0.5 хувьтэй тэнцүү байхаар төлөвлөсөн болно.



2.5 ТӨЛӨВЛӨГӨӨ

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын дагуу холбогдох хязгаарын хүрээнд нийт хөрөнгийн 70 хүртэл хувийг нээлттэй хувьцаат компанийн хувьцаанд, 25 хүртэл хувийг зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг өрийн хэрэгсэл буюу бондод хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. Нийт хөрөнгийн үлдэх хувь буюу 5 хувийг мөнгөн хөрөнгө хэлбэрээр хадгалахаар төлөвлөж байна.

Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын багцын харьцаа, өгөөж

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл	Нийт хөрөнгөд эзлэх хувь	Түүхэн өгөөж
Нээлттэй ХК-ийн хувьцаа	70%	22.9%
Өрийн хэрэгсэл	25%	14.4%
Мөнгө	5%	3.5%

Сан нь судалгаа шинжилгээнд тулгуурлан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтад тусгасан бусад хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжтой бөгөөд энэхүү тооцоололд тусгаагүй болно. Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн багцад эзлэх хувь хэмжээ нь зах зээлийн нөхцөл байдал, өгөөж, эрсдэл зэрэг хүчин зүйлсээс үүдэн өөрчлөгдөж болох хэдий ч Сангийн нийт хөрөнгийн нээлттэй зах зээлд арилжаалагддаг хувьцаанд оруулах дээд хязгаар нь 70 хүртэл хувь байхаар зохицуулсан хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтыг баримтлах болно. Мөн энэхүү төлөвлөгөөнд зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг өрийн хэрэгсэлд Сангийн нийт хөрөнгийн 25 хувийг оруулахаар төлөвлөсөн хэдий ч энэхүү хөрөнгө оруулалтын хувь хэмжээ нь зах зээлийн нөхцөл байдал, өрийн хэрэгслийн өгөөж, өрийн хэрэгсэл зах зээл дээр арилжаалагдах эсэх зэргээс хамаарч өөрчлөгдхөж боломжтой.

Сангийн хөрөнгө оруулалт хийх хэрэгслүүдийн хувьд хувьцааны жилийн дундаж өгөөж 22.9 хувь, бонд буюу өрийн хэрэгслийн жилийн дундаж өгөөж 14.4 хувь, мөнгөн хөрөнгийн харилцахын жилийн хүү 3.5 хувь байхаар тооцооллоо. Хувьцааны жилийн өгөөжийг тооцохдоо Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй ТОП-20 индексийн сүүлийн 15, 10, 5 гэсэн жилүүдийн түүхэн өгөгдөл дээр үндэслэн ханшийн өөрчлөлтийг тооцоолсон болно.

Хүснэгт 6. ТОП-20 индексийн жилийн дундаж өгөөж

	2005-2019	2010-2019	2015-2019
Дундаж өгөөж	54.3%	22.9%	8.8%
Хамгийн өндөр	970.5%	378.6%	123.8%
Хамгийн бага	-65.0%	-35.5%	-23.9%

Жилийн өгөөжийг тооцохдоо арилжааны өдөр бүрийн ТОП-20 индексийн ханшийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулан гаргасан. ТОП-20 индекс 2005-2019 оны хооронд жилд дунджаар 54.3 хувь, 2010-2019 оны хооронд жилд дунджаар 22.9 хувь, 2015-2019 оны хооронд жилд дунджаар 8.8 хувиар тус тус өссөн байна. Бид сүүлийн 10 жилийн ТОП-20 индексийн өгөөжийг илүү бодитой гэж үзэн санхүүгийн тооцоололдоо ашигласан юм.



Зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг өрийн хэрэгслийн өгөөжийн хувьд 2017 оны 11 сард арилжаалагдсан 52 долоо хоногийн хугацаатай Засгийн Газрын Үнэт Цаасны өгөөж болон 2018 онд гарсан “Минжпроперти” ХХК-ийн Парк Таун бондын өгөөжүүдийг тус тус ашиглалаа. Мөн санхүүгийн тооцоололд хувьцааны хөрөнгө оруулалтаас орж ирэх ногдол ашгийн хувийг оруулж тооцсон. Ингэхдээ ТОП-20 индекст багтдаг 20 компанийн ногдол ашгийг зах зээлийн үнэлгээнд нь харьцуулахад 2018 онд 5.3 хувь, 2019 онд 6.9 хувийн ногдол ашиг тараасан эсхүл зарласан байсан бөгөөд бид сүүлийн 2 жилийн дундаж болох 6.1 хувийг санхүүгийн тооцоололдоо ашигласан.

Хүснэгт 7. ТОП-20 индексийн компаниудын ногдол ашиг, тэрбум төгрөг

	2018	2019	Дундаж
Нийт ногдол ашиг	103.4	132.8	118.1
Нийт зах зээлийн үнэлгээ	1,968	1,936	1,952
Ногдол ашиг, хувиар	5.3%	6.9%	6.1%

Сан нь 2019 онд 250 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2020 онд 4.75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татахаар төлөвлөж байна. Сан нь үйл ажиллагаагаа 2020 оноос эхлэх бөгөөд тухайн жилдээ нийтдээ 7.0 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авч, арилжаалахаар төлөвлөөд байна. Ингэснээр 2020 оны жилийн эцэст 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байхаар төлөвлөв.

Хүснэгт 8. Хөрөнгийн хэмжээ, сая төгрөг

Бодит	Төлөвлөгөө										
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Нийт хөрөнгө	250	5,115	6,114	7,310	8,612	10,129	11,881	13,941	16,338	19,119	20,219
Мөнгө	250	256	306	366	431	506	594	697	817	956	20,219
Хөрөнгө оруулалт	-	4,859	5,808	6,945	8,182	9,622	11,287	13,244	15,521	18,163	-
Хувьцаа	-	3,580	4,280	5,117	6,029	7,090	8,317	9,759	11,436	13,383	-
Бонд	-	1,279	1,529	1,828	2,153	2,532	2,970	3,485	4,084	4,780	-
Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	0	-
Дундаж хөрөнгө	4,883	5,614	6,712	7,961	9,370	11,005	12,911	15,139	17,728	20,076	
Үнэт цаасны арилжаа	7,026	3,168	3,789	4,408	5,177	6,059	7,112	8,324	12,541	14,915	

2020 онд Сангийн нийт хөрөнгийн 70 хувь буюу 3.6 тэрбум төгрөг нь хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт, 25 хувь буюу 1.3 тэрбум төгрөг нь өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт, үлдэх 5 хувь нь мөнгөн хөрөнгө байх юм. Цаашид Сан нь ногдол ашиг болон хөрөнгө оруулалтын бодлогын хязгаарын хүрээнд жилд дунджаар 7.3 тэрбум төгрөгийн нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг өрийн хэрэгслийг худалдан авах болон худалдах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд үүний үр дүнд Сангийн нийт хөрөнгө оруулалт жилд дунджаар 17.9 хувь (2021-2028 он) өсөх юм. 2029 онд Сан нь хөрөнгө оруулалтын багц дахь нийт хувьцаа, үнэт цаасаа зарснаар 20.2 тэрбум төгрөг (холбогдох зардал хассан)-ийн цэвэр мөнгөн хөрөнгөтэй болох бөгөөд үүнийгээ нийт нэгж эрх эзэмшигчдэд хуваарилна.



Сан нь 2020 онд хөрөнгө оруулалтаас 614 сая төгрөгийн нийт орлого олохоор төлөвлөж байгаа бөгөөд үүний 217 сая төгрөг нь хэрэгжсэн орлого, 398 сая төгрөг нь хэрэгжээгүй орлого байхаар төлөвлөсөн болно. Нийт орлого жил бүр дунджаар 39.3 хувь (2021-2029 он)-аар нэмэгдэж байгаа бөгөөд 2029 онд 8.2 тэрбум төгрөгт хүрэх боломжтой юм. Сан нь үйл ажиллагаа явуулж байх хугацаандaa нийт 22.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хэрэгжсэн орлоготой ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд уг орлогын 65.8 хувь нь хувьцааны арилжааны олз, 14.8 хувь нь өрийн хэрэгслийн хүүгийн орлого, 0.7 хувь нь харилцах дансны хүүгийн орлого, 18.6 хувь нь хүлээж авсан ногдол ашиг тус тус байх юм.

Хүснэгт 9 Хөрөнгө оруулалтаас олох орлого, сая төгрөг

	Бодит					Төлөвлөгөө					
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Хэрэгжсэн орлого	0.56	217	654	881	1,133	1,404	1,708	2,050	2,443	3,686	8,247
Хувьцааны арилжааны олз	-	99	244	391	547	714	896	1,097	1,325	2,376	7,075
Бондын хүү	-	112	184	220	263	310	365	428	502	588	344
Харилцахын хүү	0.56	6	9	11	13	16	18	21	25	29	17
Ногдол ашиг	-	-	217	259	310	365	429	504	591	693	810
Хэрэгжээгүй орлого	-	398	974	1,563	2,188	2,855	3,583	4,390	5,300	5,543	-
Нийт орлого	0.56	614	1,628	2,444	3,321	4,259	5,291	6,440	7,743	9,229	8,247

Сан нь 2020 онд үндсэн үйл ажиллагаагаа эхлүүлснээр 524 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөөд байна. Уг зардалд хөрөнгө оруулалт татахтай холбоотой зардал, үндсэн үйл ажиллагааны зардлууд, мөн 2018 болон 2019 онд гарсан Санг үүсгэн байгуулах зардал зэрэг багтсан болно. Тухайлбал, хөрөнгө оруулалт татахтай холбоотой зардал нь 310 сая төгрөг байгаа бөгөөд үүнд МХБ-ийн бүртгэл, үйлчилгээний хөлс болон хөрөнгө оруулагчдад зуучилсан хөлс зэрэг багтана. Уг зардал нь зөвхөн нэг удаа гарах зардал юм. Тус онд үйл ажиллагаатай холбоотой 175 сая төгрөгийн зардал гарах бөгөөд үүнд менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах зардал, МХБ-ийн жилийн үйлчилгээний хөлс, Кастодиан банкны зардал болон аудиттай холбоотой зардлууд багтаж юм. Сангийн зардал нь жил бүр удирдаж буй хөрөнгийн үнийн дүнгийн өсөлтөөс хамаарч дунджаар 5.2 хувиар нэмэгдэнэ. Гэхдээ менежментийн компани нь зардлыг бууруулах чиглэлээр ажиллах бөгөөд 2020 онд үндсэн үйл ажиллагааны зардал нь орлогын 13.8 хувьтай тэнцэж байгаа бол уг харьцаа жил бүр буурсаар 2029 он гэхэд нийт орлогын 3.5 хувьтай тэнцэхээр байна. Нийт дэлгэрэнгүй орлого 2020 онд 44 сая төгрөг байх бөгөөд үүний 314 сая төгрөг нь үйл ажиллагааны алдагдал 358 сая төгрөг нь борлуулаагүй үнэт цаасны үнэ цэнийн өсөлт байна. Сан нь дунд болон урт хугацаанд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа тул жил бүр хөрөнгө оруулалтаас 20-30%-ийг худалдах бөгөөд бусад худалдаагүй үлдсэн хувьцааны үнэ цэнийн өсөлтийг “Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт” гэж санхүүгийн тайлан дээр тусгаж явах болно. Энэхүү бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт нь 2020 онд 398 сая төгрөг, хойшлогдсон татвар 40 сая төгрөг байх бөгөөд цэвэр дүнгээр 358 сая төгрөг байхаар төлөвлөөд байна.



2020 -08- 24

Хүснэгт 10. Орлогын тайлан, сая төгрөг

	Бодит		Төлөвлөгөө								
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Үйл ажиллагааны орлого	0.56	217	654	881	1,133	1,404	1,708	2,050	2,443	3,686	8,247
Хувьцааны орлого	-	99	460	650	857	1,079	1,325	1,601	1,916	3,068	7,886
Хувьцаа арилжааны олз	-	99	244	391	547	714	896	1,097	1,325	2,376	7,075
Ногдол ашиг	-	-	217	259	310	365	429	504	591	693	810
Хүүгийн орлого	0.56	117	193	231	276	326	383	449	527	618	361
Бонд	-	112	184	220	263	310	365	428	502	588	344
Харилцах	0.56	6	9	11	13	16	18	21	25	29	17
Зардал	0.38	524	221	261	306	358	417	486	566	682	564
Үсгэн байгуулах	-	40	-	-	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалт татах	-	310	-	-	-	-	-	-	-	-	-
МХБ-ийн бүртгэл	-	50	-	-	-	-	-	-	-	-	-
Хянах үйлчилгээний хэлс	-	2	-	-	-	-	-	-	-	-	-
Нэгж эрх боловсруулах	-	20	-	-	-	-	-	-	-	-	-
Зуучлал	-	238	-	-	-	-	-	-	-	-	-
Үйл ажиллагааны зардал	0.38	175	221	261	306	358	417	486	566	682	564
Менежмент	-	81	140	168	199	234	275	323	378	443	293
Кастодиан	-	11	20	23	28	33	39	45	53	62	41
МХБ-ийн хэлс	-	3	6	7	8	9	11	13	15	18	20
Аудит	-	20	21	22	23	24	26	27	28	30	31
Брокерийн шимтгэл	-	44	18	21	25	29	34	39	46	76	119
Бусад	0.38	15	17	20	24	28	33	39	45	53	60
Татварын өмнөх ашиг	0.18	(308)	432	620	827	1,047	1,291	1,564	1,877	3,004	7,683
Татварын зардал	0.06	6	23	38	54	71	89	110	133	236	711
Татварын дараах ашиг	0.13	(314)	409	582	773	976	1,202	1,454	1,744	2,767	6,972
Бусад орлого	-	358	877	1,407	1,969	2,569	3,225	3,951	4,770	4,989	-
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт	-	398	974	1,563	2,188	2,855	3,583	4,390	5,300	5,543	-
Хойшлогдсон татвар	-	40	97	156	219	285	358	439	530	554	-
Нийт дэлгэрэнгүй орлого	0.13	44	1,286	1,989	2,742	3,545	4,426	5,405	6,513	7,756	6,972

2013 оны Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар Сан нь орлогын албан татвар төлөхгүй байхаар зохицуулагдсан боловч 2019 оны 3 сарын 22-ны өдрийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар албан татвар төлөхөөр зохицуулагдсан байна. Сан нь үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа нийт 1.5 тэрбум төгрөгийн орлогын албан татвар төлөх юм.

Сан нь 2019 оны жилийн эцсээр 250 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бөгөөд 2020 онд үйл ажиллагаа эхлүүлснээр 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болохоор төлөвлөж байна. Нийт хөрөнгө жилд 16.6 хувь (2021-2029 он)-аар өсөх бөгөөд 2029 он гэхэд нийт хөрөнгө 20.2 тэрбум төгрөгт хүрэх юм. Сан нь 2029 оны 8 сарын 6-ны өдрөөр тасалбар болгон үйл ажиллагаагаа дуусгавар болгох бөгөөд энэ хугацаанд нийт 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 20.2 тэрбум төгрөг хүртэл өсгөснөөр 17.6 хувийн дундаж өгөөж (CAGR, ногдол ашиг оруулж тооцсон)-тэй ажиллах юм. 2029 онд Сан нь нийт хувьцаа, үнэт цаасаа зарж, 20.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй үлдэх бөгөөд энэхүү мөнгөн хөрөнгийг нэгж эрх



эзэмшигчдэдээ хуваарилах болно.

Сан нь СЭХ-ны журмын дагуу онцгой тохиолдол үүссэнээс бусад тохиолдолд зээл авахгүй бөгөөд нийт өр төлбөрийн хэмжээ 2019 онд 2,000 төгрөг байсан бөгөөд жилд дунджаар өр төлбөр ба нийт хөрөнгийн харьцаа 5 хүрэхгүй хувь байхаар төлөвлөж байна. Өр төлбөр нь үйлчилгээний хөлсийг тухайн жилдээ багтаж төлөөгүйтэй холбоотой үүсч байгаа болно. Нийт эздийн өмч нь 2019 оны жилийн эцсээр 250 сая төгрөг байсан бөгөөд 2020 оноос үйл ажиллагаа явуулж эхэлснээр жилд дунджаар 16.7 хувь (2021-2029)-аар өсөж, 2029 он гэхэд 20.2 тэрбум төгрөгт хүрэх юм.

Хүснэгт 11. Баланс, сая төгрөг

	Бодит										Төлөвлөгөө	
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	
Хөрөнгө	250	5,115	6,114	7,310	8,612	10,129	11,881	13,941	16,338	19,119	20,219	
Мөнгө	250	256	306	366	431	506	594	697	817	956	20,219	
Хөрөнгө оруулалт		4,859	5,808	6,945	8,182	9,622	11,287	13,244	15,521	18,163		
Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
Өр төлбөр	0	71	142	226	309	404	494	615	739	883		
Өглөг	0	25	21	31	36	48	47	66	76	92		
Татварын өглөг	0	6	23	38	54	71	89	110	133	236		
Хойшлогдсон татварын өглөг		40	97	156	219	285	358	439	530	554		
Эздийн өмч	250	5,044	5,972	7,084	8,303	9,725	11,386	13,327	15,598	18,236	20,219	
Хувьцаат капитал	250	5,000	5,000	5,000	5,000	5,000	5,000	5,000	5,000	5,000	5,000	
Хуримтлагдсан ашиг	0	(314)	96	677	1,334	2,155	3,162	4,376	5,829	8,247	15,219	
Бодит үнэ цэнийн тохицуулгын нөөц		358	877	1,407	1,969	2,569	3,225	3,951	4,770	4,989		
Өр төлбөр эздийн өмч	250	5,115	6,114	7,310	8,612	10,129	11,881	13,941	16,338	19,119	20,219	

Хүснэгт 12. Харьцаа үзүүлэлтүүд

	Бодит										Төлөвлөсөн	
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	
Өсөлт												
Орлого						79%	37%	30%	25%	22%	20%	19%
Зардал						-58%	18%	17%	17%	17%	17%	20%
Татварын дараах ашиг						-230%	42%	33%	26%	23%	21%	20%
Нийт ашиг						2814%	55%	38%	29%	25%	22%	20%
Баланс												
Хөрөнгө оруулалт						20%	20%	18%	18%	17%	17%	17%
Хөрөнгө						20%	20%	18%	18%	17%	17%	17%
Эздийн өмч						18%	19%	17%	17%	17%	17%	17%
Өр төлбөр						101%	59%	37%	31%	22%	24%	20%
Харьцаа												
Y.а зардал/орлого	67.2%	13.8%	9.8%	8.4%	7.6%	7.1%	6.8%	6.6%	6.4%	6.2%	3.5%	
Өр төлбөр/хөрөнгө	0.0%	1.4%	2.3%	3.1%	3.6%	4.0%	4.2%	4.4%	4.5%	4.6%	0.0%	



Хүснэгт 13. Мөнгөн хөрөнгийн тайлан, сая төгрөг

	Бодит	Төлөвлөгөө										2029
		2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	(0)	(500)	(231)	(274)	(339)	(400)	(489)	(556)	(666)	(799)	(1,603)	0
Орлого												
Зардал	0.41	500	231	274	339	400	489	556	666	799	1,603	
Үүсгэн байгуулах	-	40	-	-	-	-	-	-	-	-	-	
Хөрөнгө оруулалт татах	-	310	-	-	-	-	-	-	-	-	-	
Үйл ажиллагааны зардал	0	150	200	230	270	310	370	420	490	590	460	
Бусад	0											
Татвар		0	6	23	38	54	71	89	110	133	947	
Өглөг		-	25	21	31	36	48	47	66	76	197	
Хөрөнгө оруулалт	1	(4,245)	281	334	521	631	771	900	1,076	1,287	20,867	
Орлого	116	2,030	2,569	3,071	3,671	4,326	5,087	5,967	7,002	9,611	20,867	
Хувьцаа борлуулсны орлого		750	880	1,052	1,258	1,482	1,743	2,044	2,399	4,217	14,915	
Бондын эргэн төлөлт		1,163	1,279	1,529	1,828	2,153	2,532	2,970	3,485	4,084	4,780	
Хүлээн авсан ногдол ашиг		-	217	259	310	365	429	504	591	693	810	
Хүүгийн орлого	1	117	193	231	276	326	383	449	527	618	361	
Бусад	115											
Зарлага	115	6,275	2,288	2,737	3,151	3,695	4,316	5,068	5,926	8,324	-	
Хувьцаа авахад төлсөн	-	3,834	760	909	998	1,163	1,346	1,582	1,841	3,544	-	
Бонд авахад төлсөн	-	2,441	1,529	1,828	2,153	2,532	2,970	3,485	4,084	4,780	-	
Бусад	115											
Санхүүгийн мөнгөн урсгал	250	4,750	-	-	(116)	(155)	(195)	(240)	(291)	(349)	-	
Орлого	250	4,750	-	-	-	-	-	-	-	-	-	
Нэгж эрх гаргаснаас хүлээн авсан	250	4,750										
Зарлага	-	-	-	-	116	155	195	240	291	349	-	
Төлсөн ногдол ашиг	-	-	-	-	116	155	195	240	291	349	-	
Цэвэр мөнгөн урсгал	250	6	50	60	65	76	88	103	120	139	19,263	
Мөнгөний эхний үлдэгдэл	-	250	256	306	366	431	506	594	697	817	956	
Мөнгөний сүүлийн үлдэгдэл	250	256	306	366	431	506	594	697	817	956	20,219	

"Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС нь бизнес төлөвлөгөөгөө тооцоолоходо ТОП-20 индексийн түүхэн өгөөжийг ашигласан билээ. Ингэхдээ хамгийн боломжит хувилбар буюу ТОП-20 индексийн 2010-2019 оны хоорондох дундаж өгөөж буюу 22.9 хувийн өгөөж мөн 6.1 хувийн дундаж ногдол ашгийг ашиглан ирэх жилүүдийн Сангийн үйл ажиллагааны орлого, ашиг болон үйл ажиллагааны эцэс дэх хөрөнгө оруулагчдад хуваарилах мөнгөн хөрөнгө зэргийг тооцолсон болно. Энэхүү тооцооллоор Үндэсний Хувьчлалын Сан нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа 16.6 тэрбум төгрөгийн татварын дараах ашигтай ажиллаж, 2029 онд 20.2 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй болох бөгөөд үүнийгээ хөрөнгө оруулагч нартаа хуваарилах юм. Ингэснээр Сан нь хөрөнгө оруулагчдадаа жилийн 17.6 хувийн дундаж өгөөж (CAGR, ногдол ашиг оруулж тооцсон)-тэй ажиллах юм. Энэхүү бизнес төлөвлөгөөнд үндэслэн Сангийн нэг нэгж эрхийн үнэлгээг тооцоолоход 2029 онд 404.4 төгрөг болох бөгөөд энэ нь анх хөрөнгө оруулагчдад санал болгосон үнээс 4 дахин өссөн үзүүлэлт байх юм. Энэхүү тооцооллоос гадна ТОП-20 индексийн бусад жилийн түүхэн өгөөжийг ашиглан Үндэсний Хувьчлалын Сангийн төлөвлөгөөний сайн болон мүү хувилбарыг тооцоолж мэдрэмжийн шинжилгээ хийсэн.



Мэдрэмжийн шинжилгээ (Sensitivity analysis)

Мэдрэмжийн шинжилгээ нь тодорхой бус байдалд таамаглал хийхдээ хэд хэдэн боломжит нөхцөл байдлыг авч үзэж, тус бүрт нь үнэлгээ хийх аргачлал юм. Бид Сангийн хөрөнгө оруулалт хийсэн хувьцаанаас олох өгөөжийг тооцоходоо ТОП-20 индексийн түүхэн өсөлтийг ашигласан. Тэгэхдээ гурван өөр нөхцөл байдал, түүхэн хугацааг сонгож харьцуулж үзсэн.

ТОП-20 индекс 2005-2019 оны хооронд жилд дунджаар 54.3 хувиар өссөн билээ. Энэхүү түүхэн өгөөж дээр үндэслэн Үндэсний Хувьчлалын Сангийн төлөвлөгөөны сайн хувилбарыг тооцоолоход нийт үйл ажиллагаа явуулах хугацаандаа 82.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 2029 онд нийт цэвэр хөрөнгө 82.7 тэрбум төгрөгт хүрэх бөгөөд энэхүү цэвэр хөрөнгө хөрөнгө оруулагчдадаа хуваарилна. Ингэснээр Сан нь хөрөнгө оруулагчдад жилийн 37.5 хувийн өгөөж өгөх боломжтой байна. Энэхүү тооцооллоор цэвэр хөрөнгийн үнэлгээнд сууриссан Сангийн нэг нэгж эрхийн үнэлгээ 2029 онд 1,653 төгрөг болно. Ингэснээр анх 100 төгрөгөөр худалдаж авч байсан нэгж эрх 2029 онд 16.5 дахин өсөх боломжтой юм. Статистик ач холбогдолын хувьд түүхэн тоон мэдээлэл нь илүү урт, олон жилийн мэдээлэл байх тусам ирээдүйн таамаглал хийх чадвар нэмэгддэг. Гэвч энэ үеийн хөрөнгийн зах зээлийн өсөлт хэтэрхий хөөсрөлттэй байх эрсдэлтэй.

Харин мүү хувилбар буюу ТОП-20 индексийн 2015-2019 оны хоорондох түүхэн өгөөж 8.8 хувь байх үеийн өгөөжөөр Сангийн төлөвлөгөөг тооцоолоход үйл ажиллагаа явуулах хугацаандаа нийт 5.4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нийт хөрөнгө оруулагчдад жилийн 8.4 хувийн өгөөж өгөх боломжтой байна. 2015-2019 онын хувьд ирээдүйн таамаглал хийхэд тийм ч хангалттай хугацааг хамраагүй болно.

Хүснэгт 14. Төлөвлөгөөний боломжит хувилбарууд, 2020-2029 оны хооронд, тэрбум төгрөг

Боломжит хувилбар	Сангийн санхүүгийн төлөвлөгөө	Нийт хөрөнгө оруулагчдад хугацаалах мөнгө		Хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөж	
		Татварын дараах ашиг	Ногдол ашиг	Хугацааны эцэс дэх мөнгө	Өгөөж Нэгж эрхийн үнэлгээ (төгрөг)
Сайн	82.6	4.9	82.7	37.5%	1,653
Дундаж	16.6	1.3	20.2	17.6%	404
Мүү	5.4	0.6	9.8	8.4%	196

ТОП-20 индексийн тооцоолол хийснээс хойш зах зээлд гэнэтийн шок буюу шинэ төрлийн коронавирус (КОВИД-19)-ээс үүдэлтэй шок үүсэж ТОП-20 индекс 2020 оны 4 сарын 16-ны өдрийн байдлаар оны эхнээс 15% унаад байна. Ингэж үнэт цааснуудын үнэ хямдарч байгаа нь Сан хөрөнгө оруулалт татсаны дараа зах зээлээс хямд үнэтэй үнэт цаас авах таатай боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд бид дунд болон урт хугацаанд Монголын эдийн засгийг зерэгээр төсөөлж байна. Тийм учраас бид ирэх 9 жилд Үндэсний Хувьчлалын Сан нь бизнес



төлөвлөгөөний сайн хувилбараар ажиллах боломж бүрдэж 37.5 хувийн жилийн өгөөжийг хөрөнгө оруулагч, нэгж эрх эзэмшигчдэд өгөх боломжтой гэж итгэж байна.

Сангийн өгөөж нь Сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэмжигдэхүүн бөгөөд Сангийн цэвэр хөрөнгийн өсөлт бууралтаар илэрхийлэгдэнэ. Ингэхдээ Сангийн хөрөнгө оруулалтыг анх авсан үнээсээ өссөн буурсныг харуулдаг бөгөөд тухайн хөрөнгө оруулалтыг зarah хүртэл хэрэгжихгүй болно.

АНХААРУУЛГА: Бид төлөвлөгөөг боловсруулахдаа ТОП-20 индексийн 2010-2019 оны хоорондох түүхэн дундаж өгөөжийг ашигласан билээ. Статистик ач холбогдолын хувьд түүхэн тоон мэдээлэл нь илүү урт, олон жилийн мэдээлэл байх тусам ирээдүйн таамаглал хийх чадвар нэмэгддэг боловч ирээдүйд Сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийн баталгаа болохгүйг хөрөнгө оруулагчдад анхааруулж байна. Сангийн төлөвлөгөө нь хууль эрх зүйн орчны нөлөө, эдийн засгийн ерөнхий чиг хандлага, үйл ажиллагаа явуулж буй салбарын хэтийн төлөв, өсөлт, тэдгээртэй холбоотой эрсдэл, тодорхойгүй байдал зэргээс шалтгаалан төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх боломжтой юм.



2.6 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-аас гишүүдэд ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Сангийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргахдаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Сангийн дүрэм болон бусад холбогдох журмыг чанд баримтлан ажиллана.

Ногдол ашгийг хуваарилах нөхцөл

Сан нь доорх нөхцөл бүрдсэн, хангагдсан үед нэгж эрх эзэмшигч гишүүддээ ногдол ашиг хуваарилах болно.

- Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан;
- Сангийн жилийн өгөөж дунджаар 17.6 хувь (зардал хассан) болон түүнээс дээш байх;
- Сан холбогдох хууль журмын дагуу шалгуур үзүүлэлт, харьцаануудаа хангаж байх.

Ногдол ашгийн бодлого

Сан нь Ногдол ашиг хуваарилах нөхцөлд заасан нөхцөл байдал хангагдсан тохиолдолд тухайн жилийн татварын дараах цэвэр ашгаас 20 хувийг ногдол ашиг хэлбэрээр нэгж эрх эзэмшигчдээ хуваарилахаар төлөвлөж байгаа болно. Сангийн үр ашгийн тооцоогоор төлөвлөсний дагуу ажиллабал 2022 оноос Сан нь ногдол ашиг хуваарилах боломжтой юм. Жил бүр ногдол ашгийн хэмжээ ашигтай уялдан өсөх бөгөөд 2027 онд Сан нь нийт нэгж эрх эзэмшигчдээ 348.7 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 15. Ногдол ашгийн төлөвлөгөө, сая төгрөг

Бодит	Төлөвлөгөө										
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Ногдол ашиг (сая төгрөг)	-	-	-	116.3	154.6	195.2	240.3	290.9	348.7	-	-
Нэгжэд ноогдох (төгрөг)	-	-	-	2.3	3.1	3.9	4.8	5.8	7.0	-	-

Ногдол ашиг хуваарилах

- Ногдол ашиг тараах, түүний хувь хэмжээг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТҮЗ-өөс шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах шийдвэрт нэгж эрх бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.
- Ногдол ашгийг үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эрх бүхий байгууллагаар дамжуулан нэгж эрх эзэмшигчдийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- Ногдол ашиг тараах талаар болон ногдол ашиг тараасан талаар мэдээ, тайлант холбогдох хууль, журмын дагуу мэдэгдэж ажиллана.

Ногдол ашиг тараахгүй байх нөхцөл

Сан нь ногдол ашиг тараах нөхцөл бүрдээгүй эсхүл ногдол ашиг тараах нөхцөл бүрдсэн ч ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд хуваарилахгүй болсон үндэслэл, шалтгаан зэргийг тодорхойлсон шийдвэрийг нэгж эрх эзэмшигчдийн хурал болон олон нийтэд хууль журмын дагуу мэдээлэх болно.



2.7 ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, НЭГЖ ЭРХИЙН ҮНЭ

Сангийн цэвэр хөрөнгө болон түүнд суурилсан нэгж эрхийн үнийг өдөр бүр Голомт Банкны кастодиан банкны хэлтэс болон Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь тооцоолж Сангийн сайтаар дамжуулан мэдээллэх болно. “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн цэвэр хөрөнгө нь тухайн өдрийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассантай тэнцүү байна. Сангийн нэгж эрхийн үнэлгээ нь тухайн өдрийн сангийн цэвэр хөрөнгийг гаргасан нэгж эрхийн тоонд хувааснаар тодорхойлогдоно.


Сангийн хөрөнгийн үнэлгээг тооцоходоо доорх бодлого баримтална. Үүнд:

- Хувьцааны үнэлгээ: Үнэт цаасны арилжааны байгууллагад бүртгэлтэй хувьцааны үнэлгээг тухайн арилжааны байгууллагад арилжаалсан сүүлийн хаалтын ханшинд суурilan гаргана.
- Өрийн хэрэгслийн үнэлгээ: Үнэт цаасны арилжааны байгууллагад бүртгэлтэй өрийн хэрэгслийн үнэлгээг түүний хүүг хуримтлуулан тооцно.
- Бэлэн мөнгө, хадгаламжийн үнэлгээ: Бэлэн мөнгө болон хадгаламжийн үнэ цэнийг тооцоходоо түүний хуримтлагдсан хүүг оруулна.

Сангийн хөрөнгийн үнэлгээг тооцоолоходоо дээрх бодлогыг баримтлахаас гадна Сангийн менежер болон Санд үйлчилгээ үзүүлж байгаа мэргэшсэн нягтлан бодогч, кастодианы тооцоолох аргыг харгалзан үзэх болно.

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС нь 2019 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээр 2020 оны эцэст 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болохоор төлөвлөж байна. Цашид хөрөнгө жилд дунджаар 16.6 хувь (2021-2029 он)-аар өсч, 2029 он гэхэд нийт 20.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болох юм.


График 3. *Сангийн нийт хөрөнгө, сая төгрөг*



Сангийн цэвэр хөрөнгө 2019 онд 250 сая төгрөг байсан бөгөөд 2020 онд үйл ажиллагаа эхлүүснээр 5.0 тэрбум төгрөгт хүрэх юм. Цашид жилд дунджаар 16.7 хувь (2021-2029 он)-аар өсөх бөгөөд 2029 онд өр төлбөрөө төлөөд 20.2 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй байхаар төлөвлөсөн болно.




График 4. *Сангийн цэвэр хөрөнгө, сая төгрөг*



Анх нэг нэгж эрхийг олон нийтэд 100 төгрөгөөр санал болгох бөгөөд 2020 оны жилийн эцсээр цэвэр хөрөнгийн үнэлгээнд суурилсан нэг нэгж эрхийн үнэлгээ 100.9 төгрөг байх бол 2029 онд 404.4 төгрөгт хүрэхээр төлөвлөсөн байна. Энэхүү нэгж эрхийн үнэлгээ нь ногдол ашиг тараасны дараах Сангийн цэвэр хөрөнгөд суурилсан үнэ цэнэ болно.

График 5. *Сангийн нэгж эрхийн үнэлгээ, төгрөг*



Хэдийгээр нэгж эрхийн үнэлгээ сангийн цэвэр үнэлгээнд үндэслэн тогтоогдож байгаа боловч хоёрдогч зах зээлийн үнэтэй хамааралгүй байна. Сангийн нэгж эрх нь хоёрдогч зах зээлд чөлөөтэй арилжаалагдах бөгөөд эрэлт нийлүүлэлт дээр үндэслэн үнэ нь тогтох болно.

3.АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэр	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Бүртгэл	<ul style="list-style-type: none"> - УБД: 9011306066 - РД: 5510759
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалтын менежмент; - Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. - Тусгай зөвшөөрлийн дугаар: 380/09
Хугацаа	2011-9-6
Санхүүгийн үзүүлэлт (2019-12-31)	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө: 378 сая төгрөг - Өмч: 121 сая төгрөг - Өр төлбөр: 257 сая төгрөг - Борлуулалтын орлого: 217 сая төгрөг
Хувьцаа эзэмшигч	“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК
Гүйцэтгэх захирал	Ч.Хандаа
Ажилчдын тоо	8
Хаяг	<ul style="list-style-type: none"> - Монгол Улс, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, - “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн байр, 2 давхар - Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: ardmanagement.mn

“Ард Менежмент ҮЦК” ХХК (цаашид Ард Менежмент гэх) нь 2011 оны 9 сарын 6-ны өдөр гадаад худалданы чиглэлээр “Интер Групп Интернэйшнл” ХХК-ийн хөрөнгө оруулалттай үүсгэн байгуулдсан. 2014 онд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Ард Менежментийг худалдан авч, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн.

2016 оны 2 сарын 24-ний өдөр Ард Менежмент нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар албан ёсоор хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

2019 онд Ард Менежмент нь Монгол Улсын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулсан билээ. Уг Сан нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг компаниудын хувьчлалд оролцох, түүний бүтээж буй баялгаас хөрөнгө оруулагчидад хувь хүртээх зорилготой.

2019 онд Ард Менежмент нь 217 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бол хөрөнгө нь 378 сая төгрөгт хүрсэн байна.



3.2 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бүтэц зохион байгуулалт

Ард Менежмент нь харилцагчийн хөрөнгийг дунд болон урт хугацаанд тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулж, удирдахад мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилладаг. Иймд мэргэшсэн туршлагатай, мэргэжлийн ёс зүйг эрхэм болгосон хөрөнгө оруулалтын менежерүүд хөрөнгийн багцыг удирдах ба олон улсын стандарт бүхий хөрөнгө оруулалт, засаглал, байгууллагын соёлыг нэвтрүүлсэн бүтэц зохион байгуулалттай болно.

Схем 2. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт



Хувьцаа эзэмшигч

"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК нь "Ард Менежмент УЦК" ХХК-г 100 хувь эзэмшдэг болно. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК буюу Ард Холдингс нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. 2019 оны байдлаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь доорх 11 компанийн хувьцааг эзэмшиж байна.

Схем 3. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн хөрөнгө оруулалтын бүтэц

"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК			
Ард Даатгал - Ердийн даатгал - 1994 он	Ард Кредит ББСБ - Банк бус санхүүгийн байгууллага - 2011 он	Ард Секьюритиз УЦК - Үнэт цасны компани - 1997 он	Ард Менежмент УЦК - Хөрөнгө оруулалтын менежмент - 2011 он
Ард Актив - Хадгаламж Зээлийн хороо - 2008 он	Ард Лайф - Хувийн тэтгэвэрийн үйлчилгээ - 2010 он	Монгол Шуудан - Шуудан, логистик - 1921 он	Тэнгэр Системс - Программ хангамж - 2007 он



Ард Бит
- Үл хөдлөх хөрөнгө, гадаад худалдаа - 2017 он

Ард Холдингс Интернэшил
- Бизнесийн зөвлөгөө - 2019 он

Крипто Ундэстэн
- Цахим худалдаа - 2017 он

Эдгээр компаниуд нь харилцан бие биесийнхээ бизнесийг дэмжиж, хамтдаа санхүүгийн цогц үйлчилгээг Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор үзүүлдэг байна.

Төлөөлөн Удирдах зөвлөл

“Ард Менежмент УЦК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь улиралд нэгээс доoshгүй удаа хуралддаг, үл ажиллагаагаа зохицуулсан журамтай, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага юм.

ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд гишүүд нь санхүүгийн зах зээлд З-аас доoshгүй жил ажилласан туршлагатай юм.

Хүснэгт 16. “Ард Менежмент УЦК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил	Компанийн засаглал
1.	Ч.Ганхуяг	ТУЗ-ийн дарга	Эдийн засагч	0130277
2.	Г.Цогбадрах	ТУЗ-ийн ердийн гишүүн	Эдийн засагч, бизнес удирдлага	26765
3.	Бат.Золбоо	ТУЗ-ийн ердийн гишүүн	Эдийн засаг, санхүү	0130947
4.	Б.Солонгоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эрх зүйч	
5.	Баяр.Золбоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эдийн засагч	

ТУЗ-ийн дарга: Чулууны Ганхуяг

Ч.Ганхуяг нь 1991 онд Монголын Хөрөнгийн Биржээс хөдөлмөрийн гараагаа эхэлсэн бөгөөд 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэж, Монголбанкинд хянан шалгагчаар орсон. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр санхүүгийн менежерээр ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан гүйцэтгэх захирлаар нь томилогдсон. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсан бөгөөд 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн Хас Банк байгуулагдсан юм. Ганхуяг нь Хас Банкийг байгуулагдсан цагаас нь хойш 2009 оныг хүртэл гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд Хас Банкны толгой компани болох “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал байжээ. 2010-2012 онд Монгол Улсын Сангийн дэд сайдын албандаа томилогдон ажилласан байна.

Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Монголын Оюутны Холбооны ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны ерөнхийлөгч зэрэг албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг





1990-ээд оны сүүлээр эхлүүлж, СИДАН ХЗХ-ны удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байжээ.
2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг дэлхийн залуу манлайлагчаар
өргөмжилсөн байна..

ТҮЗ-ийн ердийн гишүүн: Галбадрахын Цогбадрах

Г.Цогбадрах нь 1997 онд Монгол Улсын Их Сургуулийг банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд ажлын гараагаа суралцаж байх хугацаандаа буюу 1996 онд Голомт Банкинд ажиллаж эхлүүлсэн байна. Тэрээр 2000 оноос Хас Банкны санхүү, дотоод аудит, салбарын удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар тус тус ажиллаж байгаад 2009-2010 онд АНУ-ын Үндэсний Их Сургуульд бизнес удирдлага мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. 2010 онд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2011 оноос 2014 оны хооронд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажилласан. 2016 оноос “Ард Даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ТҮЗ-ийн ердийн гишүүн: Батбилэгийн Золбоо

Б.Золбоо нь 2012 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд олон улсын нягтлан бодогч мэргэжлээр сурч байгаад 2013-2016 онд АНУ-ын Платсбүрг Коллеж (Plattsburgh college)-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. 2016-2017 онд “Ард Секюритиз УЦК” ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээч, 2017 оноос “Ард Менежмент УЦК”-ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирлаар тус тус ажиллаж байгаад 2019 оноос “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-д санхүү хариуцсан захирлаар ажиллаж эхэлсэн байна.

ТҮЗ-ийн хараат бус гишүүн: Баярсайханы Золбоо

Б.Золбоо нь Портландын Их Сургуулийг эдийн засгийн ухааны бакалавр, Сиднейн Их Сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй тус тус төгссөн. 2006 оноос ажлын гараагаа Голомт Банкны диллерээр эхлүүлсэн. 2012 оноос диллерийн дарга, 2014 оноос Голомт Банкны худалдааны газрын захирал, 2017-2018 онд нөөцийн удирдлагын газрын захирлаар тус тус ажилласан. Тэрээр 12 жилийн хугацаанд тасралтгүй банк санхүүгийн байгууллагад ажилласан, арвин туршлагтай бөгөөд 2018 оноос “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТҮЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

ТҮЗ-ийн хараат бус гишүүн: Баярсайханы Солонгоо

Б.Солонгоо нь Унгар Улсын Өөтвөш Лорандын Их Сургуулийг эрх зүйч мэргэжил, Дандийгийн Их Сургуулийг ашигт малтмалын эрх зүйн бодлогын магистр, Харвардын Хуулийн Сургуулийг магистр зэрэгтэй тус тус төгссөн. Солонгоо нь 2007 оноос ажлын гараагаа Монголын уул уурхайн үндэсний ассоциацид хуулийн зөвлөх, 2010 оноос “М Си Эс Холдинг” ХХК-д хуулийн мэргэжилтэн, 2011 оноос “Хоган Ловеллс” ХХН-д ахлах хуульчар ажилласан бөгөөд 2017 онд өмгөөллийн “Авинекс Партерс” ХХН-ийн үүсгэн байгуулагч гишүүн, захиралын албан тушаалыг хашиж байна. Мөн 2018 оноос “Ард Менежмент УЦК” ХХК-ийн ТҮЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.





Хөрөнгө оруулалтын хороо

Ард Менежментийн төлөөлөн удирдах зөвлөл нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах үндсэн суурь нөхцлийг хангах зорилгоор хөрөнгө оруулалтын хороотой байна. Хөрөнгө оруулалтын хороо нь төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон 3-аас дээш тооны гишүүнтэй байна. Ард Менежментийн хөрөнгө оруулалтын хорооны гишүүд нь хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, уг чиглэлээр ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд болно.

Хүснэгт 17. “Ард Менежмент УЦК” ХХК-ийн хөрөнгө оруулалтын хорооны гишүүд

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил
1.	Б.Золбоо	Хорооны дарга	Эдийн засаг, санхүү
2.	Ч.Ганхуяг	Хорооны гишүүн	Эдийн засагч
3.	Г.Цогбадрах	Хорооны гишүүн	Эдийн засагч, бизнес удирдлага

Хөрөнгө оруулалтын хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд түүний бүрэн эрх нь төлөөлөн удирдах зөвлөлийн журмаар зохицуулагдана. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлж буй Сангийн богино болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөөг гаргах;
- Сангаас олгосон эрх мэдлийн хүрээнд хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргах;
- Сангийн хөрөнгө оруулалтын явц, хэрэгжилтэнд хяналт тавих;
- Сангийн хөрөнгө оруулалтын хяналтын болон эрсдэлийн удирдлагын стратеги, цогц хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохицуулах дүрэм журамд үнэлэлт дүгнэлт өгөх;
- Сангийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжийн бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлоход чиглэл өгөх;
- Үүссэн эрсдэлтэй нөхцөл байдал болон сангаас шаардлагатай гэж үзсэн бусад асуудалд дүн шинжилгээ хийх.

Дотоод хяналтын алба

Дотоод хяналтын алба нь “Ард Менежмент УЦК” ХХК-ийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд явж байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнадаг, өөрийн үйл ажиллагааны журамтай нэгж юм. Тус нэгж нь ээлжит болон ээлжит бүс шалгалтыг компанийн санхүү, хөрөнгийн удирдлага, дотоод үйл ажиллагаа гэсэн чиглэлээр тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг. Дотоод хяналтын алба нь 3 гишүүнтэй бөгөөд гишүүд нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр ажилладаг туршлагатай болно.



Хүснэгт 18. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн дотоод хяналтын албаны гишүүд

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил	Дотоод аудиторын гэрчилгээ
1.	М.Мөнх Эрдэнэ	ДХА-ны дарга	Санхүү, НББ	No.15063570
2.	Ө. Ашхүү	ДХА-ны гишүүн	Хуульч	
3.	С. Анаар-Эрдэнэ	ДХА-ны гишүүн	Эрх зүйч	

ДХА-ны дарга: М.Мөнх-Эрдэнэ

М.Мөнх-Эрдэнэ нь Мандах Бүртгэл Их Сургуулийг 2011 онд банк, санхүү, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2011-2012 онд "АПУ" ХК-д нягтлан бодогч, 2012-2014 онд "Хүлэгт Хүннү Аудит" ХХК-д туслах аудит, 2016 оноос хойш "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн дотоод аудитороор ажиллаж байна. 2015 онд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх, 2015 онд татварын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх, 2019 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрх бүхий аудиторын гэрчилгээ авсан болно.

ДХА-ны ажилтан: Өнөрбаянгийн Ашхүү

Ө.Ашхүү 1991 онд МУИС-ийн харьяа Математикийн Гүнзгий сургалттай ангийг төгссөн. 1993-2000 онд Унгар Улсын ЭЛТЭ Их Сургуулийн төр-эрх зүйн сургуульд хуульч мэргэжлээр суралцаж төгссөн. 2003 онд Отгонтэнгэр Их сургуулийг аж ахуйн эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2003-2004 онд "Хаан Бүргэд" ХХК-д менежер, 2004-2006 онд УИХ-ын тамгын газарт тамгын газрын ажилтан, гишүүний туслах, 2006 оноос Унгар Улсын Өргөмжит Консулын газарт консулын коллег, 2010-2014 онд "Бльюскай Партнерс" ХХК-д гүйцэтгэх захирал, 2015-2017 онд "Номын хишиг" ХХК-д гүйцэтгэх захирал, 2018 оноос "Ард Менежмент УЦК" ХХК-д хуулийн зөвлөхөөр тус тус ажиллаж байна.

ДХА-ны ажилтан: Сүхбаатарын Анаар-Эрдэнэ

С.Анаар-Эрдэнэ нь ерөнхий боловсролын Орчлон Сургуулийг 2009 онд төгсөж, 2011-2016 оны хооронд Бээжингийн Их Сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2016-2020 оны хооронд "Дачин" ХХН компанийд Паралегал-р ажиллаж байгаад 2020 оны 3 сараас эхлэн "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-д д хууль эрх зүйн хянан нийцүүлэлт эрхэлсэн захирлаар ажиллаж байна.

Гүйцэтгэх алба

"Ард Менежмент УЦК" ХХК-ийн ажиллагсад нь компанийн хамгийн чухал үнэт зүйл бөгөөд бид байгууллагын ирээдүйг тодорхойлогч, чадварлаг, байгууллагын хөгжлийг манлайлан хөгждөг, сэтгэл ханамжтай баг хамт олныг бүрдүүлж ажиллахыг зорьж ирсэн билээ. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндсэн зарчим нь нэг удирдлагатай, ажил үүргийн оновчтой хуваарилалт, удирдлага мэдээллээр сайн хангагддаг байх, ажилчид ажлын үр дүнг хэлэлцдэг байх, хяналт ил тод байх явдал гэж бид дүгнэдэг. Одоогоор Ард Менежмент нь 8 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.



Хүснэгт 19. "Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн ажилтан

№	Нэр	Албан тушаал	Мэргэжил	Сургууль
1.	Ч.Хандаа	Гүйцэтгэх захирал	Эдийн засагч	МУИС, Эдийн Засгийн Сургууль
2.	Г.Билэгсайхан	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Бизнесийн удирдлага	МУИС, Бизнес Сургууль
3.	Г.Мягмаржав	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Санхүү, менежмент	МУИС,
4.	Ч.Хандсүрэн	Санхүүгийн шинжээч	Санхүү, эдийн засагч	Чех Улсын Карлын Их Сургууль
5.	Э.Золбаяр	Санхүүгийн шинжээч	Эдийн засагч	МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль
6.	Ө.Ашхүү	Дотоод хяналтын ажилтан	Эрх зүйч	Унгар Улсын Элта Их Сургууль
7.	Г.Энхсаруул	Нягтлан бодогч	Нягтлан бодогч	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
8.	Б.Оюунсууд	Нягтлан бодогч	Нягтлан бодогч	Мандах Бүртгэлийн Дээд Сургууль

Гүйцэтгэх захирал: Боржигон овогт Чулуунбаатарын Хандаа

Ч.Хандаа нь 2005 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд 2006 оноос эхлэн одоогийн "Ард Секьюритиз ҮЦК" ХХК-д ажиллаж эхэлсэн. Ажиллах хугацаандаа 2006-2010 онд брокер, дилер, 2010-2012 онд хөрөнгийн зах зээлийн хэлтэсийн захирал, 2012 оноос гүйцэтгэх захиралаар тус тус ажилласан. 2015 оноос эхлэн "Ард Менежмент ҮЦК" ХХК-д гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. Ч.Хандаа нь 2018 оноос "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажлыг удирдаж амжилттай хэрэгжүүлсэн болно. 2019 оноос "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын сангийн менежерийг давхар гүйцэтгэж байгаа болно. Ч.Хандаа нь хөрөнгийн зах зээл, компанийн үнэлгээ, андеррайтер, судалгаа, шинжилгээ, санхүүгийн менежер зэрэг чиглэлүүдээр мэргэшсэн туршлагатай бөгөөд хөрөнгийн зах зээлд нийт 13 жил ажилласан билээ. Тэрээр, 2009 онд Санхүүгийн зах зээлийн холбооноос зохион байгуулсан Санхүүгийн зах зээл, Компанийн санхүү хөрөнгө оруулалт, 2011 онд Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп (London exchange group)-ээс зохион байгуулагдсан Хөрөнгийн зах зээлийн дунд болон гүнзгийрүүлсэн шатны сургалтанд амжилттай хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн.



3.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард Менежмент нь 2011 оны 9 сарын 6-ны өдөр гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгуулагдсан бөгөөд 2014 оны 12 сарын 3-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэж, компанийн үйл ажиллагааны чиглэлээр өөрчилсөн болно. Энэхүү шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2016 оны 2 сарын 24-ний өдөр баталгаажуулснаар Ард Менежмент нь хөрөнгө итгэмжлэн удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа албан ёсоор явуулж эхэлсэн болно.

Ард Менежмент нь 2018 оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах, удирдах, үл хөдлөх хөрөнгө болон үнэт цаасыг итгэмжлэн удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас зарласан төрийн өмчийн хувьчлалд оролцох, Засгийн Газрын үнэт цаас, нээлттэй компанийн бонд болон хувьцаанд хөрөнгө оруулалт хийх зорилгоор хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулахаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ажиллаж байна.

3.4 САНХҮҮ

“Ард Менежмент ҮЦК” ХХК нь 2019 оны байдлаар 378 сая төгрөгийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 17.4 хувь өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 20. “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баланс, аудитлагдсан, сая төгрөг

	2017	2018	2019
ХӨРӨНГӨ	480	322	378
Эргэлтийн хөрөнгө	27	102	34
Мөнгө	6	1	2
Бусад	21	100	33
Эргэлтийн бус хөрөнгө	454	221	343
Үндсэн хөрөнгө	1	4	2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	453	217	342
Бусад	-		0
ӨР ТӨЛБӨР	312	168	257
Богино хугацаат өр төлбөр	303	79	215
Урт хугацаат өр төлбөр	0	85	41
Хойшлогдсон татварын өр	9	3.7	1
ЭЗДИЙН ӨМЧ	169	154	121
Хувьцаат капитал	100	100	100
Хуримтлагдсан ашиг	(14)	20	12
Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	83	34	9

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн нийт хөрөнгийн 90.7 хувь буюу 343 сая төгрөг нь урт хугацаат хөрөнгө оруулалт байна.



Хүснэгт 21. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт, сая төгрөг

	2017	2018	2019
Урт хугацаат хөрөнгө оруулалт	453	217	342
"Ард Актив" ХЗХ	29	39	80
"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК	424	103	12
"Ард Даатгал" ХК		75	
"Үндэсний хувьчлалын сан" хамтын ХОС		250	

Ард Менежмент нь 2019 онд 217 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бөгөөд энэ нь өмнөх оноос 0.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин хөрөнгө оруулалтын орлого буурсантай холбоотой нийт орлого буурсан байна. Тайлант онд компани нь 7 сая төгрөгийн алдагдалтай, 31 сая төгрөгийн дэлгэрэнгүй орлоготой ажилласан.

Хүснэгт 22. "Ард Менежмент УЦК" ХХК-ийн орлогын тайлан, аудитлагдсан, сая төгрөг

	2017	2018	2019
ОРЛОГО	74	366	252
Борлуулалтын орлого	48	219	217
Хүүгийн Орлого	0	0	0
Бусад Орлого	27	146	35
ЗАРДАЛ	81	328	259
Хүний Нөөц	53	254	139
Үйл Ажиллагаа	28	68	91
Санхүүгийн Зардал	1	5	29
ВАЛЮТЫН ХАНШ ОЛЗ (ГАРЗ)	0	0	0
АШИГ (татвар өмнөх)	-7	38	-7
Татвар	-0.01	4	0
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	-7	34	-7
Х.О-ын үнэлгээний нөөц	92	38	42
Хойшлогдсон татвар	9	4	4
Нийт дэлгэрэнгүй орлого	76	68	31

2020 оноос Ард Менежмент нь үндсэн үйл ажиллагаа болох хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эхлүүлж ажиллахаар төлөвлөж байна.



4.3АХ ЗЭЭЛ

4.1 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн эдийн засаг

АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан, хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил удааширч, дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалт болон худалдааны эргэлт буурсантай холбоотой 2019 онд дэлхийн эдийн засгийн өсөлт саарсан. Үүнтэй холбоотойгоор Олон Улсын Валютын Сангаас 2020 оны 1 сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа “2019 онд Дэлхийн эдийн засгийг 2.9 хувь өссөн талаар урьдчилсан байдлаар тооцоолсон” байна. Харин Латин Америк, Ойрхи Дорнод, Европын хөгжиж буй орнуудын эдийн засаг сайжрахтай холбоотойгоор 2020 онд дэлхийн эдийн засаг 3.3 хувиар өсөх хандлагатай гэж таамаглажээ. Гэвч 2019 оны сүүлээр гарсан шинэ төрлийн Коронавирус (COVID-19) дэлхий даяар хурдтай тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн нь дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд эдийн засгийн өсөлтийн төсөөллөө бууруулахад хүргэж байна. Шинэ төрлийн Коронавирусийн нөлөөгөөр олон улсын нислэгүүд, нийлүүлэлтийн сүлжээ, үйлчилгээ, худалдаа зогсонги байдалд орж эхлэсэн бол цаашлаад улс орнууд хөл хороо тогтоосноор дэлхийн эдийн засагт томоохон хүндрэлүүд гарч эхлээд байгаа билээ. Хэдийгээр шинжээчид 2020 онд вирус гарахаас өмнө дэлхийн эдийн засгийг 3.3 хувь өснө гэж таамаглаж байсан бол вирус гарсны дараа -1.0 хувиас 1.4 хувийн хооронд өснө гэж таамаглалаа өөрчилсөн байна. Шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаар харилцан адилгүй байр суурьтай байгаа боловч дунджаар 0.3 хувь өснө гэж таамаглаж байна.

Хүснэгт 23. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь

	Бодит					Урьдчилсан		Төсөөлөл	
	2015	2016	2017	2018	2019	Вирусээс өмнө	Вирусийн дараа	2020	
Дэлхий	2.8	2.4	3	3.6	2.9	3.3	3.3	0.3	
Хөгжингүй орнууд	2.2	1.6	2.3	2.3	1.7	1.6	1.6		
АНУ	2.9	1.5	2.3	2.9	2.3	2	2	0.7	
Евро бүс	2.1	1.8	2.4	1.9	1.2	1.3	1.3	-2.4	
Япон	1.4	0.9	1.7	0.8	1	0.7	0.7		
Хөгжиж буй орнууд	3.6	3.7	4.3	4.5	3.7	4.4	4.4		
ОХУ	-2.8	-0.2	1.7	2.3	1.1	1.9	1.9		
БНХАУ	6.9	6.7	6.9	6.6	6.1	6	6	2.3	
Монгол Улс	2.4	1.2	5.3	6.9	6.5	5.4	5.4		

Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан, Монголбанк

Дэлхийн эдийн засгийн 19 хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засаг 2019 онд 6.1 хувь өссөн.

Олон Улсын Валютын Сангаас БНХАУ-ын эдийн засгийг 2020 онд 6 хувь өснө гэж таамаглаж байсан. Гэвч COVID-19 вирусын нөлөөгөөр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2020 оны эхний улиралд огцом агшсан бөгөөд Олон улсын хөрөнгийн корпорациас Хятадын эдийн засгийн өсөлтийг 2020 онд 2.6 хувьтай гарна гэж төсөөлсөн байна. Аху 2019 оны сүүлээр БНХАУ-д



COVID-19 вирус бүртгэгдэж, улмаар 1 сарын дундаас эрчимжсэнээр вирусын голомт болох Хубэй муйийн Вухан хот болон бусад 12 хотыг тугаарласан. Мөн БНХАУ даяар нийтдээ 760 сая хүнд хөл хорио тогтоосон байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд 3 сарын дундуур вирусийн тархалтыг хяналтдаа авч чадсан байна⁴. Блуумбергийн шинжээчид “БНХАУ энэ оны I улиралд вирусийг хяналтдаа авах бол харин Америк болон Европын холбооны орнууд II улирлын эцэст хяналтдаа авч, улмаар оны эхний хагаст Хятадын гадаад эрэлт сул байж оны сүүлийн хагаст сэргэнэ” гэж төсөөлж байна. 2020 оны 3 сарын 20-ны өдрийн байдлаар БНХАУ-ын эдийн засаг 85 хувиас дээш түвшинд ажиллаж байгаа бөгөөд аж үйлдвэрийн салбарын ажилчдын 80 гаруй хувь нь эргээд ажилдаа оржээ. Ийнхүү аж үйлдвэрийн салбар дахь ажиллах хүч нэмэгдэж байгаа нь эдийн засгийн салбарууд алгуур сэргэх найдлагыг бий болгож байна. Хятадын Ардын Банкнаас БНХАУ-ын эдийн засаг потенциал түвшиндээ хурдан эргэж очих боломжтой, эдийн засгийн сэргэлтийн мөчлөгийг “V” хэлбэртэй байх төлөвтэй гэж 2020 оны 3 сарын 23-ны өдөр мэдэгдсэн байна⁵.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2019 онд 2.3 хувь өссөн бөгөөд 2020 онд 2.0 хувиар өснө гэж Олон Улсын Валютын Сангаас төсөөлж байсан билээ. Үүнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж буй төсвийн тэлэх бодлогын нөлөөлөл ирэх онуудад саарах төлөвтэй байгаа нь голлон нөлөөлнө гэж үзсэн байна. Гэвч Коронавирусын нөлөөгөөр АНУ-ын эдийн засгийн төсөөлөл өөрчлөгдж байгаа бөгөөд Голдман Сакс тус улсын эдийн засгийг 2020 онд -0.6 хувь агшина гэж төсөөлсөн бол ЖэйПиМорган 1.8 хувиар өснө, Олон улсын санхүүгийн байгууллагууд дунжаар 0.7 хувиар өснө гэж таамаглаж байна. Холбооны нөөцийн банкны тэргүүн асан Б.Бернанке 2020 оны 3 сарын 25-ны өдөр CMBC телевизэд өгсөн ярилцлагадаа “АНУ-ын эдийн засаг хоёрдугаар улиралд огцом агших эрсдэлтэй ч, эргээд харьцангуй хурдан сэргэх боломжтойг илэрхийлсэн. Үүний тулд ажлын байрыг хамгаалах ёстойг онцолжээ. Түүнчлэн COVID-19 вирусийн тархалтыг хяналтад оруулах нь хамгийн чухал болохыг онцлоод, үүнийг хийхгүйгээр ямар ч төсөв, мөнгөний бодлого тус болохгүй анхааруулав. Энэ удаа вирусийн нөлөө санхүүгийн зах зээл дээр мэдрэгдэж паник савлагаа үүсгэж байгаа ч, 1930-аад оны Их хямрал, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас ялгаатай учраас вирусийг хяналтад оруулсан тохиолдолд төсөв, мөнгөний бодлогоор даамжирсан уналтаас сэргийлж, эдийн засгийг хурдтай сэргээх боломжтойг” дурджээ.

Худалдааны маргаан, БНХАУ-ын эдийн засгийн бууралт, Германы үйлдвэрлэлийн салбарын удаашралт, Брекситтэй холбоотой тодорхой бус байдал зэрэг нь Евро бүсийн 2019 оны эдийн засгийн өсөлтийг сааруулж буй гол хүчин зүйлс болж байна. Олон Улсын Валютын Сангаас гаргасан тайландаа 2019 онд Евро бүсийн эдийн засаг 1.2 хувь өссөн гэж тооцоолсон байна. 2016 оны 6 сард Их Британид болсон бүх нийтийн санал асуулгаар нийт иргэдийн 52 хувь нь Европын Холбооноос гарах санал өгсөн билээ. Ингэснээр 1973 онд Европын Холбоонд нэгдэж байсан анхны гишүүдийн нэг болох Их Британи нь 2020 оны 1 сарын 31-ний өдөр албан ёсоор Европын Холбоог орхив. Одоо Их Британи болон Европын хоорондын харилцаа цаашдаа ямар

⁴ www.nytimes.com

⁵ Монголбанк “Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтийн товч”





түвшинд байхыг шийдэх “шилжилтийн үе” ирээд байгаа бөгөөд энэ хугацаанд худалдааны хэлэлцээр болон бусад дүрэм, журам, стандартууд дээр тохиролцох шаардлагатай⁶. ОУВС-аас 2019 оны сүүлч, 2020 онд Германы автомашин үйлдвэрлэлийн бууралт болон Францын үймээн зэрэг асуудлууд намжиж, гадаад эрэлт сэргэснээр евро бүсийн эдийн засаг 2020 онд 1.6 хувиар өснө гэж үзэж байв. Гэвч эдийн засгийн нөхцөл байдал хувьсан өөрчлөгдсөнтэй холбоотойгоор шинжээчид Евро бүсийн эдийн засгийг 2020 онд дунджаар -2.4 хувь агшина гэж таамагласан байна. Хэдийгээр Евро бүсийн эдийн засаг агших хүлээлттэй байгаа боловч 2021 онд 7.8 хувиар өснө гэж Голдман Сакс таамагласан байна.

Дэлхийн санхүүгийн зах зээл

2019 онд худалдааны маргаан тойрсон тодорхой бус байдал үргэлжилсээр байсан нь санхүүгийн зах зээлийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байв. Гэхдээ АНУ болон БНХАУ үлсууд худалдааны хэлэлцээрт хүрэх хүлээлттэй байсан 2019 оны эхний хагаст хөрөнгийн зах зээлийн гол индексүүд оны эхнээс өссөн үзүүлэлттэй байсан ч 5 болон 8 сард худалдааны маргаан хурцадсанаар хөрөнгийн зах зээл хүчтэй савлахад хүрэв. Гэвч 2019 онд дэлхийн томоохон хөрөнгийн биржүүдийн индексүүд өсөлттэй байсан бөгөөд тухайлбал, S&P 500 өмнөх оны мөн үеэс 28.8 хувь, FTSE 100 индекс 12.1 хувь, NIKKEI 25 индекс 18.2 хувиар тус тус өсч хаагдсан байна. Мөн дэлхийн эдийн засагт тулгараад буй тодорхой бус байдлаас үүдэн засгийн газрын бондын өгөөж буурсан байна.

2020 он гарсаар дэлхийн санхүүгийн зах зээлд шинэ төрлийн Коронавирусээс үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүд сүүлийн 1 сарын хугацаанд 30 хувиар буурлаа. Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөд эх үүсвэрээ байршуулж эхэлснээр улс орнуудын засгийн газрын бонд болон компаниудын бондын үнэ үнаж, өгөөж нь огцом өслөө. Улс орнууд COVID-19 вирусийн эдийн засагт үзүүлэх үр дагаврыг бууруулах зорилгоор төсвийн болон мөнгөний бодлогын арга хэмжээг шуурхай авсаар байна. Тухайлбал, 2020 оны 3 сарын 26-ны өдрийн байдлаар нийт 40 орчим улсын Төв Банк бодлогын хүүгээ бууруулах шийдвэр гаргасан байна. Харин АНУ-ын Холбооны нөөцийн банк болон Европын төв банк зэрэг дэлхийн томоохон төв банкууд үнэт цаас худалдаж авах хөтөлбөрийг баталж, зах зээлд их хэмжээний мөнгөн хөрөнгийг нийлүүлж байна.

Үл уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн чиг хандлага

Зэс

Дэлхийн зэсийн эрэлт 2018 онд 23.87 сая тн⁷ байсан бөгөөд цаашдаа жилд дунджаар 2.6 хувиар өсч, 2027 онд 29.8 сая тн-д⁸ хүрнэ гэж шинжээчид үзэж байна. Харин зэсийн нийлүүлэлт 2018 онд 23.63 сая тонн хүрсэн нь зэсийн эрэлтийг бүрэн хангаж чадаагүй тул зэсийн хомсдол үүссэн байна. Перугийн уурхайн өргөтгөл, Индонезийн хамгийн том уурхай

⁶ <https://www.bbc.com/news/uk-politics-32810887>


⁷ <http://www.coppercouncil.org/iwcc-supply-and-demand-forecasts-november-2019>

⁸ <https://www.mining.com/global-copper-market-supplied-demand-rise-report/>



Грасбергийн үүрхай үйл ажиллагааг сайжруулсан зэрэг нь богино хугацаанд зэсийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиг хандлагатай байгаа боловч урт хугацаандаа зэсийн хомсдол нэмэгдсэн хэвээр байхаар байна. Гэвч зэсийн үнэд эрэлтээс гадна худалдааны дайнаас үүдэлтэй тодорхой бус байдал ихээр нөлөөлж байна. Мөн зэсийн нийт эрэлтийн 50 орчим хувийг БНХАУ бүрдүүлдэг бөгөөд тус улсын зэсийн хэрэглээ тогтвортож байна. Эдгээр хүчин зүйлсээс үүдэн зэсийн үнэ 2017 оноос хойш хамгийн доод түвшиндээ хүрээд байсан бөгөөд 2019 оны 4 улиралд ялимгүй өсч 6,077 долларын ханшид хүрч хаагдлаа.

График 6. Зэсийн үнэ, доллар/тн



Эх сурвалж: ОУВС, Copper, grade A cathode, LME spot price, CIF European ports, US\$ per metric ton


Монгол Улсын Засгийн Газар 2020 оны төсвийн төсөлд нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,991 доллар байхаар төсөөлжээ. Гэвч COVID-19 вирусийн нөлөөгөөр зэсийн эрэлт буурсаар 2020 оны 3 сарын 24-ний өдрийн байдлаар 4,811 долларт хүрсэн байна. БНХАУ-ын Сангийн Яамнаас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ нь зэсийн үнэ ханшинд эерэгээр нөлөөлөх боломжтой юм.

Алт

Дэлхий дахинд нийгэм, эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, геополитикийн асуудлууд, тэр дундаа АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан, хөгжингүй орнуудын Төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний зөвлөн бодлого, Их Британи Европын холбооноос гарсан зэрэг дэлхийн эдийн засагт үүсээд байгаа нөхцөл байдлууд нь хөрөнгө оруулагчдын алт худалдаж авах сонирхолыг нэмэгдүүлж, алтны үнийг өсөхөд нөлөөлж байна. 2019 оны жилийн эцсээр 1 трой үнц алтны ханш (LBMA) 1,476 доллараар хаагдсан нь өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өссөн үзүүлэлт юм.



График 7. Алтны ханш, доллар/трой унц




Эх сурвалж: OUBC, Gold, Fixing Committee of the London Bullion Market Association, London 3 PM fixed price, US\$ per troy ounce

Олон улсын шинжээчид алтны үнийг 2020 онд үргэлжлэн өсч, 1,545 долларт хүрнэ гэж таамаглаж байна.⁹ Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаагаас аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтын ханш нэмэгдэж байна. 2020 оны 3 сарын 24-ний өдрийн байдлаар 1 унц алтны үнэ 1,632 долларт хэдийнээ хүрсэн байна.

Нүүрс

Парисын Агаарын бохирдол болон дэлхийн дулаарлын эсрэг хэлэлцээрийн дагуу ихэнх орнууд тэр дундаа АНУ ?? болон Европын улс орнууд нүүрсний хэрэглээгээ бууруулах төлөвтөй байна. Тухайлбал, АНУ-ын эрчим хүч хангагчид нүүрсээр ажилладаг станцуудын үйл ажиллагааг зогсоож, сэргээгдэх эрчим хүчээр орлуулах болсноор 2018 онд нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэл 40 хувиар буурсан. Харин дэлхийд нүүрсний хэрэглээгээрээ тэргүүлэгч Хятад болон Энэтхэг улсуудын нүүрсний хэрэглээ ойрын жилүүдэд буурах төлөвгүй байна. Эрчим хүчиний нүүрсний эрэлтийн энэхүү огцом уналтай холбоотойгоор нүүрсний спот үнэ 2018 онд тонн нь 106 доллар байсан бол 2019 оны жилийн эцэст 70 доллар болж, 33.6 хувиар буурчээ.

График 8. Нүүрсний үнэ, доллар/тн



Эх сурвалж: OUBC, Coal, Australian thermal coal, 12,000- btu/pound, less than 1% sulfur, 14% ash, FOB Newcastle/Port Kembla, US\$ per metric ton

⁹ Улсын төсөв 2020




Харин манай Засгийн Газар 2020 оны төсөвт нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 75.5 доллараар тооцож, мөн гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж дуусгаснаар боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэн ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолж, 1.5 их наяд төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээр тооцжээ. Гэвч COVID-19 вирусийн нөлөөгөөр нүүрс экспорт 2020 оны 2 сарын 11-ний өдрөөс 3 сарын 22-ны өдрийг хүртэл түр зогссон байна.

БНХАУ-ын Засгийн Газраас зарим мужуудын хүчин чадал бага, үр ашиг муутай нүүрсний уурхайнуудыг хааж, түүнчлэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор тус улсын коксжих нүүрсний импорт сүүлийн 3 жил дараалан өсөөд байсан билээ. Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт болон нийлүүлэлт талын шок болох Австрали улсад болсон уурхайн асуудал зэргээс үүдэн 2018 оны эхэнд Австралийн коксжих нүүрс 1 тн нь 260 доллар хүртэл өссөн боловч буцаад 170 доллар хүрч буурсан. Коксжих нүүрсний үнэ нэлээд хэлбэлзэж байгаад 2019 оноос тоторжиж эхэлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 1 тн нь 121.4 долларт хүрсэн байна. Коксжих нүүрсний үнийн хувьд 2019 он мөн уналттай байлаа. Энэхүү уналт нь дэлхийн зах зээлийн тодорхойгүй байдал, Хятадын гангийн үйлдвэрлэлийн саармагжилт болон гангийн үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа буурсн зэргээс шалтгаалж байна¹⁰. Цаашид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч байгаа, худалдааны маргаан зэргээс үүдэн шинжээчид Австралийн коксжих нүүрсний үнийг буурч, 2020 онд 154 долларт хүрнэ гэж төсөөлж байна. 2020 оны 3 сарын 24-ний өдрийн байдлаар 1 тн коксжих нүүрс 160 доллартай байна.

Төмрийн худэр

БНХАУ болон бусад хөгжиж буй орнууд дэд бүтцийн зардлаа өсгэж ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлсэн нь 2018, 2019 онуудад гангийн эрэлтийг эрс нэмэгдүүлсэн. Нөгөөтэйгүүр төмрийн худрийн томоохон нийлүүлэгч болох Бразил, Австрали зэрэг улсуудад байгалийн гамшигт үзэгдэл болсноос үүдээд зах зээлд хомсдол үүсэж, 2019 онд үнэ огцом өссөн.

График 9. *Төмрийн худрийн үнэ, доллар/тн*



¹⁰ <https://steelguru.com/coal/coking-coal-price-outlook-diis/554891>



Эх сурвалж: ОУВС, China import Iron Ore Fines 62% FE spot (CFR Tianjin port), US dollars per metric ton

Харин 2019 оны сүүл 2020 оны эхээр төмрийн хүдрийн томоохон экспортлогч орон болох Австрали болон Бразилийн Vale SA болон Fortescue Metals Group-ийн төмрийн хүдрийн нийлүүлэлт эргэн сэргэх төлөвтөй байгаа тул шинжээчид үнийг бууран 73 долларт хүрнэ гэж төсөөлж байгаа. Цаашдаа олон улсын шинжээчид Энэтхэг болон Бразилийн гангийн үйлдвэрлэлүүд БНХАУ-тай зэрэгцэхүйц хэмжээний гангийн гол үйлдвэрлэгчид болно гэж үзэж байгаа ба одоогийн байдлаар БНХАУ 84.2 сая тонн ган үйлдвэрлэж, төмрийн хүдрийн хэрэглээгээрээ 1 дүгээрт бичигдээд байгаа бол Энэтхэг улс 2 дугаарт буюу 9.2 сая тонн, Бразил улс 2.4 сая тонныг үйлдвэрлэж 9 дүгээрт бичигдэж байна.

Хятадад вирус хяналтад орж, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаанд шилжиж байгаатай холбоотойгоор гангийн үйлдвэрлэл сэргэж, үнэ өсч, нүүрсний хаагдсан байсан үүрхайнууд нээгдэж эхэлж байна. 2020 оны 3 сарын 20-ны өдрийн байдлаар гангийн нөөц буурч, бүтээгдэхүүний үнэ сэргэж эхэлсэн байна.



4.2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд 2018 онд огцом сайжирсан бөгөөд энэхүү байдал 2019 оны эхний хагаст хэвээр хадгалагдсан боловч оны сүүлээр саарлаа. 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүн (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.1 хувиар өслөө. Энэ өсөлтэд уул үүрхайн бус салбар голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн салбар 8.4 хувь, худалдаа 7.2 хувь, санхүүгийн салбар 10.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин оны эхний хагаст 13 хувиар өсч байсан уул үүрхайн салбарын үйлдвэрлэл удааширч 2019 оны эцэст 0.6 хувиар буурлаа.

Хүснэгт 24. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, салбараар, хувь

	2015	2016	2017	2018	2019
Дотоодын нийт бүтээгдэхүүн	2.4%	1.2%	5.3%	7.2%	5.1%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	10.7%	6.2%	1.8%	4.5%	8.4%
Уул үүрхай, олборлолт	14.1%	0.2%	-5.5%	6.1%	-0.6%
Боловсруулах үйлдвэрлэл	2.6%	-0.8%	19.9%	15.7%	11.0%
Цахилгаан, усан хангамж	0.9%	-2.8%	9.3%	5.9%	6.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	-8.1%	-2.6%	6.8%	2.2%	7.2%
Тээвэр, мэдээлэл	2.9%	6.6%	14.0%	7.6%	4.7%
Санхүүгийн болон даатгал	14.6%	2.3%	9.1%	5.5%	10.3%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.3%	0.6%	3.8%	4.4%	3.3%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-22.1%	0.5%	18.5%	20.1%	5.4%

Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг задаргаагаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 1.1 нэгж, худалдаа 0.9 нэгж, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 0.7 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлсэн бол уул үүрхайн салбар 0.1 хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 25. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, түүний задаргаа, хувь

	2015	2016	2017	2018	2019
Дотоодын нийт бүтээгдэхүүн	2.4%	1.2%	5.3%	7.2%	5.1%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	1.3%	0.8%	0.2%	0.6%	1.1%
Уул үүрхай, олборлолт	3.2%	0.0%	-1.4%	1.3%	-0.1%
Боловсруулах үйлдвэрлэл	0.2%	0.0%	1.1%	1.0%	0.8%
Цахилгаан, усан хангамж	0.0%	-0.2%	0.5%	0.3%	0.3%
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.1%	-0.3%	0.8%	0.3%	0.9%
Тээвэр, мэдээлэл	0.3%	0.6%	1.3%	0.8%	0.5%
Санхүүгийн болон даатгалын	0.8%	0.1%	0.6%	0.4%	0.7%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.3%	0.1%	0.5%	0.6%	0.4%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-2.5%	0.0%	1.6%	2.0%	0.6%

Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

Цаг агаарын нөхцөл харьцангуй таатай, малын тоо толгой огцом өссөн, үр тарианаас бусад газар тариалангийн бүтээгдэхүүнүүд өсөлттэй байсан зэрэг нь хөдөө аж ахуйн салбарыг 8.4



хувиар өсөхөд нөлөөлж, энэ нь ДНБ-ийн өсөлтөд 1.1 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлсэн байна. Уул уурхай, олборлох салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 0.6 хувиар буурлаа. Энэхүү бууралтад алт, хайлуур жоншны баяжмалын олборлолт буурсан нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж муудсан, 2019 оны 3 сараас алтны роялти татварыг нэмэгдүүлсэн зэрэгтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэл 21.3 хувиар буурсан байна. Нүүрний тухайд үнэ алгуур буурах хандлагатай байсан ч үйлдвэрлэл, экспортын хэмжээ харьцангуй сайн гүйцэтгэлтэй байлаа.

Тайлант хугацаанд гадаад худалдааны тэнцэл сайжирч, цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. 2019 онд экспорт хурдтай өсч (8.7 хувь), импортын өсөлт огцом саарсан (4.3 хувь)-тай холбоотой гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум долларын ашигтай гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 26. Гадаад худалдаа, сая доллар

	Жилээр					Өөрчлөлт	
	2015	2016	2017	2018	2019*	2018	2019
Эргэлт	8,467	8,274	10,536	12,887	13,747	22.3%	6.7%
Экспорт	4,669	4,916	6,201	7,012	7,620	13.1%	8.7%
Импорт	3,798	3,358	4,335	5,875	6,127	35.5%	4.3%
Тэнцэл	872	1,558	1,866	1,137	1,493	-39.1%	31.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт уул уурхайн экспортын 45.6 хувийг дангаараа бурдүүлсэн нүүрний экспортын биет хэмжээ болон үнийн дүн өндөр байсан зэрэг нь экспортыг өсөхөд голлон нөлөөллөө. Нөгөө талаас, импорт, хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулах зорилгоор 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн макро зохицой бодлого үр дүнгээ өгч, боловсруулах салбарын өсөлт удааширсан зэргээс шалтгаалан импортын өсөлт ийнхүү буурчээ. Монгол Улс 2019 онд нийт 152 үлстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум долларт хүрч өмнөх оноос 6.7 хувиар өссөн байна. 2019 оны гүйцэтгэлээр 7.6 тэрбум долларын экспорт хийснээс 89 хувь нь БНХАУ-руу экспортлосон бол нийт импортын 33.6 хувь нь БНХАУ-аас, 28.2 хувь нь ОХУ-аас импортлосон байна.

Төлбөрийн тэнцэл 2018 онд 141.7 сая долларын алдагдалтай байсан бол 2019 онд сайжирч, 452.9 сая долларын ашигтай гарчээ. Төлбөрийн тэнцэл сайжирсан гол шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн, “Монголын Ипотекийн Корпораци” ХК нь 300 сая долларын бонд амжилттай гаргасан зэргийг дурьдаж болно. Тухайлбал, урсгал дансны алдагдал 2018 онд 2.2 тэрбум долларын алдагдалтай гарч байсан бол 2019 онд гадаад худалдааны тэнцэл сайжирсантай холбоотой -1.8 сая доллар хүрч алдагдал буурсан байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.1 тэрбум долларт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад тогтвортой байсан, Монголын Ипотекийн Корпораци 2019 оны 1 сард гадаад бонд гаргасан нь багцын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн зэрэг нь санхүүгийн дансны тэнцлийг ашигтай гарахад нөлөөлсөн байна. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын улсын



нөөцийг нэмэгдүүлж, 2019 оны жилийн эцсээр 4.3 тэрбум долларт хүрсэн бөгөөд энэ нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 7 орчим сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 27. Төлбөрийн тэнцэл, сая доллар

	Үнийн дүн						Өөрчлөлт	
	2015	2016	2017	2018	2019	2018	2019	
Ургал данс	(948)	(700)	(1,155)	(2,207)	(1,813)	91.0%	-17.8%	
Хөрөнгийн данс	116	91	78	92	117	18.3%	27.0%	
Санхүүгийн данс	788	812	2,599	2,091	2,375	-19.6%	13.6%	
ГШХО	83	-4,171	1,446	2,137	2,086	47.8%	-2.4%	
Төлбөрийн тэнцэл	(268)	(18)	1,460	(142)	453	-109.7%	-419.6%	

Эх сурвалж: Монголбанк

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2019 онд 628 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, ДНБ-ийн 1.7 хувьд хүрсэн байна. Хэдийгээр улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарсан ч 2016 оноос хойш уг алдагдал тогтвортой буурч байна. Тухайлбал, 2016 онд төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал ДНБ-ийн 15.3 хувьтай тэнцэж байсан бол 2017 онд эрс буурч, 2018 онд ашигтай гарч байсан билээ. Төсвийн нөхцөл байдал сайжрахад нийт орлого өссөн, засгийн газраас төсвийн ургал болон хөрөнгийн зарлагад тавьсан хяналт үр дүнтэй болсон зэрэг нь чухал нөлөө үзүүлсэн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2019 онд 10.8 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 17.0 хувь, тайлант хугацааны орлогын төлөвлөгөөнөөс 9.9 хувиар давж биеллээ¹¹. Орлого төлөвлөснөөс давж биелэхэд үүл үүрхай салбар, тэр дундаа нүүрсний салбарт эерэг үзүүлэлтүүд гарсан мөн орлого бүрдүүлэлт сайжирсан зэргээр тайлбарлагдахаар байна¹². Харин нөгөө талдаа төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 2019 онд 11.4 их төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 23.9 хувиар их, тайлант хугацааны зардлын төсвөөс 1.4 хувиар бага биелсэн байна.

Хүснэгт 28. Улсын төсөв, тэрбум төгрөг

	Үнийн дүн						Өөрчлөлт	
	2015	2016	2017	2018	2019	2018	2019	
Тэнцвэржүүлсэн орлого	5,974	5,852	7,239	9,235	10,802	27.6%	17.0%	
Нийт зарлага ба цэвэр зээл	7,137	9,520	8,981	9,223	11,429	2.7%	23.9%	
Төсвийн тэнцэл	(1,163)	(3,668)	(1,742)	12	(628)			

Эх сурвалж: YCX

Мөнгөний нийлүүлэлт 2019 онд 6.8 хувиар өсөж, 20.8 их наяд төгрөгт хүрэв. 2016 онд 31.3 хувь өсч байсан мөнгөний нийлүүлэлт 2019 онд 6.8 хувиар өссөн нь мөнгөний бодлогын төлөв чангарч эхэлсний илтгэж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төгрөгийн харилцах,

¹¹ Улсын Их Хурлын Тамгын Газар “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны урьдчилсан гүйцэтгэлийн товч танилцуулга

¹² Дэлхийн банк “Монголын эдийн засгийн тойм”



хадгаламж 6.4 хувь, гадаад валютын харилцах, хадгаламж 9.8 хувиар өссөн нь голлон нелөөлсөн.

Хүснэгт 29. Мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөг

	Үнийн дүн				Өөрчлөлт		
	2015	2016	2017	2018	2019	2018	2019
M2 мөнгө	10.1	12.1	15.9	19.5	20.8	22.8%	6.8%
Төгрөгийн харилцах, хадгаламж	6.7	7.3	10.8	13.5	14.4	24.7%	6.4%
Гадаад валютын харилцах, хадгаламж	2.9	4.2	4.4	5.3	5.8	19.8%	9.8%
Банкнаас гадуурх мөнгө	0.5	0.6	0.6	0.7	0.6	9.6%	-8.4%

Эх сурвалж: Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, YCH

Монголбанк төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хамгаалах, макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор 2018 оны 11 сард бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмж 11 хувьд хүргэсэн. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд, Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувьд хэвээр хадгалах, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 15 хувиар тогтоо шийдвэрийг гаргалаа.

Харин Covid-19 вирусийн эдийн засагт үзүүлэх үр дагаварыг бууруулах зорилгоор дэлхийн олон оронд төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээг авч ажиллаж байгаа билээ. Үүний нэгэн адил Монголбанкнаас 3 сарын 11-ний өдөр мөнгөний бодлогыг зөвлөх шийдвэр гаргалаа. Шийдвэрээр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж 8.5 хувьд тогтоо болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөхөөр болов.


2019 онд улсын инфляцийн түвшин Монголбанкны зорилtot түвшин болох 8 хувиас бага буюу 5.2 хувьтай байлаа. Эдийн засгийн идэвхжил буурахын хэрээр өрхийн хэрэглээ буурч мөн мөнгөний нийлүүлэлт агшсанаас шалтгаалан¹³ 2014 оны 7 сард 14.9 хувь хүрч байсан инфляци эрчимтэй буурсаар 2016 оны 10 сард -0.2 хувь буюу дефляци болсон юм. Харин 2017 оноос инфляци нэмэгдэж сүүлийн 2 жил 5-9 хувийн хооронд хэлбэлзэж байна.

¹³ <https://ikon.mn/n/ske>





График 10. Инфляци, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувь



Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцийн түвшинг тогтвортжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт болон аль нэг салбар, бүтээгдэхүүн эсхүл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдахад чиглэсэн арга хэмжээг бодлогын хүйтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Эдийн засгийн идэвхжлийн үр дүнд өрхийн бодит орлого үргэлжлэн нэмэгдэж байгаа ч эрэлтийн гаралтай инфляци харьцангуй тогтвортой байна. Харин нийлүүлэлтийн шалтгаантай үнэ нь өөрчлөгдж буй цөөн бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт инфляцийн хэлбэлзлийг голлон тайлбарласан хэвээр байна. Цашид буюу 2020 онд инфляци Монголбанкны дунд хугацааны зорилтот түвшин болох 6%-д тогтвожих төлөвтэй байна.¹⁴

Инфляцийг тодорхойлдог хэрэглээний сагсны нийт жингийн 57.1 хувийг хүнсний бараа, хувцас, тээвэр бүрдүүлж байна. 2019 оны 5.2 хувийн инфляцийн 3.3 пунктыг хүнсний бараа болон хувцасны үнийн өсөлт бүрдүүлжээ.

Хүснэгт 30. Инфляцийн бүлгүүдийн оролцооны түвшин, жилийн эцсээр

Бараа, үйлчилгээний бүлэг	ЖИН	2016	2017	2018	2019
Ерөнхий индекс	100	1.3	6.4	8.1	5.2
Хүнсний бараа, ундаа, үс	26.1	0.4	1.8	2.3	2.1
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0	0.2	0.3	0.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.4	0.7	0.8	1.2
Орон сууц, үс, цахилгаан,	9.3	0.2	0.7	1.6	0.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.3	0.3	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.3	0.4	0.1
Тээвэр	14.4	-0.2	1.5	1.4	-0.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-0.1	0	0	0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0	0.1	0.3	0.3

Эх сурвалж: УСХ

Тэмдэглэл: Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт




Боловсролын үйлчилгээ	4.8	0.2	0.3	0.3	0.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	3	0	0.1	0.2	0.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.1	0.4	0.2	0.3

2019 онд валютын ханш харьцангуй тогтвортой байлаа. 2019 оны 1 сарын 2-ны өдөр доллар болон юанийн албан ханш 2,648 болон 386 төгрөг байсан бол 2019 оны 12 сарын 31-ний өдөр доллар 2,734 төгрөг, юань 392 төгрөгтэй тэнцэж байна. 2016 оны суулийн хагаст гадаад валютын албан нөөц (цаашид ГВАН гэх) шавхагдаж, улсын төсөв өндөр алдагдалтай байж төгрөгийн ханш маш их суларч байсан. Улмаар Монголбанкнаас ГВАН-ийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2016 оны гуравдугаар улиралд ГВАН 1 тэрбум доллар байсан бол 2019 оны 12 сард 4.3 тэрбум долларт хүрээд байна.

ГВАН тогтмол нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл эерэг байгаа хэдий ч төгрөгийн ханш аажмаар суларсаар байна. Төгрөгийн ханшийн сурал нь урсгал дансны өндөр алдагдалтай холбоотой байдаг¹⁵. Урсгал дансны тэнцэл гэдэг нь энгийнээр гадаадад худалдах бараа, үйлчилгээ, шилжүүлгийн орлогоос гаднаас авдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн төлбөрийг хассан цэвэр дүн юм. Урсгал данс алдагдалтай байгаа нь валютын орлого гадагшаа төлж буй валютаа хангаж чадахгүй байгааг илэрхийлж буй юм. Урсгал данс байнгын алдагдалтай байгаа бөгөөд 2019 онд 1.8 тэрбум долларын алдагдалтай байна.

График 11. *Доллар болон юанийн ханш*



Эх сурвалж: Монголбанк

¹⁵ <https://www.mongolbank.mn/news.aspx?tid=2&id=2449>



2020 -08- 24

ARD МЕНЕДЖМЕНТ-03
КОМПАНИ

Монгол Улсын эдийн засгийн цаашдын чиг хандлага

Монгол Улсын эдийн засаг 2017 оноос хурдтай сэргэж эхэлсэн бөгөөд үүнд төсвийн гүйцэтгэл сайн гарч, макро эдийн засгийн бодлогын уялдаа сайжирч, түүхий эдийн үнэ харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувиар тус тус өссөн байна. Гэвч түүхий эдийн үнэ дэлхийн зах зээлд алгуур буурсны зэрэгцээ гол экспортын бүтээгдэхүүний чанар нь муудсан зэрэг шалтгаанаар уул уурхайн салбар агшиж, Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онд 5.1 хувь болж буурав¹⁶. Цаашид Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2020 болон 2021 онд өмнөх оноосоо яльгүй саарах ч тогтвортой түвшинд хадгалагдана гэж дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд үзэж байсан билээ. Тухайлбал, Дэлхийн банкнаас 2020 оны 2 сард гаргасан тайландаа “Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдийнхээс бага зэрэг саарсан ч дунд хугацааны төлөв зэрэг хэвээр байх талаар тусгасан байна. Мөн 2020-2021 онд хувийн хэрэглээний тогтвортой өсөлт, уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эдийн засаг дунджаар 5.6 хувиар өсөх төлөвтэй байна гэжээ. Гэвч дэлхий даяар хурдтай тархаж цар тахлын хэмжээнд хүрээд байгаа COVID-19 вирусийн улмаас эдийн засгийн төсөөлөл өөрчлөгдөж байгаа билээ. Учир нь Монгол Улсын эдийн засаг түүхий эдийн үнийн савалгаа, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт зэрэг гадны хүчин зүйлүүдээс нэлээд мэдрэмтгий байдаг бөгөөд уг вирусийн улмаас БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удааширал нь Монгол Улсын экспортийн салбарт ихээхэн нөлөөлөхөөр байна. Дэлхийн Банкнаас 2020 оны 4 сарын 2-ны өдөр гаргасан Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг COVID-19 тархалтын үед сэдэвт эдийн засгийн тоймд¹⁷ 2020 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллийг 2.4 хувь, хамгийн муу нөхцөл байдалд 1 хувь байна гэж таамаглав. Гэвч Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2021 онд 5.1 хувь, 2022 онд 5.4 хувь байхаар эерэгээр төсөөлсөн байна.

¹⁶ Дэлхийн банк “Монголын эдийн засгийн тойм”


¹⁷ www.worldbank.org



4.3 МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2016 оноос Монгол Улсын эдийн засаг сайжирч, зах зээлд компаниуд шинээр хувьцаа гаргаж эхэлснээр үнэт цаасны зах зээл тогвортой өсч эхэлсэн билээ. Тухайлбал, 2019 онд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ (МХБ-д бүртгэлтэй компани) 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь түүхэн дэх хамгийн өндөр түвшин байв. Зах зээлийн үнэлгээ нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хэмжээ, үнэлгээг илэрхийлдэг бөгөөд энэхүү үзүүлэлт өндөр байх тусам эдийн засгийг бүрдүүлэгч компаниудын тоо нэмэгдэж байгаа эсхүл түүний хувьцааны ханш өсөж байгааг харуулдаг. 2019 онд зах зээлийн үнэлгээ өмнөх онтой харьцуулахад 7.3 хувь, 2016 онтой харьцуулахад 82.5 хувиар тус тус өссөн байна.


График 12. Зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

Үнэт цаасны зах зээл хэр хөгжсөн болон хүчин чадал багтаамжийг нь тодорхойлохын тулд үнэт цаасны зах зээлийн үнэлгээг тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулж тооцдог билээ. Тухайлбал, 2019 онд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ-тэй харьцуулсан харьцаа 7.3 хувьтай байсан бөгөөд энэ нь Монгол Улсын ДНБ-ийн 7.3 хувь нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээг илэрхийлж байгааг харуулж байна.

График 13. Зах зээлийн үнэлгээ/ДНБ, хувь



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо


Мөн сүүлийн жилүүдэд уг харьцааг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бодит үнэ цэнээсээ өндөрөөр үнэлэгдсэн эсхүл багаар үнэлэгдсэнийг тодорхойлоход ашиглаж эхэлсэн байна.



Тухайлбал, уг харьцаа нь 50 хувиас бага байвал үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бодит үнэ цэнээсээ бага үнэлэгдсэнийг илтгэдэг бөгөөд эдийн засаг үнэт цаасны зах зээлд хангалттай хөрөнгө оруулах боломжтой гэж үзэн хувьцааны ханш өсөх чиг хандлагыг харуулдаг байна.

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хувьцааны ханшийн өсөлт, бууралтыг харуулдаг ТОП-20 индекс 2019 онд 19,621.9 нэгжид хүрч, өмнөх оноос 8.6 хувиар буурсан ч 2016 онтой харьцуулахад 57.5 хувиар өссөн хэвээр байв. ТОП-20 индексийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас идэвхтэй арилжаалагддаг, хамгийн үнэлгээ өндөр 20 компанийн хувьцааны ханшид суурilan гаргадаг бөгөөд энэхүү үзүүлэлт нь үнэт цаасны зах зээл дэх хувьцааны ханшийн өсөлт, бууралтыг харуулдаг. 2019 оны байдлаар ТОП-20 индексийн хүрсэн дээд үзүүлэлт 21,888.2 нэгж, доод үзүүлэлт 17,922.8 нэгж, дундаж үзүүлэлт 19,978.1 нэгж болсон байна.


График 14. ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

2019 онд нийт 143.2 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдсанаас 133.5 тэрбум төгрөг нь хувьцаа, 9.7 тэрбум төгрөг нь Засгийн Газрын үнэт цаасны арилжаа байв. МХБ-ээр нийт 133.5 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 36.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 15. Хувьцааны арилжаа, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

Зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулж тооцох нь үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварыг буюу зах зээл дэх арилжааны идэвхийг харуулдаг.



График 16. Зах зээлийн хөрвөх чадвар, хувь




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

2019 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар 5.0 хувьд хүрсэн бөгөөд энэ нь хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компаниудын нийт хувьцааны 5.0 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааны арилжаа 2019 онд хийгдсэн гэсэн үг юм. Хөрвөх чадварын харьцаа бусад хөгжжик буй орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур түвшинд байгаа бөгөөд энэ нь компанийн хувьцаа хэт төвлөрсөнтэй холбоотой юм.

Монгол Улсын Засгийн Газар болон компаниуд хөрөнгө оруулагчдаас өөрт шаардлагатай байгаа санхүүжилтээ өрийн хэрэгсэл болох бондыг ашиглан шийдвэрлэж болдог билээ. Тухайлбал, 2014 оноос Засгийн Газар төсвийн алдагдлаа санхүүжүүлэх зорилгоор Засгийн Газрын үнэт цаас ихээр гаргах болсон бөгөөд 2017 онд тус үнэт цаасны арилжаа 772.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү Засгийн Газрын үнэт цаасны хүү нь банкны хүйтэй харьцуулахад өндөр байсан мөн түүний хүүгийн орлогоос орлогын албан татвар авдаггүй зэрэг олон давуу талууд байсан нь бондын зах зээлд ихээхэн эрэлтийг үүсгэж, хөрөнгө оруулагчдыг ихээр татсан юм. Гэвч 2018 оноос Засгийн Газрын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарч эхэлснээр Засгийн Газар үнэт цаас гаргах үйл ажиллагаагаа хумиж эхэлсэн. Энэхүү нөхцөл байдал цаашид үргэлжлэн 2019 онд 9.7 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалагджээ.

График 17. Засгийн Газрын үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо



2020 -08- 24

2017 онд “Сүү” ХК нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан компанийн бонд гаргаж байсан бол түүнээс хойш МХБ-ээр компанийн бонд шинээр гараагүй байна.


График 18. Компанийн бондын арилжаа, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

Хувьцааны хэт төвлөрөл үүссэн, компанийн засаглал мүү, Монголын Хөрөнгийн Биржийн шаардлага шалгуурыг хангахгүй зэрэг шалтгаанаар хувьцаат компанийн тоо жил ирэх тусам буурч байна. Хэдийгээр хувьцаат компанийн тоо буурч байгаа ч чанартай хувьцаат компаниудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдэд ил тод тайлагнадаг хувьцаат компанийн тоо нэмэгдэж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржид 198 хувьцаат компани бүртгэлтэй байна.

График 19. Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо (Монголын Хөрөнгийн Бирж)



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Мөн хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх хамгийн чухал нөхцөл бол компаниудын ногдол ашиг тараалт буюу хөрөнгө оруулагчдын хүлээн авсан ногдол ашиг билээ. 2018 онд нийт 35 компани 112 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан бол 2019 онд 32 компани 139 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар зарласан байна.





График 20. Ногдол ашиг тараасан компанийн тоо болон ногдол ашгийн хэмжээ, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

*ногдол ашиг тараахаар зарласан компанийн мэдээлэл

2018 оноос хөрөнгийн зах зээлээр дамжуулан компаниуд хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа нэлээд сэргэж эхэлсэн бөгөөд 2018 онд 5 компани, 2019 онд 4 компани хөрөнгийн зах зээлд шинээр хувьцаа гаргах замаар санхүүжилт татаж, үйл ажиллагаагаа өргөжүүлж эхэлсэн байна. 2018 онд 5 компани Initial Public Offering (IPO) буюу анх удаа олон нийт хувьцаа санал болгож, нийт 26.7 тэрбум төгрөгийг амжилттайгаар татан төвлөрүүлээд байна. Энэ нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, энэхүү салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвхи, сонирхол нэмэгдэх нь цаашид зах зээл тогтвортой өсөх үндэслэл юм. 2019 онд 4 компани IPO хийж 42.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

График 21. IPO хийсэн компанийн тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгө, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Мөн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд Follow on Public Offering (FPO) буюу нэмэлт хувьцаа гаргах замаар дахин хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагаа явуулдаг. 2018 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй 2 компани нэмж хувьцаа гарган



4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна. Үүнд: “Хөвсгөл Алтандүүлга” ХК 3.7 тэрбум төгрөг, “Цемент Шохой” ХК 1.0 тэрбум төгрөгийн нэмэлт хувьцаа гаргасан байна.


График 22. Нэмж хувьцаа гаргасан компани, татан төвлөрүүлсэн хөрөнгө, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2016 оноос хөрөнгө оруулагчид “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д данс нээлгэх нь огцом өссөн бөгөөд энэ нь Засгийн Газраас “Сайн Хувьцаа” хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй холбоотой юм. Мөн 2019 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг байршуулахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчид шинээр данс нээлгэх нь огцом нэмэгдсэн байна.

График 23. Үнэт цаасны данс, мянган ширхэг




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, УЦТХТ ХХК

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дунгзэр нийт 1,827,724 хөрөнгө оруулагчийн данс бүртгэлтэй байна. Үүний 99.9 хувь буюу 1,825,245 нь дотоодын аж ахуй нэгж, иргэн байгаа бол 0.1 хувь буюу 2,479 нь гадаадын аж ахуй нэгж, хувь хүн байгаа болно. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 523,353 данс шинээр нээгджээ.



2019 онд хөрөнгийн зах зээлд 143 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдсан бөгөөд үүний 96 хувь нь дотоодын хөрөнгө оруулагчид, 4 хувь нь гадны хөрөнгө оруулагчдын хийсэн арилжаа байна.

График 24. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



2018 оноос гадны хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох идэвхи нэмэгдсэн бөгөөд энэ нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээг өсгөх, институциональ хөрөнгө оруулагчдын сонирхлыг өдөөх, төлбөрийн балансын голлогч бүрэлдэхүүн болох капиталын балансыг тэнцвэржүүлэх, ургал балансын алдагдлыг нөхөх, эдийн засгийн бодит өсөлтийн боломжийг бүрдүүлэхэд шууд нөлөөтэй билээ. Гэвч 2019 онд нийт арилжаанд эзлэх гадны хөрөнгө оруулагчдын эзлэх хувь буурч 4 хувьд хүрсэн байна. Хөрөнгийн зах зээл дэх гадны хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх үндсэн арга нь үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт, дэд бүтцийг сайжруулах замаар уул уурхай болон аж үйлдвэрлэлийн салбарт институциональ хөрөнгө оруулалтыг татах бөгөөд энэ нь өөрөө хөгжлийн бодлогын боломжит хувилбар юм. Үүнтэй холбоотойгоор СЗХ-ноос 2020 оны 3 сарын 31-ний өдрөөс үнэт цаасны төлбөр тооцооны T+2 горим буюу төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлсэн байна. Энэхүү системийг нэвтрүүлснээр үнэт цаасны зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөл бүрдэх эерэг нөлөөтэй гэж СЗХ-ноос үзэж байгаа билээ.

4.4 ТОП-20 ИНДЕКС

Хөрөнгийн биржүүд томоохон хувьцаат компаниудын хувьцаагаар багц бүрдүүлж, эдгээр компаниудын хувьцааны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн индекс тооцож гаргадаг билээ. Энэхүү индекс өсч, буурах нь хөрөнгийн зах зээлийн чиг хандлага цаашлаад хувьцаанд оруулсан хөрөнгийн өгөөжийг тодорхойлж байдаг. Тухайлбал Токиогийн Хөрөнгийн Бирж Японы хамгийн том 225 компаниар багцаа бүрдүүлж, НИККЭЙ 225 (NIKKEI 225) индексийг тооцож гаргадаг, Лондонгийн Хөрөнгийн Бирж ФУЦЭ 100 (FTSE 100) индекс тооцож гаргадаг байна. Тэгвэл Монголын Хөрөнгийн Бирж 2003 оноос ТОП-20 индексийг тооцож эхэлсэн бөгөөд ТОП-20 индексийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас идэвхтэй арилжаалагддаг, хамгийн үнэлгээ өндөр 20 компанийн хувьцааны ханшид суурин гаргадаг бөгөөд энэхүү үзүүлэлт нь Монголын үнэт цаасны зах зээл дэх хувьцааны ханшийн өсөлт, бууралтыг харуулдаг. 2004 оны 1 сард ТОП-20 индексийн дундаж ханш 850 нэгж байсан бол 2019 оны 12 сард 19,978.1 нэгжид хүрч, 22.5 дахин өссөн байна. Энэ нь Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагддаг хувьцаат компанийн хувьцааг худалдан авсан бол хөрөнгө оруулалт 22.5 дахин өсөх боломжтой байсан гэдгийг харуулж байна. Эдийн засаг огцом өсөж, хөрөнгө оруулалт нэмэгдэж байсан 2011 онд ТОП-20 индекс түүхэн дээд ханш буюу 32,955 нэгжид хүрч байжээ.

Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах нь хэр өгөөжтэйг харуулахын тулд Монголын Хөрөнгийн Бирж хувьцаат компаниудын хувьцааны чиг хандлагыг тодорхойлогч ТОП-20 индексийн өсөлтийг НИККЭЙ 225, ФУЦЭ 100 индексүүдийн өсөлттэй харьцуулав.

График 25. 2010-2019 оны хоорондох жилийн өсөлт 200 өдрийн гулсах дунджаар ба дундаж өсөлт



Тэмдэглэл:


Жилийн өсөлтийг тооцохдоо ТОП-20, ФҮЦЭ 100 индексүүдийн хувьд жилд дунджаар арилжааны 252 өдөр байдаг учир арилжааны 252 өдрийн өмнөхтэй нь харьцуулсан бол НИККЭЙ 225 индексийн хувьд жилд дунджаар 244 арилжааны өдөр байсан тул арилжааны 244 өдрийн өмнөхтэй нь харьцуулж тооцсон. Мөн харьцуулж хараад хялбар байх үүднээс графикийн босоо тэнхлэгийг адилхан байгуулав.

ФҮЦЭ 100 индексийн хувьд сүүлийн арван жилд маш тогтвортой байсан байна. Энэ хугацаанд нэг жилийн өсөлт (200 хоногийн гулсах дунджаар тооцсон) нь хамгийн ихдээ 24 хувийн өсөлттэй байсан бол хамгийн баагдаа 9 хувиар унажээ. NIKKEI 225 индексийн өсөлт харьцангуй тогтвортой байж хамгийн ихдээ жилд 57 хувиар өсөж хамгийн баагдаа 14 хувиар буурчээ. Харин ТОП-20 индексийн хувьд савалгаа ихтэй байж хамгийн ихдээ жилд 149 хувиар өсөж хамгийн муудаа 24 хувиар унажээ. Хэдийгээр ТОП-20 индекс савалгаа ихтэй байгаа хэдий ч дундаж өсөлтийн хувиар FTSE 100 болон NIKKEI 225 индекстэй харьцуулахад өндөр өгөөжтэй байна. ТОП-20 индекс сүүлийн арван жилд 1 жилд дунджаар 23 хувиар өссөн бол FTSE 100 индекс 5 хувиар, NIKKEI 225 индекс 11 хувиар өссөн байна.

ТОП-20 индексийн цаашдын чиг хандлага

Хувьцаа болон индексийн үнийг оновчтой таамаглахын тулд шинжээчид маш олон загварчлал хэрэглэж, туршдаг. Аливаа үзүүлэлтийг таамаглахад ашиглаж буй загваруудыг ерөнхийд нь бүтцийн хандлага (ARIMA, VAR, VAC), хагас бүтцийн хандлага (SVAR, FAVAR, SVEC) болон бүтцийн хандлага (SEM, DSGE) хэмээн ангилж болно. Эдгээр загваруудаас индекс, хувьцааны үнэ таамаглахад хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргачлал бол ARIMA (Autoregressive Integrated Moving Average) загварчлал юм. Энэхүү загварыг анх 1971 онд Жорж И.П.Бокс болон Гвилым Жэнкинс нар гаргаж ирсэн бөгөөд өөрөөр Box-Jenkins аргачлал ч гэж нэрлэдэг. Энэхүү загвар нь санхүүгийн таамаглал хийхэд түлхүү ашиглагддаг бөгөөд ялангуяа богино хугацааны таамаглалыг маш оновчтой хийдгээрээ алдартай. Аргачлалын хувьд ерөнхийдөө тухайн нэг хувьсагчийн ирээдүйн утгыг өнгөрсөн утгууд болон алдаануудаас нь үнэлэж таамагладаг юм.

График 26. ТОП-20 индексийн ирэх 10 жилийн таамаглал, 2020-2029



ARIMA загвараар ТОП-20 индексийг таамаглаж үзэхэд ирэх 10 жилд тогтвортой өсөх хандлагатай байгаа бөгөөд 95 хувийн итгэх түвшинд 2029 он гэхэд 72,243 болох боломжтой.



2020 -08- 24



БҮРТГЭВ-03
МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

Хэдийгээр ирээдүйг бүрэн таамаглах нь боломжгүй хэдий ч Монголын үнэт цаасны зах зээлийн хувьд эерэг хүлээлт олон байна. Монголын үнэт цаасны зах зээл дөнгөж хөгжиж байгаагийн хувьд цаашид өсөж, томрох боломж маш их, хөрөнгийн зах зээлийг дэмждэг гол тоглогчид болох хөрөнгө оруулалтын сангүүд цөөнгүй байгуулагдаж эхэлж байгаагаас гадна иргэд, хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг улам нэмэгдэж байна. Мөн төрөөс тэтгэврийн реформ хийж хувийн тэтгэврийн сангүүд бий болох, төрийн өмчит компаниудын хувьчлал хийгдэх зэрэг үнэт цаасны зах зээлийн хөгжлийг урагшлуулах олон ажлууд хэлэлцэгдэж ойрын хугацаанд хийгдэхээр хүлээгдэж байна.

ТОП-20 индексийн сүүлийн үеийн мэдээлэл

ТОП-20 индексийн таамаглал хийснээс хойш зах зээлд гэнэтийн шок буюу COVID-19-ээс үүдэлтэй шок үүсэж ТОП-20 индекс оны эхнээс 15% үнаж 2020 оны 4 сарын 16-ны өдрийн байдлаар 16,679-д хүрээд байна. COVID-19 вирусээс үүдэн эдийн засаг хүндэрч, олон аж ахуй нэгжүүдийн орлого, үйл ажиллагаа доголдолж байгаа нь шууд хувьцаат компанийн хувьцааны ханшинд нөлөөлж байна. Гэвч бид энэхүү нөхцөл байдлыг боломж гэж харж байна. Сан байгуулагдаж хөрөнгө оруулалт татах энэ үед бидний хөрөнгө оруулах үнэт цаасны үнэ хямдарч байгаа нь Сангийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх юм.

4.5 МОНГОЛ УЛСЫН ХУВЬЧЛАЛ

Монгол Улс нь төлөвлөсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихдээ эдийн засгийн шинэчлэлийн багц арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь өмч хувьчлал юм. Анх 1991 оны 5 сарын 22-ны өдөр Улсын бага хурлаас “Өмч хувьчлах тухай хууль”-ийг баталж, төрийн өмчийг иргэддээ хувьчлах түүхэн шийдвэр гаргасан билээ. 1992-1995 оны хооронд 475 улсын үйлдвэр, аж ахуй нэгжийг МХБ-д бүртгүүлж, тэдгээрийн 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг иргэддээ эзэмшүүлсэн юм. Ингэхдээ иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг тэгшигтгэн хуваарилж, хувьцаат компанийн хувьцааг эзэмших боломжийг олгосон бөгөөд нийт 1.2 сая иргэн буюу тухайн үеийн нийт хүн амын 52 орчим хувь нь хувьцаа эзэмшигч болсон. Энэхүү хувьчлал нь хөрөнгийн дахин хуваарилалтыг бий болгох, иргэд олон нийтэд компанийн хувьцааг эзэмших ижил нөхцлийг санал болгосон хэдий ч иргэдийн бэлтгэл сайтар хангагдаагүй, мэдлэг, мэдээлэл дутмаг байсан тул ихэнх хувьцаа эзэмшигчид хувьцаагаа хямд үнээр мэдлэг, мэдээлэлтэй гэх цөөн хүмүүст зарж, үүний үр дүнд цөөн гэр бүл компаниудын хувьцааны хяналтын багцыг эзэмшсэн байдал.

Үүнээс хойш төрийн бусад өмчийг хувьчлах үйл ажиллагаа үргэлжлүүлсэн бөгөөд 1996-2012 оны хооронд 1,088 компани, үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулах арга зэргийг ашиглан хувьчилж, 81.02 тэрбум төгрөгийг хувьчлалын орлого болгон төвлөрүүлсэн байна.

Эдгээр хувьчлалын үр дүнд Монгол Улс богино хугацаанд төрийн өмчийг хувийн өмчид шилжүүлж чадсан ч иргэд хувьчлалын урт хугацааны үр өгөөжийг хүртэж, баялагийн эзэн болж чадаагүй алдсан юм.

Харин 2015 оноос төрийн өмчит компанийн менежмент, өрсөлдөх чадвар зэргийг сайжруулах, үр ашигтай ажиллуулах зорилгоор хувьчлалыг явуулж эхэлсэн нь Монгол Улсад хувьчлалын шинэ давалгааг эхлүүлсэн юм. 2015 оны 7 сарын 3-ны өдөр УИХ-аас нэр бүхий 19 компанийг хувьчлах тухай 70 дугаар тогтоол баталсан билээ. Эдгээр компаниудаас “Монгол Шуудан” төрийн өмчит компани нь нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй арилжаалсан. Энэхүү хувьчлалын гол зорилго нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах байсан.

График 27. “Монгол Шуудан” ХК-ийн хувьцааны эрэлт нийлүүлэлт




Хувьцааг олон нийтэд санал болгох үед олон нийтээс 2 дахин их хувьцаа худалдаж авах санал орж ирсэн байна.






График 28. “Монгол Шуудан” ХК-ийн хувьцааны хаалтын ханш, төгрөг



Энэхүү хувьчлалын үр дүнд “Монгол Шуудан” ХК-ийн хувьцааны ханш нь хоёрдогч зах зээлийн эхний долоо хоногт 70 хувиар өсч 325 төгрөгт хүрч өссөнөөр хувьцаа эзэмшигчдэд 75.7

хувийн өндөр өгөөж авчирсан байна. Мөн 2019 оны байдлаар хувьцааны ханш 725 төгрөгт хүрч 290 хувийн өгөөжтэй байв. Мөн хувьчлал явагдсаны дараа компанийн менежмент, өрсөлдөх чадвар сайжирч, илүү үр ашигтай ажиллах болсон.

График 29. “Монгол Шуудан” ХК-ийн татварын дараах цэвэр ашиг, сая төгрөг



Тухайлбал, 2015 онд “Монгол Шуудан” ХК нь 94 сая төгрөгийн ашигтай, 0.7 хувийн эздийн өмчийн өгөөжтэй байсан бол хувьчлагдсаны дараа буюу 2016 оны жилийн

эцсээр цэвэр ашиг 1.0 тэрбум төгрөг, эздийн өмчийн өгөөж 4.9 хувьд хүрсэн байна.

Цаашид хэд хэдэн томоохон төрийн өмчит компаниуд хувьчлагдахаар хүлээгдэж байна. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 6 сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл” хуулийн төслийг хэлэлцсэн. Энэхүү төслийн үзэл баримтлал нь хувийн хэвшилд сууринсан эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах замаар төрийн өмчит хуулийн этгээдийн үнэ цэнийг өсгөх зорилготой бөгөөд нийтдээ 27 төрийн өмчит хуулийн этгээдийг Монголын Хөрөнгийн Бирж болон нээлттэй дуудлага худалдаагаар хувьчлахаар тусгасан байна¹⁸. Эдгээр компаниудаас дурьдвал:

Монголын Хөрөнгийн Бирж ХК

Монголын Хөрөнгийн Бирж нь 1991 оны 1 сарын 18-ны өдөр байгуулагдсан бөгөөд хувьцаа, бонд зэрэг үнэт цаасны арилжааг зохион байгуулдаг 100 хувь төрийн өмчит хувьцаат компани юм. Засгийн Газар Монголын Хөрөнгийн Биржийг 100 хувь хувьчилна гэсэн байр суурьтай байгаа ба хотын төвд өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй, Лондонгийн Хөрөнгийн Биржийн хөрөнгийн зах зээлийн цогц дэд бүтцийг суурилуулсан зэрэг давуу талуудаас гадна дотоод,

¹⁸ <https://vip76.mn/content/53458>



гадаадын санхүүжилт татаж бизнес эрхлэгчдэд хямд эх үүсвэр татах гүүр болж өгдөг нь Монголын Хөрөнгийн Биржийн үнэ цэнийг өсгөж байгаа.

График 30. “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн хөрөнгө, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн 2018 оны жилийн тайлан

Төрийн банк

Төрийн банк нь Монголбанкнаас 2009 оны 11 сарын 23-ны өдөр олгосон банкны зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Монгол орон даяар 500 гаруй салбар нэгж, 308 ATM, 3,054 гаруй картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна¹⁹.

График 31. Төрийн банк, нийт хөрөнгө, тэрбум төгрөг



Тус банк нь 2019 оны байдлаар 3.3 орчим их наяд төгрөгийн активтай, 2.1 сая харилцагчтай байна. Эрсдэлийн сангийн зардал болон татвар тооцсоны дараах цэвэр ашиг 2019 онд 20.3 тэрбум төгрөгөөр хэмжигдсэн Төрийн банкийг 100 хувь хувьчлах зарчмыг баримталж байна. Төрийн банкны тодорхой хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад өгнө.

Үлдсэн хувийг нь Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалах зураг гараад байна.

“МИАТ” ТӨХК

“МИАТ” ТӨХК нь 1956 оны 7 сарын 7-ны өдөр үүсгэн байгуулагдсан Монгол Улсын үндэсний агаарын тээврийн компани юм. Тус компани нь 7 онгоц (3 нь Монгол Улсад бүртгэлтэй, 4 нь гадаад улсад бүртгэлтэй)-той үйл ажиллагаа явуулж байна.

¹⁹ https://www.statebank.mn/w/content/2020/04-13/Annual_report_2019.pdf



График 32. **Олон улсын агаарын тээврийн зах зээл, мянган хүн**



2019 оны байдлаар “МИАТ” ТӨХК нь олон улсын чиглэлд 589.4 мянган зорчигч тээвэрлэсэн бөгөөд энэ нь нийт зах зээлийн 50 хувийг эзэлж байна. Харин орон нутгийн зах зээлийн хувьд нийт 433.4 мянган зорчигч тээвэрлэснээс МИАТ ТӨХК нь 45 хувийг тээвэрлэсэн байна.
 Сүүлийн 5-н жилийн хугацаанд “МИАТ” ТӨХК-ний зорчигчдын тоо жилд дунджаар 9 хувийн өсөлттэй байна.²⁰

Засгийн Газраас МИАТ-ын 49 хувийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэйгээр арилжаалах боломжтой гэж үзэж байна.

²⁰ <https://www.mcaa.gov.mn/?p=685>



5. НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

5.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг нэгж эрх гаргаж, үүний 95 хувийг буюу 47,500,000 ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгоно. Хөрөнгө оруулагчид харилцагч үнэт цаасны компаниараа дамжуулан Монголын Хөрөнгийн Бирж дээрээс Сангийн нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Олон нийтэд санал болгож буй нэгж эрхийн мэдээлэл

Нэгж эрх гаргач	“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС
Нэгж эрхийн хэлбэр.....	Биет бус
Нэгж эрхийн санал болгох үнэ.....	100 төгрөг
Олон нийтэд санал болгож байгаа нэгж эрх	
- Нэгж эрхийн тоо.....	47,500,000 ширхэг
- Нийт нэгж эрхэд эзлэх хувь.....	95%
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.....	4,750,000,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт.....	Хөрөнгө оруулалт хийх
Санал болгох хүрээ	Олон нийт
Санал болгох арга хэлбэр.....	Тогтсон үнийн арга
Арилжааг зохион байгуулах байгууллага.....	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Санг үүсгэн байгуулагч.....	“Ард Менежмент УЦК” ХХК

5.2 НЭГЖ ЭРХИЙГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ШИЙДВЭР

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг үндэслэн 2019 оны 7 сарын 17-ны өдөр Ард Менежментийн төлөөлөн удирдах зөвлөл 19/05 тоот тогтоолоор “Ундэсний Хувьчлалын Сан” хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг 50,000,000 нэгж эрхтэй байхаар үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын хүрээнд 2020 оны 6 сарын 2-ны өдөр Ард Менежментийн төлөөлөн удирдах зөвлөлийн 20/10 тогтоолоор “Ундэсний Хувьчлалын Сан”-гийн 47,500,000 нэгж эрхийг олон нийтэд санал болгож, хувь нийлүүлсэн хөрөнгийг 5,000,000,000 төгрөг болгохоор шийдвэрлэсэн. Уг шийдвартай холбоотойгоор Ундэсний Хувьчлалын Сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд хавсралтаар нэмэлт өөрчлөлт орсон Сангийн дүрмийн найруулгыг оруулав. Хөрөнгө оруулагч та Санд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахаас өмнө хавсралтад тусгасан нэмэлт өөрчлөлт орсон Сангийн дүрмийн найруулгатай сайтар танилцаж, шийдвэрээ гаргана уу.

5.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС нь нийтдээ 50,000,000 ширхэг нэгж эрхтэй бөгөөд үүний 5 хувийг үүсгэн байгуулагч “Ард Менежмент УЦК” ХХК нь эзэмшдэг болно. Ард Менежмент нь санг үүсгэн байгуулах үед сангийн 5 хувь буюу 2,500,000 сая ширхэг нэгж эрхийг 250.0 сая төгрөгөөр худалдаж авсан ба Сангийн үлдэх нэгж эрх болох 47,500,000



ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгож байна. Ингэснээр сангийн нэгж эрх эзэмшигчийн бүтэц доорх бүтэктэй болно.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
Ард Менежмент УЦК ХХК.....	2,500,000	5.0%
Олон нийт.....	47,500,000	95.0%
Нийт.....	50,000,000	100.0%

5.4 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

- Сангийн үйл ажиллагааны орлогоос өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн ногдол ашиг хүртэх;
- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын эрхтэй оролцох;
- Бусад нэгж эрх эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа нэгж эрхээ чөлөөтэй захиран зарцуулах;
- Санг татан буугдах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;
- Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй нэгж эрхээ Иргэний хуульд заасан зохицуулалтын хүрээнд захиран зарцуулах /худалдах, бэлэглэх, барьцаалах, өв залгамжуулах болон хуулиар зөвшөөрсөн бусад хэлбэр/;
- Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь Санггаас нэмж гаргаж буй нэгж эрхээс өөрийн эзэмшиж буй хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын сангийн талаарх холбогдох мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх.
- Сангийн дүрэмд тусгасан бусад эрх.

Хөрөнгө оруулагч та Санд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахаас өмнө хавсралтад тусгасан нэмэлт өөрчлөлт орсон Сангийн дүрмийн найруулгатай сайтар танилцаж, шийдвэрээ гаргана уу.

5.5 НЭГЖ ЭРХ АРИЛЖИХ

Үнэт цаасны данс

Нэгж эрхийн арилжаа нь Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар явагдах бөгөөд та үнэт цаасны арилжаанд оролцохын тулд “өөрийн харилцагч үнэт цаасны компанийд үнэт цаасны данс нээлгэсэн байх шаардлагатай. Үнэт цаасны дансыг хувь хүн, аж ахуй нэгж байгууллага гэсэн 2 ангилалтайгаар нээдэг болно. Данс нээх талаар дэлгэрэнгүй мэдээллийг харилцагч үнэт цаасны компаниас авна.



Нэгж эрхийн захиалга

Хөрөнгө оруулагчид нэгж эрхийг худалдан авах захиалгыг үнэт цаасны компаниудад өгөх бөгөөд захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Бирж бүртгэх зөвшөөрөл гарснаас хойш Ард Менежмент нь холбогдох байгууллагуудтай хамтран тогтооно.

- Нэгж эрхийг нийтэд танилцуулж эхэлсэн өдрөөс эхлэн захиалга авч эхэнэ.
- Хөрөнгө оруулагч нь захиалгыг бүртгэх хугацаанд харилцагч үнэт цаасны компанидаа худалдан авах нэгж эрхийн тоо болон нэгжийн үнэ, нийт үнийн дунг бөглөсөн захиалгын маягтыг бүрэн бөглөж захиалга өгнө.
- Хөрөнгө оруулагч нь захиалга бүртгэх хугацаанд өөрийн өгсөн захиалгын тоо ширхэг үнийн дунд өөрчлөлт оруулж болохоос гадна цуцалж болно.
- Үнэт цаасны компани нь хүлээн авсан захиалгыг өдөр бүр Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон арилжааны цагт програмд бүртгэж авна.

Олон нийтэд санал болгох үнэ

“Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-г үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч “Ард Менежмент УЦК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс 2019 оны 7 сарын 17-ны өдөр болон 2020 оны 6 сарын 2-ны өдрүүдэд тус тус гаргасан 19/05 тоот болон 20/10 тоот тогтоолуудад дурьдсаны дагуу нэгж эрхийг олон нийтэд санал болгох үнийг 100 төгрөг байхаар тогтоосон болно.

Олон нийтэд мэдээлэл хүргэх

Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэгж эрхийг бүртгэх зөвшөөрөл гарснаас хойш Ард Менежмент нь “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн талаар мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Мэдээллийг захиалгын бүртгэл эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө нэгж эрхийн танилцуулга болон тараах материалыг үнэт цаасны компаниудад хүргүүлнэ.

Нэгж эрхийг байршуулах

Нэгж эрхийн захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан биелэх боломжтой захиалга тус бүрээр нэгж эрхийн хуваарилалтыг хийнэ. Энэ үед захиалга өгсөн этгээдийн дансанд үнэт цаасыг байршуулахгүй бөгөөд урьдчилсан байдлаар тухайн захиалагчид ногдох нэгж эрхийн тоо ширхгийг тогтооно. Санхүүгийн Зохицуулах Хорооноос уг хуваарилалтыг зөвшөөрснөөр нэгж эрхийн нийлүүлэлтийг хийж, анхдагч зах зээлийн арилжааг явуулна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа

Ундэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-оос нэгж эрхийг олон нийтэд амжилттай санал болгон шаардлагатай санхүүжилтийг босгосны дараагаар МХБ-ийн журмын дагуу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ба энэ үед нэгж эрх худалдан авсан хөрөнгө оруулагчид нэгж эрхээ зарж борлуулах эрх нээлттэй болно.



2020 -08- 24

5.6 ТАТАН ТӨВЛӨРҮУЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Сан нь олон нийтэд нийт 47,500,000 ширхэг нэгж эрхээ санал болгон нийт 4.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээр 5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болох юм. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Сан нь хөрөнгө оруулалт хийхээс гадна хөрөнгө оруулалт татах болон хөрөнгө оруулалт хийхдээ холбоотой доорх зардлуудыг төлнө.

	Зардлын төрөл	Үнийн дүн/хувь	Тайлбар
1	Сан байгуулах зардал	40,000,000₮	Сан байгуулахтай холбогдон гарсан зардлын дүн.
2	Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэлийн хураамж	50,000,000₮ (1%)	Нэгж эрхийн Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлэхэд гардаг зардал.
3	Монголын Хөрөнгийн Биржийн хянах үйлчилгээний хөлс	2,000,000₮	Нэгж эрх бүртгэхэд Монголын Хөрөнгийн Биржийн хяналтын үйлчилгээний хөлс.
4	Нэгж эрхийн танилцуулга боловсруулах зардал	20,000,000₮	Нэгж эрхийн танилцуулга боловсруулахтай холбогдон гарсан зардлын дүн.
5	Зүүчлал	237,500,000₮ (5%)	Хөрөнгө оруулалт татах зуучлалын хөлс.
	Нийт	349,500,000₮	

Нийт 349.5 сая төгрөгийн үүсгэн байгуулах болон хөрөнгө оруулах татахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс гаргана. Эдгээр зардлууд нь нэг удаагийн буюу цаашид дахиж гарахгүй зардлууд юм. Харин үлдсэн 4.65 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх бөгөөд үүний 70 хүртэл хувиар нээлттэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийнэ.



6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн санхүүжилтээр үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх тул эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж явах зайлшгүй шаардлага тулгарч байгаа билээ. Эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг тодорхойлж, үнэлж, удирдах гэсэн үндсэн З үйл ажиллагаанаас бүрддэг. Бид доорх байдааар эрсдэлээ багцалж, тодорхойлж байгаа бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх, удирдах арга хэмжээний талаар тус бүрд нь бичсэн болно.

- Хөрөнгө оруулалтын эрсдэл;
- Үйл ажиллагааны эрсдэл;
- Нэгж эрх эзэмшигчдэд үүсэх эрсдэл.

Хөрөнгө оруулалтын эрсдэл

Энэ эрсдэлд хөрөнгө оруулалтын багцтай холбоотой үүсч болох эрсдэлүүдийг багтаасан болно. Тухайлбал, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хөшүүргийн эрсдэл, хөрөнгийн үнэлгээ болон хөрөнгө оруулалттай холбоотой үүсэх бусад эрсдэлүүд юм.

Хөрөнгө оруулалтын эрсдэл гэдэг нь удирдаж буй хөрөнгө оруулалтын багцын өгөөж түүнтэй харьцуулах хөрөнгийн багцын (benchmark) өгөөжөөс бага түвшинд хүрэхэд үүсдэг эрсдэл юм. Хөрөнгө оруулалтын менежерүүд нь гүйцэтгэлээ харьцуулж буй хөрөнгө оруулалтын багцын өгөөжөөс их эсвэл бага хэмжээтай байгаагаас хамаарч эрсдэлийг хянаж, тохируулж байдаг. Тогтмол хугацаанд хөрөнгө оруулалт болон түүний өгөөжийн гүйцэтгэлийг тооцоолж, хянаснаар энэ төрлийн эрсдэлийг бууруулах боломж бүрддэг.

Эрсдэлийн нэр	Эрсдэлийг удирдах арга зүй
Хөрөнгө оруулалтын хэлбэрийн (Investment style) эрсдэл	Зах зээл болон эдийн засгийн нөхцөл, зах зээлд шинээр гарсан бүтээгдэхүүн үйлчилгээнээс үүдэн багц дахь хөрөнгө оруулалтуудын хэмжээ, хэлбэр өөрчлөгджэй байдаг. Тухайлбал, ялгаатай хөрөнгө оруулалтын хэлбэр баримталсан хэдий ч ижил хөрөнгө оруулалт хийсэн тусдаа дансны өгөөжүүд өөр байдаг. Бид хөрөнгө оруулалтын стратегиудыг цаг тухай бүр өөрчлөх замаар энэхүү эрсдэлийг удирдах болно.
Хөрвөх чадварын (liquidity) эрсдэл	Хэдийгээр хувьцаат компаниудын үнэт цаас олон нийтэд чөлөөтэй арилжаалагддаг боловч арилжааны хэмжээ бага байх тохиолдол байдаг. Хөрвөх чадвар сул үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийснээр энэхүү эрсдэл нь үүсдэг. Ялангуяа Монголын Хөрөнгийн Биржийн өнөөгийн чадамжаас шалтгаалан хөрвөх чадвар эрсдэлтэй байдаг. Энэ эрсдэлийг бууруулахын тулд хөрөнгө оруулалтын багц болон үнэт цаас бүрийн хувьд хөрвөх чадварыг тодорхойлж, түүнд тохиорох бодлогыг баримтлан ажиллах болно. Мөн Сангийн хөрөнгийг олон төрлийн хувьцаа, бондод тархаан байршуулснаар энэхүү эрсдэлийг бууруулж чадна.



2020 -08- 24

Төрөлжүүлэлтийн эрсдэл	Аль нэг төрлийн үнэт цаасанд Сангийн хөрөнгийг төвлөрүүлснээр хөрөнгө оруулалтын багц нэг үнэт цааснаас хэт хамаарлтай болж, эрсдэл нэмэгддэг. Иймээс нэг төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хэт их хөрөнгийг төвлөрүүлэхээс зайлсхийж, аль болох олон төрлийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын багцыг бурдүүлснээр энэ эрсдэлийг бууруулах боломжтой юм. Энэхүү эрсдэлийн хүрээнд Сан нь хөрөнгө оруулалтын бодлогодоо эдийн засгийн нэг салбарт хөрөнгө оруулах дээд хязгаар нь Сангийн нийт активын 25%-аас хэтрэхгүй мөн нэг компанийн хувьцааны 10-аас дээш хувийг дангаар эзэмшихгүй хэмээн тус тус заасан.
Санхүүийн хөшүүргийн эрсдэл	Зээлэх болон үүсмэл үнэт цаасанд хөрөнгө байршуулснаар анхны оруулсан хөрөнгө оруулалтаас үүсэх ашиг болон алдагдлыг өөрчлөх боломжтой юм. Сан нь зээлээр хөрөнгө оруулалт хийхгүй байх бодлого баримталж байгаа тул энэхүү эрсдэлээс бүрэн урьдчилан сэргийлэх боломжтой юм.
Үнэлгээний эрсдэл	Тухайн өдрөөр Сангийн дансан дахь хөрөнгийн үнэлгээ хүлээж байснаас их эсхүл багаар үнэлгэдэх боломжтой. Энэ нь дутуу мэдээлэл, зах зээлийн тогтвортгуй байдал, санхүүгийн загвар болон үнэд нөлөөлөх боломжтой үнэт цаас, зардал зэрэг олон хүчин зүйлсээс хамаарлтай. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд менежер нь зах зээлийн үнэлгээ, урьдчилж гарах зардалтай холбоотой гэрээ зэргийг ашиглаж бодит үнэлгээг тодорхойлохоор ажиллах юм.
Үнэт цаас гаргагчийн эрсдэл болон харилцагч (counterparty) талын эрсдэл	Менежер нь үнэт цаас гаргагчдын эрсдэлийг үнэлдэг рейтэнгийн агентлагуудын (rating agency) үнэлгээнд суурилаж шийдвэр гаргадаг бол энэхүү рейтэнгийн агентлагуудаар үнэлгэдээгүй үнэт цаас гаргагчийн эрсдэлийг тооцох шаардлагатай болдог. Энэ тохиолдолд мэргэжлийн компаниудын хийсэн үнэлгээн дээр эсхүл компанийн суурь шинжилгээ хийх замаар шийдвэр гаргана.
Загварын эрсдэл (model)	Менежерүүд нь өргөн цар хүрээтэй тоон шинжилгээ болон хөрөнгө оруулалтын загваруудыг ашигладаг бөгөөд эдгээрийг ашиглах үед хүлээж байснаас өөр үр дүнг үзүүлэх тохиолдол байдаг. Энэ нь хүний хүчин зүйлс, тоон алдаа эсхүл програм хангамж гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалдаг. Бид энэхүү эрсдэлийг бууруулахын тулд үнэлгээний моделийг тогтмол шалгаж, зах зээлийн өөрчлөлттэй холбогдуулж өөрчлөх, бусад мэргэжлийн байгууллагуудтай харьцуулж явахын зэрэгцээ менежерүүд моделийг зөв ашиглаж байгаа эсэх, модельд ашиглагдаж буй тоон өгөгд-лүүд үнэ зөв эсэх зэргийг хянаж явах болно.
Хүүгийн түвшний эрсдэл	Хүүгийн түвшний өөрчлөлт нь Сангийн мөнгөн хөрөнгөөс олох өгөөжийг өөрчлөх бөгөөд Сангийн нийт хөрөнгөд нөлөөлөх боломжтой болно. Иймд бид Сангийн мөнгөн хөрөнгийг банкуудад байршуулахдаа тогтвортой үйл ажиллагаа явуулдаг банкуудыг сонгох зарчим баримтална.



2020 -08- 24

ARD МЕНЕДЖМЕНТ-03
КОМПАНИ

Компанийн бондын эрсдэл	Компанийн бондын эрсдэл нь тус компани бондын дуудагдсан хугацаанд купон болон үндсэн төлбөрийн үүргээ биелүүлж чадахгүй байх явдал юм. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд бонд гаргагчийн үйл ажиллагаа, удирдлага, ашигт ажиллагаа, хөрөнгийн бүтэц, төлбөрийн чадвар болон бүтээгдэхүүний эрэлт зэргийг судалж хөрөнгө оруулалтаа хийх болно.
Инфляцийн эрсдэл	Инфляци нь мөнгөний үнэ цэнийг бууруулдаг тул хөрөнгө оруулалтын үр өгөөж, хөрөнгө оруулалтын үнэ цэнэ нь ирээдүйд бага байх эрсдэлтэй юм. Инфляци өсөхийн хэрээр энгийн хувьцааны бодит үнэ цэнэ, тэдгээр хувьцааны тархалт буурч болно.
Дефляцийн эрсдэл	Дефляцийн эрсдэл буюу эдийн засаг хумигдаж бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ буурч байгаа нь компаниудын зах зээлийн үнэлгээ, үйл ажиллагаа, орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл юм. Үүнээс гадна дефляци нь үнэт цаас гаргагчийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд үнэт цаасны үнэ цэнийн бууралт бий болгох магадлалтай.
Хөрөнгийн зах зээлийн эрсдэл	Сангийн хөрөнгө оруулах дотоод болон гадаад хөрөнгийн зах зээл унаж Сангийн хөрөнгө буурах эрсдэлтэй. Аливаа хөрөнгийн зах зээлд уналт сэргэлт ээлжилж байдаг. Сан нь хөрөнгө оруулахдаа судалгаа, шинжилгээнд суурилан урт хугацаанд өсөлттэй, тогтвортой байх хувьцаа, бондод хөрөнгө оруулж зах зээлийн богино хугацааны уналтаас сэргийлнэ.
Макро эдийн засгийн эрсдэл	Монголын эдийн засгийн уналт Сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Монголын эдийн засаг нь гадаад зах зээлийн түүхий эдийн үнийн хэлбэлзээс ихээхэн хамааралтай бөгөөд үүнээс эрсдэл үүсэх боломжтой. Сан нь энэхүү эрсдэлийг Сангийн хөрөнгийн хөрвөх чадварыг сайн байлгаж суурь шинжилгээ сайн компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар бууруулна.
Валютын ханшийн эрсдэл	Сангийн төвлөрүүлэх эх үүсвэр нь төгрөгөөр илэрхийлэгдэх учир ханшийн эрсдэл шууд нөлөөлөхгүй.
Сангийн менежерийн эрсдэл	Сангийн менежерийн эрсдэл буюу сангийн менежер буруу шийдвэр гаргах, их хэмжээний алдагдалд хүргэх хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрсдэлтэй. Энэхүү эрсдэлээс сэргийлэхийн тулд Сангийн дүрэмд их хэмжээний хэлцлийг Сангийн ТУЗ гаргахаар шийдвэрлэсэн бол хөрөнгө оруулалтын шийдвэрийг ХОМК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалтын хороо болон Сангийн менежер зэрэг гаргахаар зохицуулж өгсөн болно.



Үйл ажиллагааны эрсдэл

Сангийн үйл ажиллагатай холбогдон дараах эрсдэлүүд үүсэх боломжтой.

Эрсдэлийн нэр	Эрсдэлийг удирдах арга зүй
Технологи, тоног төхөөрөмжийн эрсдэл	Үйл ажиллагааны хүрээнээс хамаараад хөрөнгийн багц, түүний эрсдэлийг тодорхойлох, тоон судалгаа хийх, арилжааны систем, арилжааны мэдээллийг хадгалах зэрэг системүүдийг ашиглах шаардлагатай болдог. Иймд бид тогтмол хугацаанд менежментийн компанийд шаардлагатай системүүдийг ашиглагдаж байгаа эсэх болон ойрын хугацаанд ямар системүүд шаардлагатай болох зэрэг судалгаа хяналтыг хийж ажиллах болно.
Мэдээлэл хадгалалтын эрсдэл	Менежментийн компани Сангийн бичиг баримт, тоон өгөгдөл зэргийг тогтмол хадгална. Мөн кастодиан банк Сангийн хөрөнгийг хадгалж, хянаж байх бөгөөд Кастодианы үйл ажиллагаанд дотоод хяналтын хороо хяналт тавьж ажиллана.
Боловсон хүчиний эрсдэл	Менежментийн компанийн хувьд гол эрсдэлүүдийн нэг нь боловсон хүчиний эрсдэл юм. Энэ эрсдэлийг удирдахын тулд гүйцэтгэх захирал, менежер болон бусад ажилчиддаа мэргэжил дээшлүүлэх, ур чадвар нэмэгдүүлэх сургалтанд тогтмол хамрагдуулах бөгөөд урт хугацаанд тогтвортой ажиллуулах тал дээр анхаарна.
Засаглалын эрсдэл	Сангийн бүтэц болон хяналтын механизмтэй холбогdon гарч ирдэг эрсдэл юм. Энэ эрсдэлийг үр ашигтай удирдахын тулд Сан нь бүтэц зохион байгуулалтын хэмжээнд хяналтаар хангаж, эрсдэлийг ухамсарлах ёс зүйг суулгах хэрэгтэй юм. Сан нь үйл ажиллагааны түвшин бүрт хяналт тавих зорилгоор доорх бүтцийг бий болгон ажиллах болно.

Дотоод хяналтын үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт

Нэгж эрх эзэмшигчдийн хурал

Менежментийн компани болон Кастодиан банкинд хяналт тавьж ажиллана.

Төлөөлөн удирдах зөвлөл

- Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог зөв зохион байгуулах, хөрөнгө оруулалт болон санхүүгийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах тогтолцоо бүрдүүлэх, эрсдэлийг менежментээр хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.
- Аудитын хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дотоод Хяналтын Хороо

Хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлагын бичиг баримт, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх

Ард Менежмент УЦК ХХК

Эрсдэлийн удирдлагын бодлого, тогтолцооны дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Хяналт





Энэ бүтцээр Дотоод Хяналтын Хороо нь үйл ажиллагаа болон үүссэн нөхцөл байдлыг хараат бусаар ТУЗ, гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх боломжтой. Энэхүү бүтцийн гол зорилго нь зөвхөн эрсдэлийг бууруулахад оршдоггүй, эрсдэлийг зөв үнэлж тодорхойлох ба түүнийг удирдахад оршдог.

Сан нь эрсдэлийг ойлгох, удирдах нь ажилтан бурийн үүрэг гэсэн соёлыг бий болгохоор зорьж ажиллах бөгөөд ингэснээр аливаа шийдвэр гаргахад томоохон суурь нь болж чадна гэж найдаж байна. Сангийн бүх түвшинд тухайлбал, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий ажилтнууд эрсдэлийн менежментийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл болон мэдлэгтэй байх ёстой. Энэ тогтолцоог бий болгохын тулд тогтмол хугацаанд ажилчдаа сургалтанд хамруулж ажиллах болно.

Дотоод хяналтаас гадна хөндлөнгийн хяналт тавьж ажилласнаар засаглалын эрсдэлийг цогцоор нь бууруулах боломжтой. Энэ хяналтаар эрсдэлийн удирдлага, хууль, хяналт, санхүү болон аудитын газрууд нь нэг цогц удирдлагад төвлөрөх эсвэл тус тусдаа удирдах зарчмаар ажиллаж болох ба хөндлөнгийн хяналтыг бид нэр хүнд бүхий аудитын байгууллагаар хийлгэж явах болно.

Сангийн нэгж эрх эзэмшигчдэд үүсэх эрсдэл

Эрсдэлийн нэр	Эрсдэлийг удирдах арга зүй
Шинэ үнэт цаас	Сан нь Монгол Улсад анх удаа байгуулагдаж байгаа хамтын хаалттай сан юм. Тиймээс Сан нь үйл ажиллагаа, арилжааны идэвхийн түүх байхгүй бөгөөд Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд шинэ бүтээгдэхүүн юм. Мөн хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллалагаа хэрхэн явагддагийг мэдээгүй буюу ойлголтын зөрүүгээс үүдэн нэгж эрх эзэмшигчдэд эрсдэл үүсэх боломжтой. Тийм учраас Сан нь Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гарч буй энэхүү бүтээгдэхүүнийхээ талаар олон нийтэд таниулах ажлыг өөрийн вэб сайт, сошиал сүлжээ, хэвлэл мэдээллээр дамжуулан өргөн хүрээнд танилцуулах болно.
Хөрөнгө оруулалт ба зах зээлийн эрсдэл	Санд хөрөнгө оруулалт хийх нь хувьцаанд хөрөнгө оруулсантай адилхан эрсдэлтэй юм. Санд хөрөнгө оруулалт хийх нь шууд бус байдлаар хувьцаанд хийх хөрөнгө оруулалт болж байдаг. Сангийн нэгж эрх нь зах зээл дээрх бусад хөрөнгө оруулалтуудын адил богино хугацаанд ханш хэлбэлзэх, урьдчилан тооцоолоогүй байдалд хүрэх боломжтой. Сангийн хөрөнгө нь ногдол ашиг болон дахин хөрөнгө оруулалт хийсний дараа ч анхны хөрөнгө оруулалтаас бага байх боломжтой. Сан нь энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд судалгаа шинжилгээнд суурилсан хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын багцаа олон төрлийн үнэт цаасаар бүрдүүлэх зэргээр эрсдэлээ бууруулж ажиллана.



Нэгж эрхийн зах зээлийн үнэ Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнээс бага байх эрсдэл	Сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгөд суурилсан үнэлгээ нь Сангийн нийт цэвэр хөрөнгийн үнэ цэнээр тодорхойлогдох ба харин нэгж эрхийн зах зээл дээр арилжаалагдаж байгаа ханш нь хөрөнгө оруулагчдын үүсгэж буй эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно. Иймд нэгж эрхийн зах зээлийн ханш нь нэгж эрхийн үнэ цэнээс ялгаатай байж болох бөгөөд энэ нь богино хугацаанд ашиг хийх зорилготой хөрөнгө оруулагчдад эрсдэл бий болгоно. Тиймээс Сан нь урт хугацааны хөрөнгө оруулагчдад илүү тохиромжтой юм.
Ногдол ашгийн эрсдэл	Сан нь ногдол ашгийн бодлогын дагуу ашгийнхаа 30 хүртэл хувийг ногдол ашиг хэлбэрээр нэгж эрх эзэмшигчдэд хуваарилахаар төлөвлөж байгаа билээ. Гэвч төлөвлөж буй хэмжээнд ашиг орлоготой ажиллаж чадахгүй тохиолдолд ногдол ашиг хуваарилахгүй байх боломжтой юм. Иймд Сан нь ирээдүйд төлөвлөсөн хэмжээгээр тогтсон хугацаанд ногдол ашиг төлөхийг баталгаажуулахгүй болно.
Хөрвөх чадварын эрсдэл	Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй. Хэрэв нэгж эрх эзэмшигчид нэгж эрхээ худалдахыг хүсвэл Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хоёрдогч зах дээр арилжаалах боломжтой байдаг. Харин энэ үед хөрвөх чадварын эрсдэл буюу зах зээл дээр худалдан авагч олдохгүй байх эрсдэл үүсэж болно.



7. ХАВСРАЛТ

7.1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, БҮТЭЦ

	Сангаас гарах нийт зардал /хөрөнгийн тухайн үеийн үнэ цэнээс жил бүр төлөх хувь хэмжээ/	%
1	Нийт үйлчилгээний зардлын хувь хэмжээ, жилээр	2.7%-3.5%
1.1	- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээнд	2.5%
1.2	- Хөрөнгө хадгалах үйлчилгээнд	0.35%
1.3	- Багц бүрдүүлэлтэнд /арилжааны шимтгэл, хураамж/	0.28%-0.86% (хувьсах)
1.4	- Бусад /зар сурталчилгээ, аудит гэх мэт/	0.43%-0.69% (хувьсах)
	Нэгж эрх эзэмшигчээс гарах зардал /хөрөнгө оруулалтын дүнгээс/	
2	Нэгж эрх худалдан авах, худалдахтай холбоотой зарал	Нэгж эрх эзэмшигч нь үйлчлүүлж буй үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг төлне.

7.2. “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ” ТУХАЙ 20/10 тоот төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

ARD МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

2020 06 02

Drawn 20/10

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Үндэсний Хувьчлалын Сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Компанийн тухай хуулийн 62.1.1 дахь заалт, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС (цаашид ХОС гэх)-ийн дурмийн 10.2.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энээ санал хураалтыг тус тус ундерсэн ТОГТООХ Нь:

- ХОС-ийн нэгж эрхийг олон нийтэд санал болгох, хөрөнгө татан төвлөрүүлэхгүй холбоотой “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС нэг бүр нь 100 төгрөгийн изрэлсэн үнэ бүхий 47,500,000 (дөчин долоон сая таван зуун мянга) ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгосутай.
 - ХОС-ийн нийт гаргасан нэгж эрхийг 50,000,000 (тавин сая) ширхэг, нийт хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг болгосутай.
 - ХОС-ийн нэг нэгж эрхийг 100 төгрөгөөр олон нийтэд санал болгосутай.
 - ХОС нэмж нэгж эрх гаргаж байгаатай холбогдуулан Ард Менежмент УЦК ХХК нь өөрийн эзэмшиж буй нэгж эрхтэй хувь гэнцүүлэн тэргүүн ээлжинд нэгж эрх худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүэй.



2020 -08 - 24

ARD МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

5. ХОС нэмж нэгж эрх гаргаж, олон нийтэд санал болгож байгаатай холбогдуулан ХОС-ийн дүрмийг тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
6. ХОС-ийн нэгж эрхийг олон нийтэд санал болгох, хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотой ажлыг удирдан зохион байгуулах энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, ХОС-ийн дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал Ч.Хандаа-д даалгасугай.

ДАРГА

Ч.ГАНХУЯГ

7.3. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН “УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН ДҮРМИЙН НАЙРУУЛГА

“Ундэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС ХХК-ийн
Нэгж эрх эзэмшигчдийн 2020 оны 6 сарын 2-ны өдрийн хурлын
№ 20/10 тоот шийдвэрийн 1 дүгээр хавсралт

“УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- “Ундэсний хувьчлалын сан” Хамтын хөрөнгө оруулалтын сан (цаашид “Сан” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос гаргасан дүрэм, журам, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү Дүрмийг үйл ажиллагаандaa удирдлага болгон ашгийн төлөө хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зориулалтын компани байна.

Хоёр. Сангийн оноосон нэр, хаяг

- Сангийн оноосон нэр:
 - Монголоор: “Ундэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС ХХК;
 - Англиар: “National Privatization Fund” closed-end fund.
- Сангийн оршин байгаа газар, албан ёсны хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар;
Утас: 77078080;
- Цахим хаяг: info@ardmanagement.mn
- Сан нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- Сан нь өөрийн “Ундэсний хувьчлалын сан” Хамтын ХОС гэсэн нэрийг бүх үйл ажиллагаандaa ашиглана.
- Сан нь үүсгэн байгуулах баримт бичиг болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Гурав. Сангийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хугацаа



- 3.1 Сан нь хамтын хөрөнгө оруулалтын сан (Хамтын ХОС)-гийн хэлбэртэй байна.
- 3.2 Сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан байна.
- 3.3 Сан нь зөвхөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой байна.
- 3.4 Сан нь үйл ажиллагаагаа 10 (арван) жилийн хугацаатай явуулна.
- 3.5 Сан нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллаж, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.
- 3.6 Санг үүсгэн байгуулагч нь үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.9-д заасан ажиллагаа бүрэн хийгдэж, Сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр Санг үүсгэн байгуулагдсанд тооцно.
- 3.7 Сан нь Хорооноос тусгай зөвшөөрөл авч, Сангийн үйл ажиллагааг эхлүүлснээр зөвхөн хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зориулалтын компани байна.

**Дөрөв. Сангийн хөрөнгө, санд хөрөнгө оруулах хэрэгсэл, активыг байршуулахад
 тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрийн
 эрсдэлийн удирдлага**

- 4.1 Сан нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000,000 (тавин сая) ширхэг зарласан нэгж эрхтэй байна.
- 4.2 Санд төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байна.
- 4.3 Сан нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000,000 (тавин сая) ширхэг нэгж эрхийг эргэлтэд гаргасан бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгө нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг болно.
- 4.4 Сангийн нэгж эрх тус бүр нь сангийн гишүүдийн хуралд саналын нэг эрхтэй оролцох ба нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд тус бүрийн саналын эрх нь тэдгээрийн тус бүрийн өмчлөл, эзэмшил дэх нэгж эрхийн тоогоор тодорхойлогдоно.
- 4.5 Сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл активын бүтэцдээ оруулахыг хориглоно.
- 4.6 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд:
 - 4.6.1 Засгийн газрын өрийн хэрэгсэл;



- 4.6.2 Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
 - 4.6.3 Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
 - 4.6.4 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
 - 4.6.5 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.
- 4.7 Сан нь зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг холбогдох хууль журамд тусгагдсан бусад хэрэгслүүдэд хөрөнгө оруулж болно.
- 4.8 Сан нь энэхүү Дүрэмд зааснаас өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.
- 4.9 Сан нь Дүрмийн 4.6-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулсантай холбоотой үүсэж болох эрсдэлд тухай бурд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

Тав. Сангийн нэгж эрх эзэмшигч

- 5.1 Сангийн гаргасан нэгж эрхийг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд Сангийн нэгж эрхийн эзэмшигч болно.
- 5.2 Сан нь түүний нэгж эрхийг эзэмшигч хуулийн этгээдийн өмчлөл дэх сангийн нэгж эрхийн хувь, хэмжээнээс үл хамаарч тухайн нэгж эрхийг эзэмшигч хуулийн этгээдээс хараат бус байх бөгөөд Компанийн тухай хуульд заасан охин болон хараат компани, толгой компанийн хоорондын эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй.
- 5.3 Сангийн нэгж эрхийг эзэмшигч хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээсэн үүргийг зөвхөн тухайн хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгөөр хариуцна. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь сангийн өр төлбөр болон аливаа үүргийг өөрийн хөрөнгөөр хариуцахгүй.
- 5.4 Сан нь нэгж эрхийг эзэмшигч болон санд үйлчилгээ үзүүлж байгаа Хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид “Менежментийн компани” гэх), кастодианы бусдын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.
- 5.5 Сангийн нэгж эрхийн бүртгэлийг санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан хөтөлнө.
- 5.6 Хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг анхдагч зах зээлд худалднаас олсон төлбөрийг санд бүрэн төлснөөс хойш ажлын 1-3 өдрийн дотор брокер эсхүл кастодианаар дамжуулан Сангийн нэгж эрхийг эзэмшигч болсныг бүртгүүлж, баталгаажуулна.

Зургаа. Хөрөнгө оруулалтын менежментийн компани

- 6.1 Менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь Санг үүсгэн байгуулах, Санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг, үйл ажиллагааг эрхлэх төлөөлөх ажиллагаа байна.
- 6.2 Санг үүсгэн байгуулагч Менежментийн компанийн нэр, оршин байгаа газрын хаяг:





№	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	Регистрийн дугаар, Тусгай зөвшөөрлийн дугаар	Хаяг	Утас, Цахим хуудас
1.	“Ард Менежмент УЦК” ХХК	5510759 №: 380/09	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар	77078080, 88114679 ardmanagement. mn

- 6.3 Менежментийн компани нь Санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн Сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна.
- 6.4 Менежментийн компанийтай байгуулах “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” нь энэхүү Дүрмийн 3.5-д заасан хугацаатай адил хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дуусгавар болгосонбол хүчин төгөлдөр бусад тооцогдоно.
- 6.5 Менежментийн компани нь энэхүү Дүрмийн 6.4-д заасны дагуу Сантай байгуулсан гэрээ дуусгавар болсон буюу цуцлагдсан тохиолдолд дараагийн Менежментийн компанийтай гэрээ байгуулах, уг гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл гэрээнд заасан үүргээ тасралтгүй хэрэгжүүлнэ.

Долоо. Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд

- 7.1. Кастодиан нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг Сантай байгуулсан “Хөрөнгө хадгалах гэрээ”-ний үндсэн дээр эрхэлнэ.
- 7.2. Санд Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг:

№	Кастодианы нэр	Регистрийн дугаар	Хаяг	Утас, Цахим хуудас
1.	Голомт Банк ХХК	2075377	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Очир Төв, Голомт Кастодиан, 503 тоот	custody@golomtbank.com

- 7.3. Кастодиан нь Санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна.



Найм. Сангийн нэгж эрхийг арилжих

- 8.1. Сан нь нэгж эрхээ нийтэд санал болгох замаар хөрөнгө төвлөрүүлэх бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд чөлөөтэй арилжаална.
- 8.2. Сангийн нэгж эрх нь хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжаалагдах бөгөөд Сан нь хоёрдогч зах зээл дэхь арилжаалагдах үнийг тогтоход үүрэг хүлээхгүй.
- 8.3. Сан нь гүйлгээнд гаргасан нэгж эрхээ буцааж худалдаж авах үүрэг хүлээхгүй.
- 8.4. Сан нь нийтээс хөрөнгө оруулалт татах ажиллагааг сангийн нэгж эрхийн танилцуулгад үндэслэн хэрэгжүүлнэ.
- 8.5. Хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг худалдан авах гэрээг байгуулж, нэгж эрхийн төлбөрийг бүрэн төлснөөр Сангийн нэгж эрх эзэмшигч болж энэхүү Дүрэм болон бусад хууль тогтоомжид заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Ес. Нэгж эрх эзэмшигчдийн эрх, үүрэг

- 9.1. Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
 - 9.1.1. Сангийн үйл ажиллагааны орлогоос өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн ногдол ашиг хүртэх;
 - 9.1.2. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын эрхтэй оролцох;
 - 9.1.3. Бусад нэгж эрх эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа нэгж эрхээ чөлөөтэй захиран зарцуулах;
 - 9.1.4. Санг татан буугдах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;
 - 9.1.5. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй нэгж эрхээ энэхүү Дүрэмд заасан зохицуулалтын хүрээнд захиран зарцуулах (худалдах, бэлэглэх, барьцаалах, өв залгамжуулах болон хуулиар зөвшөөрсөн бусад хэлбэр);
 - 9.1.6. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь Сангаас нэмж гаргаж буй нэгж эрхээс өөрийн эзэмшиж буй хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;
 - 9.1.7. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь хөрөнгө оруулалтын сангийн талаарх тохирох мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
 - 9.1.8. Кастодиан банкны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх; Нэгж эрх эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа нэгж эрхийн тоог нэгж эрх эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх,





түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх үүрэг хүлээнэ.

- 9.1.9. Энэхүү 9.1.8-т заасны дагуу бүртгүүлснээр нэгж эрх эзэмшигчийн эрх үүснэ.
- 9.1.10. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Арав. Сангийн удирдлага

- 10.1 Сангийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байна.
- 10.2 Сангийн төлөөлөн удирдах зөвлөл (“ТҮЗ”) нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хөрөнгө оруулалтын сангийн эрх барих байгууллага байна.
- 10.3 Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага эрхлэх бөгөөд уг бүрэн эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр Менежментийн компани өөрөө эсхүл уг Менежментийн компаниас томилсон эрх бүхий Сангийн менежер хэрэгжүүлнэ.

Арван нэг. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

- 11.1 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэг адил хамаарна
- 11.2 Дараах асуудлыг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 11.2.1 Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Сангийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 11.2.2 Санг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;
 - 11.2.3 Сангийн өрийг нэгж эрхээр солих, нэмж гаргах нэгж эрхийн тоог тогтоох;
 - 11.2.4 Сангийн нэгж эрхийг хуваах болон нэгтгэх;
 - 11.2.5 Санг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 11.2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 11.2.7 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан, ТҮЗ-өөр шийдвэрлэж чадаагүй их хэмжээний хэлцлийг батлах;
 - 11.2.8 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан, ТҮЗ-өөр шийдвэрлэж чадаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 11.2.9 Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн болон менежментийн компанийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;



2020 -08- 24

- 11.2.10 Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
- 11.2.11 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ-аас оруулсан асуудлууд;
- 11.2.12 Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны Хамтын Хөрөнгө Оруулалтын Сангийн Үйл Ажиллагааны тухай журамд заасан бусад асуудлууд.

Арван хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл

- 12.1 Сангийн ТУЗ нь 5 (таван) гишүүнтэй байх ба тэдгээрийн 1/3-аас багагүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан байна.
- 12.2 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 (хоёр) жил байх бөгөөд улируулан сонгож болно.
- 12.3 ТУЗ нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 12.3.1 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах;
 - 12.3.2 Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - 12.3.3 Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан Гүйцэтгэх удирдлагын дүгнэлтийг хэлэлцэх;
 - 12.3.4 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 12.3.5 Сангийн аудиторыг сонгох, гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 12.3.6 Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 12.3.7 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 12.3.8 Сангийн нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах талаар сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 12.3.9 Сангийн дотоод хяналтын хорооны гишүүдийг томилох;
 - 12.3.10 Энэхүү Дүрэмд заасан зарласан нэгж эрхийн тоонд багтаан нэгж эрх гаргах;
 - 12.3.11 Энэхүү дүрэм болон сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.



- 12.3.12 Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны Хамтын Хөрөнгө Оруулалтын Сангийн Үйл Ажиллагааны тухай журамд заасан бусад асуудлууд.
- 12.4 ТУЗ-ийн гишүүн нь удаан хугацаагаар (зургаан сараас дээш) үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилно.
- 12.5 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн нийт гишүүний олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
- 12.6 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, Сангийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулна.
- 12.7 ТУЗ нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 12.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд 1 (нэг) удаа хуралдуулна.
- 12.9 ТУЗ нь аудитын хороо, дотоод хяналтын хороотой байж болно.
- 12.10 ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 12.11 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурна.
- 12.12 ТУЗ-ийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Арван түрав. Гүйцэтгэх удирдлага

- 13.1 Менежментийн компани, Сангийн менежер нь энэхүү Дүрэм болон Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулна.
- 13.2 Гүйцэтгэх удирдлага буюу Менежментийн компани нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Энэ гэрээнд Менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, үйлчилгээний зардлын төлбөр, гүйцэтгэлийн урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 13.3 Менежментийн компани нь Сангаас олгосон эрх хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалт, хэлцэл хийх, гэрээ байгуулах, төлөөлөх зэргээр Сангийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.
- 13.4 Менежментийн компани нь Сангаас олгосон эрх хэмжээнээс давсан хөрөнгө оруулалт, хэлцэл хийх, гэрээ байгуулах тухай бүрдээ ТУЗ-аас бичгээр зөвшөөрөл авна.



2020 -08- 24

- 13.5 Менежментийн компани нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 13.5.1 Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах;
 - 13.5.2 Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тухайн хөрөнгө оруулалтын санг төлөөлөх бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа ТУЗ болон нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулах;
 - 13.5.3 Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаандaa тухайн Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах; Энэхүү Дүрмээр зарласан нэгж эрхийн хэмжээний дотор шинээр нэгж эрх гаргаж хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 13.5.4 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах;
 - 13.5.5 Санд үйлчилгээ үзүүлэх кастодиан, аудит, үнэлгээчнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж ТУЗ болон нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулах;
 - 13.5.6 Санг татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 13.5.7 Санг татан буулгасан тохиолдолд хөрөнгийг хуваарилах;
 - 13.5.8 Ногдол ашиг тараах үйл ажиллагааг зохион байгуулах;
Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулалтын шийдвэрийг хөрөнгө оруулалтын менежментийн компани гаргах;
 - 13.5.9 Хорооноос тогтоосон хугацаанд холбогдох журмын дагуу тайлан мэдээ гаргах, хүргүүлэх;
 - 13.5.10 Хууль тогтоомжид заасан бусад.
- 13.6 Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Менежментийн компаниас томилсон Сангийн менежер удирдана.
- 13.7 Сангийн менежер нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 13.7.1 Хууль тогтоомж болон энэхүү Дүрэм, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;
 - 13.7.2 Сангийн хөрөнгө нь сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шалгуурыг хангаж байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;



- 13.7.3 Кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийн хүрээнд хяналт тавих эрхтэй;
- 13.7.4 Кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;
- 13.7.5 Менежер нь гэрээний үндсэн дээр үндсэн дээр нэгж эрх эзэмшигчийн тухайлсан бүртгэлийг үнэт цаасны төлбөр, тооцоо гүйцэтгэх эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж болно.
- 13.7.6 Сантай холбоотой хөрөнгийн бүхий л гүйлгээнд хяналт тавих, эрсдэлийг тооцох;
- 13.7.7 Сангийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйд хувийг нь холбогдох санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэж байгаа мэргэшсэн нягтлан бодогч болон кастодианд хүргүүлэх;
- 13.7.8 Сан нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нэгж эрх эзэмшигчдийн болон эрх бүхий албан тушаалтан, төлөөлөгчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахдаа Хорооноос зөвшөөрөл авах;
- 13.7.9 Сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, байгуулсан гэрээнд зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөс гүйцэтгэхгүй байх;
- 13.7.10 Сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигч гишүүдийг мэдээллээр хангаж ажиллах;
- 13.7.11 Сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд нэгж эрх эзэмшигчдийн бүтэц, тухайн сангийн нийт гаргасан нэгж эрхийн 5 хувь ба түүнээс дээш хэмжээний нэгж эрхийг эзэмшигчдийн жагсаалтыг тусган нийт нэгж эрх эзэмшигчдэд мэдэгдэх;
- 13.7.12 Сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд Сангийн менежер нь өөрийн үйл ажиллагааны тайланг тусгаж Хороонд хүргүүлэх;
- 13.7.13 Санд хөрөнгө оруулах боломжтой аливаа этгээдэд мэдээллийг үнэ төлбөргүй гарган өгөх, зөвлөгөө өгөх;
- 13.7.14 Үйл ажиллагаандаа Сангийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, хууль болон энэхүү Дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;
- 13.7.15 Сангийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;



- 13.7.16 Санг татан буулгах журмын төслийг боловсруулж, сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн татан буулгах шийдвэрийн хамт батлуулах;
- 13.7.17 Хууль болон Сангаас тогтоосон бусад эрх, үүрэг.
- 13.8 Сангийн менежер нь сангийн хөрөнгийг энэхүү дүрэм, Сангийн журамд зааснаас бусад зориулалтаар санаатайгаар ашигласан хууль бус үйлдэл нь сангийн актив болон хөрөнгийн бүтцэд хамаарах хөрөнгөд хохирол учруулсан нь тогтоогдсон бол уг хохирлыг сангийн менежер өөрийн хөрөнгөөр барагдуулна.

Арван дөрөв. Хөрөнгө оруулалтын бодлого

- 14.1 Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигтэй байна.
- 14.2 Сангийн активыг энэхүү дүрмийн 4.6-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулна.
- 14.3 Сангийн бодлогын баримт бичигт дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:
- 14.3.1 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо;
 - 14.3.2 Хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын хэрэгслийн жагсаалт, хязгаарлалт;
 - 14.3.3 Энэхүү дүрмийн 14.3.2-т заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулсантай холбогдон үүсэж болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийн тухай;
 - 14.3.4 Сангийн активын бүтцэд тавих шаардлага;
 - 14.3.5 Сангийн орлогоос гишүүдэд орлого хуваарилах бодлого.

Арван тав. Кастодиан банк

- 15.1 Сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага сантай байгуулсан Хөрөнгө хадгалалтын гэрээний дагуу явуулна.
- 15.2 Сан нь кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах гэрээнд дараах зүйлийг заавал тусгана. Үүнд:
- 15.2.1 Сангийн бүх хөрөнгийн бүртгэлийг хөтлөх тухай;
 - 15.2.2 Хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд заасны дагуу сангийн нэгж эрхийн бүртгэлийг хөтлөх, нэгж эрхийн өмчлөх эрхийн бүртгэлийг хөтлөх;
 - 15.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалтын тухай, гүйлгээг хэрхэн гүйцэтгэх тухай;
 - 15.2.4 Сангийн хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн үнэлгээг хууль тогтоомжид заасан аргачлалын дагуу гүйцэтгэх тухай;



- 15.2.5 Сангийн орлогыг хууль тогтоомж болон сангийн дүрэмд заасан зориулалтаар ашиглах ажиллагаанд хяналт тавих тухай;
- 15.2.6 Сангийн хөрөнгөтэй холбоотой сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн даалгаврыг хууль тогтоомж болон Сангийн дүрэм, журамтай зөрчилдөөгүй нөхцөлд саадгүй хэрэгжүүлэх тухай;
- 15.2.7 Хөрөнгө хадгалах үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлөх тухай.

**Арван зургаа. Сангийн орлого, орлого зарцуулалт,
ногдол ашиг хуваарилах**

- 16.1 Сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 16.1.1 Хөрөнгө оруулалтын орлого;
- 16.1.2 Бусад орлого.

- 16.2 Хөрөнгө оруулалтын орлогод Сангийн худалдан авч эзэмшиж буй санхүүгийн хэрэгслийн ханшийн зөрүүний орлого, хүү, ногдол ашгийн орлого болон хууль, журамд заасан бусад орлого хамаарна.
- 16.3 Сангийн ногдол ашгийн хуваарилах талаар Менежментийн компанитай харилцан тохиролцсоны дараа ТУЗ-өөс шийдвэрлэнэ.

Арван долоо. Хөрөнгө оруулалтын сангийн зардал

- 17.1 Сангийн хөрөнгийг захиран зарцуулахдаа Сангийн үйл ажиллагаанд хуулиар оролцохыг зөвшөөрсөн этгээдүүдэд төлөх үйлчилгээний хөлс, Сангийн үйл ажиллагааг үдирдан зохион байгуулах, хэвийн, тасралтгүй, тогтмол үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардлагатай зардал дээр үндэслэгдэх зарчим баримтална.
- 17.2 Сангийн хөрөнгийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
 - 17.2.1 ТУЗ-ийн гишүүдийн хараат бус үр дүнтэй үйл ажиллагааг хангуулах зорилготой Дүрэмд заасны дагуу тогтоосон цалин хөлс;
 - 17.2.2 Хөрөнгө итгэмжлэн үдирдах гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын менежментийн компанид төлөх төлбөр, гүйцэтгэлийн урамшуулал;
 - 17.2.3 Хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр кастодианд төлөх төлбөр;
 - 17.2.4 Банкны үйлчилгээний шимтгэл, хураамжууд;
 - 17.2.5 Брокерийн үйлчилгээний шимтгэл, хураамж;
 - 17.2.6 Аудит болон нягтлан бодох бүртгэл хөтлөх үйлчилгээнд төлөх төлбөр;
 - 17.2.7 Хуулийн үйлчилгээний зардал;



- 17.2.8 Сангийн актив хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомжид заасан улсын тэмдэгтийн бүх төрлийн хураамж;
 - 17.2.9 Сангийн актив хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомжид заасан бүх төрлийн татвар;
 - 17.2.10 Сангийн нэгж эрхийн эзэмшигчдийн хурлын зардал;
 - 17.2.11 Нэгж эрхийг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох, худалдахтай холбоотой гарсан Сангийн менежерийн үйл ажиллагааны зардал;
 - 17.2.12 Хууль тогтоомжид Сан хариуцахаар заасан бусад зардал.
- 17.3 Сангийн зардлын гүйлгээ нь Сангийн менежер эсхүл түүнийг орлох этгээд, Нэгж эрх эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн бол хурлаас зөвшөөрсөн этгээдийн гарын үсэг болон сангийн тэмдэг (тамга)-ээр баталгаажсан байна.
- 17.4 Сангийн хөрөнгөнөөс Менежментийн компанийн болон Сангийн менежерийн бусдын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахгүй.
- 17.5 Энэхүү Дүрмийн 17.2.2, 17.2.3-д заасан зардлын нийлбэр дүн нь Сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 3 хувиас хэтрэхгүй байна.
- 17.6 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны гэрээнд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэлийн урамшуулал өгөхөөр тохиролцсон тохиолдолд хэмжээ нь сангийн ашгийн 30 хувиас хэтрүүлэхгүйгээр тусгана.

Арван найм. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл

- 18.1 Сангийн нягтлан бодох бүртгэлийг бүртгэлийн олон улсын стандартын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөтөлне.
- 18.2 Сангийн нягтлан бодох бүртгэлийг Менежментийн компани гүйцэтгэх бөгөөд эсхүл хуульд заасан эрхтэй хуулийн этгээд болон мэргэшсэн нягтлан бодогчоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
- 18.3 Сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх этгээд нь тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан, аудитын компани, түүний ажилтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

Арван ес. Хөрөнгө оруулалтын сангийн хяналтын тогтолцоо

- 19.1 Сангийн үйл ажиллагааны хяналт нь дараах хяналтаас бүрдэнэ. Үүнд:
- 19.1.1. Дотоод хяналт;
 - 19.1.2. Аудитын хяналт;
 - 19.1.3. Хорооноос хэрэгжүүлэх хяналт, зохицуулалт.



- 19.2 Энэхүү дүрмийн 19.1-т заасан хяналтыг хэрэгжүүлэх этгээдүүд нь харилцан хамааралгүйгээр хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 19.3 Дотоод хяналт шалгалтыг Хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон 3 (гурав) гишүүнтэй Дотоод хяналтын хороо гүйцэтгэнэ.
- 19.4 Дотоод хяналтын хорооны гишүүдийн нэг нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр 3 (гурав)-аас доошгүй жил ажилласан этгээд байна.
- 19.5 Дотоод хяналтын хорооны гишүүд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 19.5.1. Тухайн ажилд хамааралтай, шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;
 - 19.5.2. СЗХ-оос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байх;
 - 19.5.3. Холбогдох ажлын туршлагатай байх;
 - 19.5.4. Хараат бус, бие даасан, сонирхлын зөрчилгүй байх.
- 19.6 Аудитын хяналтыг Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 19.7 Сангийн үйл ажиллагаанд тавих СЗХ-ны хяналт нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавихад оршино.

Хорь. Санг татан буулгах

- 20.1 Санг дараах тохиолдолд татан буулгана. Үүнд:
 - 20.1.1 Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;
 - 20.1.2 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас санг сайн дурын үндсэн дээр хугацаанаас өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;
 - 20.1.3 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулсан бөгөөд Сангийн нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонх санг татан буулгах шийдвэр гаргасан;
 - 20.1.4 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу онцгой нөхцөл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
 - 20.1.5 Сан дампуурсан;
 - 20.1.6 Төлбөрийн чадваргүй болох;
 - 20.1.7 Хууль тогтоомжид заасан бусад.



- 20.2 Хөрөнгө оруулалтын санг татан буулгах шийдвэрийг дараах этгээд гаргана:
- 20.2.1 Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал;
 - 20.2.2 Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий бусад этгээдийн хүсэлтийг үндэслэн шүүх;
 - 20.2.3 Энэхүү дүрмийн 20.1.1-20.1.3-д заасан үндэслэлээр санг татан буулгах шийдвэрийг нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гаргана.
 - 20.2.4 Энэхүү дүрмийн 20.1.4-20.1.5-д заасан үндэслэлээр санг татан буулгах шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий этгээдийн хүсэлтээр Монгол Улсын шүүх гаргана.

Хорин нэг. Сангийн хөрөнгийг хуваарилах

- 21.1 Татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг дараах дарааллын дагуу хуваарилна. Үүнд:
- 21.1.1 Сангийн төлөх татварын өр, төлбөр;
 - 21.1.2 Санд үйлчилгээ үзүүлсэн бусад этгээдэд төлөх өр, төлбөр;
 - 21.1.3 Санг татан буулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа төрийн болон эрх бүхий байгууллагад төлөх төлбөр;
 - 21.1.4 Хөрөнгө хадгалах гэрээний дагуу кастодианд төлөх үйлчилгээний төлбөр;
 - 21.1.5 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний төлбөр.
- 21.2 Энэхүү Дүрмийн 23.2-д заасны дагуу хөрөнгийг хуваарилж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сангийн нэгж эрх эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь мөнгөн хөрөнгөөр хувь тэнцүүлэн олгоно.

Хорин хоёр. Сангийн дүрэм хүчин төгөлдөр болох

- 22.1 Энэхүү Дүрмийг 4 [дөрөв] хувь үлдсэн бөгөөд үүсгэн байгуулагч нэг хувийг, Санхүүгийн зохицуулах хороо нэг хувийг, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газар нэг хувийг, үйлдсэн нэг хувийг Сан өөртөө хадгална.
- 22.2 Энэхүү дүрэм нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батлагдаж, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 22.3 Энэхүү Дүрэм нь Сангийн үндсэн баримт бичиг байна.
- 22.4 Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

-----ооОоо-----



7.4. “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ

2020 оны 6 сарын 2-ны өдөр

Дугаар №: 20/14

Улаанбаатар хот

Энэхүү Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Иргэний тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журам болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дагаж мөрдөхөөр тогтоосон бусад холбогдох хэм хэмжээг удирдлага болгон;

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэлийн байр хаягт үйл ажиллагаа эрхэлдэг “Ард Менежмент ҮЦК” ХХК (Reg.No:5510759, цаашид “ХОМК” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ч.Хандаа;

нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэлийн байр хаягт үйл ажиллагаа эрхэлдэг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС (Reg.No: 6457983, цаашид “ХОС, “Сан” эсхүл “Үйлчлүүлэгч” гэх), түүнийг төлөөлж ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг нар (тус тусад нь “Тал” эсхүл “Гэрээний тал”, хамтад нь “Талууд” гэх) нь харилцан тохиролцож, дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний зорилго нь ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, өдөр тутмын үйл ажиллагааг явуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх, үйлчилгээний хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээнд Талууд харилцан тэгш эрхтэй оролцох бөгөөд Гэрээний зүйл, заалттай танилцаж, хүлээн зөвшөөрч, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн болно.
- 1.3 Гэрээ байгуулахын өмнө ХОМК нь Үйлчлүүлэгчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг танилцуулсан болно.
- 1.4 Энэхүү Гэрээнд хавсаргагдсан баримт материалууд нь Гэрээний салшгүй нэг хэсэг, бүрдэлд тооцогдох бөгөөд Гэрээ нь хавсралт болон хавсаргагдсан баримтуудын хамтаар хүчин төгөлдөр үйлчилнэ.



ХОЁР. ГЭРЭЭНИЙ НЭР ТОМЬЁО

- 2.1 Гэрээнд хэрэглэгдэх нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 “Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани” эсхүл “ХОМК” гэж “Ард Менежмент УЦК” ХХК-г;
 - 2.1.2 “Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ” Гэрээнд үндэслэн ХОС-ийн үнэт цаас, мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхийг;
 - 2.1.3 “Үйлчлүүлэгч”, “ХОС” эсхүл “Сан” гэж “Ундэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийг;
 - 2.1.4 “Кастодианы данс” гэж ХОС-ийн нэр дээр Кастодианд нээсэн дансыг;
 - 2.1.5 “Хөрөнгө” гэж ХОС-ийн өмчлөлийн үнэт цаас, мөнгө, хуулиар хориглоогүй бусад санхүүгийн болон хөрөнгө оруулалтын хэрэгслийг;
 - 2.1.6 “Үнэт цаас” гэж Монгол Улсын Үнэт цаасны тухай хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгслийг;
 - 2.1.7 “Мөнгөн хөрөнгө” гэж ХОС-ийн данс дахь мөнгө болон түүнтэй адилтгах хэмжээний эд хөрөнгийг;
 - 2.1.8 “Гишүүн” гэж ХОС-ийн нэгж эрхийг эзэмшиж буй иргэн хуулийн этгээдийг;
 - 2.1.9 “Нэгж эрх” гэж Гишүүнээс ХОС-д оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;
 - 2.1.10 “СЗХ” гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ХЭЛБЭР

- 3.1. Энэхүү гэрээний хугацаа нь ХОС-ийн дүрэмд заасан сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нэгэн адил буюу 10 (арван) жил байна.
- 3.2. ХОМК нь ХОС-ийг үүсгэн байгуулах, ХОС-д хөрөнгө оруулалт татахтай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулж, түүнд тохирсон үйлчилгээний хөл авна.
- 3.3. ХОМК нь ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө удирдах, захиран зарцуулах болон бусад нэмэлт үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:
 - 3.3.1. ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах, оффис, хүний нөөц, харилцаа холбоогоор хангах;
 - 3.3.2. ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 3.3.3. Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу ХОС-ийн хөрөнгийг удирдаж, хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах, хөрөнгө оруулалт худалдах, худалдан авах;
 - 3.3.4. ХОС-ийг төлөөлөх, бусадтай гэрээ байгуулах, ХОС-ийн хөрөнгийг захиран зарцуулах хэллцийг хийх,
 - 3.3.5. Энэхүү гэрээнд тусгагдсан зардлыг ХОС-ийн хөрөнгөөс гаргаж, төлбөрийг төлөх;
 - 3.3.6. ХОС-ийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэлтийг хангах;



- 3.3.7. Шаардлагатай бол ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах талаар санал гаргах;
 - 3.3.8. ХОС-ийн талаар гаргасан хуулийн этгээд, иргэдийн гаргасан санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
 - 3.3.9. ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааны хүрээнд ХОС-ийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох;
 - 3.3.10. Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл тайлан бэлтгэх.
- 3.4. ХОМК нь ХОС-ийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаж, тухайн ХОС-ийн нэр дээр нээсэн тусдаа дансанд байршуулж, эрх бүхий Кастодианд хадгалуулна.
- 3.5. ХОМК нь ХОС-ийн доор дурьдсан тайлангуудыг заасан давтамжийн дагуу гаргаж тайлагнана.

Тайлан		
1	Цэвэр хөрөнгийн үнэлгээний тайлан	Өдөр бүр
2	Нэгж эрхийн үнэлгээний тайлан	Өдөр бүр
3	ХОС-ийн жилийн үйл ажиллагааны тайлан	Жил бүр
4	ХОС-ийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан	Жил бүр
5	СЗХ болон бусад хамтран ажиллах байгууллагуудтай байгуулсан гэрээнд тусгасан тайланг холбогдох хууль, журам гэрээнд заасан хугацаанд	
6	НЭЭХ-д хүргэх хурлын материал	Жил бүр
	ТУЗ-д хүргэх хурлын материал	Улирал бүр

- 3.6. ХОМК нь доорх тохиолдлуудад ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна:
- 3.6.1. Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн 26.5-д заасан нөхцөл байдал үүссэн;
 - 3.6.2. ХОМК татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанийд хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн;
 - 3.6.3. Кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;
 - 3.6.4. ХОС-ийн бусдын өмнө хүлээсэн төлберийн үүрэг нь тухайн сангийн цэвэр активыг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.5-д заасан хэмжээнээс бууруулах нөхцөл байдал үүссэн.



- 3.7. ХОС-ийн үйл ажиллагаа дуусгавар болсон өдрөөс эхлэн ХОМК нь ХОС-ийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.8. ХОС-ийг татан буулгах тохиолдолд ХОС-ийн хөрөнгийг хууль, журмын хүрээнд нэгж эрх эзэмшигчдэд хуваарилах үйл ажиллагаа зохион байгуулна.
- 3.9. ХОМК нь ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, хуульд заасан хугацаанд Татвар, Сангийн яам, СЗХ-нд холбогдох тайланг гаргаж хүргүүлнэ. Ингэхдээ доорх бичиг бүрдүүлж хадгална:
 - 3.9.1. ХОС-ийн хөрөнгө оруулалтын бүртгэл, үлдэгдлийн тооцоог холбогдо үнэлгээний аргачлалын хамт хөтлөн, хадгалах;
 - 3.9.2. ХОС-ийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны баримтыг үйлдэнэ.
- 3.10. ХОМК нь ХОС-ийн нэгж эрхийн бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалах ажлыг зохион байгуулна.
 - 3.10.1. ХОМК нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж болно.
 - 3.10.2. ХОМК нь ХОС-ийн нэгж эрхээр гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбогдсон үйлчилгээг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар хийж гүйцэтгүүлж болно.
 - 3.10.3. ХОС-ийн гишүүний бүртгэлийг ХОМК нэгж эрхийн тухайлсан бүртгэл болон Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын мэдээлэлд үндэслэн хөтөлнө.
- 3.11. Сангийн зар сурталчилгааны мэдээлэл нь хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулагч татах, тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны талаар зах зээлд мэдээлэл өгөх мэдээллийн үндсэн арга байна.
 - 3.11.1. ХОМК нь ХОС-д хөрөнгө оруулагчид татах, зар сурталчилгаа болон сангийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх зэрэг маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.12. ХОМК нь нэмэлт үйлчилгээг үзүүлж болно. Талууд харилцан тохиролцож гарын үсэг, тамга тэмдэг дарснаар үйлчилгээний нэмэлт нөхцөл нь энэхүү гэрээний дагуу баталгаажиж, Гэрээний салшгүй хэсэг болно.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ХӨРӨНГИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ

- 4.1. ХОМК нь ХОС-ийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж болно. Үүнд:
 - 4.1.1. Засгийн газрын өрийн хэрэгсэл;
 - 4.1.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
 - 4.1.3. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
 - 4.1.4. Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
 - 4.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;



- 4.1.6. Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг холбогдох хууль журамд тусгагдсан бусад хэрэгслүүд.
- 4.2 ХОМК нь ХОС-ийн хөрөнгөөр Гэрээний 4.1-д заасан зохицуулалттай зах зээлд нийтэд нээлттэй арилжаалагддаг санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.
- 4.3 ХОМК нь ХОС-ийн нийт хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхдээ доорх хязгаарлалтыг баримтална:
 - 4.3.1. Өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн хэмжээ нь сангийн нийт активын 70%-аас хэтрэхгүй байна.
 - 4.3.2. Эдийн засгийн нэг салбарт хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар нь сангийн нийт активын 25%-аас хэтрэхгүй байна.
 - 4.3.3. Нэг компанийн хувьцааны 10-аас дээш хувийг дангаараа эзэмшихгүй байна.
 - 4.3.4. Компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл эсхүл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг зохицуулалттай зах зээлд арилжаалагддаг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийнэ.
- 4.4. ХОМК нь ХОС-ийн нэг удаагийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа ХОС-ийн нийт хөрөнгийн 25 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах эрхтэй. Түүнээс дээш хувийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах бол ТУЗ-өөс зөвшөөрөл авна.
- 4.5. ХОМК нь ХОС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхдээ ХОС-ийн ТУЗ-өөс зөвшөөрөл авна.
- 4.6. ХОМК нь энэхүү гэрээний 4.3 дахь заалтын хүрээнд ХОС-ийн хөрөнгө оруулалт хийшнийд гаргасан боловч үнийн өсөлт бууралт зэрэг гадны хүчин зүйлсийн улмаас энэхүү гэрээний 4.3 дэх заалтад заасан хязгаарууд зөрчигдэж болно. Энэ тохиолдолд ХОМК нь ХОС-ийн ТУЗ-тай харилцан тохиролцож, энэхүү гэрээний 4.3 дахь заалтад заасан ХОС-ийн хөрөнгийн хязгаарлалтыг хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

ТАВ. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ХАДГАЛАЛТ

- 5.1. ХОС-ийн эрх барих дээд байгууллага нь ХОС-ийн нэгж эрхийг эзэмшигчдийн хурал байна.
- 5.2. ХОС-ийн гишүүдийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуульд нийцүүлэн баталсан ХОС-ийн дүрмээр тодорхойлно.
- 5.3. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ХОС-ийн эрх барих байгууллага байна.
- 5.4. ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг Гэрээний үндсэн дээр ХОМК өөрөө эсхүл уг ХОМК-аас томилсон эрх бүхий Сангийн менежер хэрэгжүүлнэ.



- 5.5. ХОМК нь ХОС-ийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан, тухайн ХОС-ийн нэр дээр нээсэн кастодианы тусгаарласан дансанд байршуулна.
- 5.6. ХОС-ийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага сантай байгуулсан Хөрөнгө хадгалалтын гэрээний дагуу явуулна.

ЗУРГАА. ИТГЭМЖЛЭЛИЙН ХӨРӨНГӨ БОЛОН ҮНЭТ ЦААС

- 6.1 Гэрээний үндсэн дээр итгэмжлэгдэх итгэмжлэлийн хөрөнгө болон үнэт цаас нь дараах байдалтай байна. Үүнд:
 - 6.1.1 Хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр зөвшөөрөгдсөн дараах үнэт цаас;
 - (i) Засгийн газрын өрийн хэрэгсэл;
 - (ii) Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
 - (iii) Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
 - (iv) Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
 - (v) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.
 - 6.1.2 Мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө.
 - 6.1.3 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг холбогдох хууль журамд тусгагдсан бусад хэрэгслүүд.
- 6.2 Гэрээнд оролцогч Талууд, тэдгээрийн аль нэг нь Гэрээтэй холбогдуулан аливаа гуравдагч этгээдийн өмнө эрх, үүрэг хүлээхгүй.

ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, УРАМШУУЛАЛ

- 7.1 ХОС нь ХОМК болон кастодианы үйлчилгээний зардлыг өөрийн хөрөнгөөс төлөх бөгөөд уг зардлын жилийн нийлбэр дүн нь ХОС-ийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн турван хувиас хэтрэхгүй байна.
- 7.2 ХОС-ийн ХОМК-д төлөх үйлчилгээний хөлс нь ХОС-ийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 2.5 хувьтай тэнцүү байна.
- 7.3 ХОМК нь ХОС-ийн активын үлдэгдэл болон менежментийн зардлын хэмжээг өдөр бүр тооцож гаргах бөгөөд сар бүр ХОС-оос нэхэмжлэн авна.
- 7.4 ХОМК нь өмнөх сарын төлбөрийг дараа сарын 10-ны өдрийн дотор ХОС-аас нэхэмжлэх ба ХОС-ийн данснаас суутган авна.
- 7.5 Хэрэв ХОС-ийн гүйцэтгэл нь Нэгж эрхийн танилцуулгад тусгасан “зорилтот хэмжээнээс” давсан тохиолдолд ХОМК-д гүйцэтгэлийн урамшуулал олгох ба энэ нь “зорилтот хэмжээнээс” давсан нийт ашгийн 20 хувь байна. Урамшууллыг ХОС-ийн аудитын тайлан гарсны дараа тооцож, жилд нэг удаа олгоно.
- 7.6 ХОС-ийн санаачилгаар Гэрээг цүцлах тохиолдолд ХОС нь Гэрээ байгуулнаас хойш үйлчилгээ үзүүлсэн өдрийг хүртэлх үйлчилгээний хөлсийг ХОМК-д төлнө.



2020 -08- 24

НАЙМ. ХОС-ИЙН ЗАРДАЛ

8.1 ХОС нь доорх зардлыг хариуцна:

- 8.1.1 ХОС-ийг үүсгэн байгуулах зардал;
- 8.1.2 ХОС-ийн хөрөнгө оруулалт татахтай холбоотой зардал;
- 8.1.3 Хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдан авах эсхүл за��хтай холбогдон гарах брокерийн хөлс болон бусад зардлууд;
- 8.1.4 ХОС-ийн татварын зардал;
- 8.1.5 ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК-ийн үйлчилгээний хөлс;
- 8.1.6 ХОС-д үйлчилгээг үзүүлж буй Кастодианы үйлчилгээний хөлс;
- 8.1.7 ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулах зардал;
- 8.1.8 ХОС-ийн маркетингийн зардал;
- 8.1.9 ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг тараах, хагас жил болон жилийн эцсийн тайлан хүргүүлэх болон бусад мэдээлэл бэлтгэх, түгээх зэрэгтэй холбогдон гарах зардлууд;
- 8.1.10 ХОС-ийн хүүний зардал;
- 8.1.11 ХОС-ийн аудит болон хууль эрх зүйн үйлчилгээний зардлууд;
- 8.1.12 Бусад ХОС-ийн үйл ажиллагаанд шууд холбогдон гарах зардлууд;
- 8.1.13 ХОС-ийн ТУЗ-ийн цалин, урамшуулал;
- 8.1.14 ХОС-ийн татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлууд;
- 8.1.15 ХОС-ийн орлогоос гишүүдэд орлого хуваарилах зардлууд.

8.2 ХОМК-ийн ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах зардалд доорх зардал хамаарна:

- 8.2.1 Цалин, урамшуулал зэрэг гүйцэтгэх удирдлагын хүний нөөцтэй холбоотой зардал;
- 8.2.2 Түрээс, утас зэрэг оффисын зардал;
- 8.2.3 Хөрөнгө оруулалт хийх, бусадтай гэрээ хэлцэл хийх, зар сурталчилгааны үйл ажиллагаа зэрэг ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах. Энэ тохиолдолд зохион байгуулалтаас бусад хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой брокерийн хөлс, зар сурталчилгааны хэвлэх, сурталчлах зэрэгтэй холбоотой хэрэгжүүлэх зардлууд хамаарахгүй болно.
- 8.2.4 Хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа шинжилгээ хийх
- 8.2.5 ХОС-ийн засаглалын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой зардлууд хамаарах боловч хэрэгжүүлэхтэй холбоотой зардлууд хамаарахгүй болно:
 - 8.2.5.1 ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл тайлан бэлтгэхэд ТУЗ-д туслах;
 - 8.2.5.2 Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл тайлан бэлтгэхэд ТУЗ-д туслах.



8.2.6 Хөрөнгө хадгалалт, тайлан мэдээ

8.2.6.1 ХОС-ийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаж, тухайн ХОС-ийн нэр дээр нээсэн тусдаа дансанд байршуулж, эрх бүхий Кастодианд хадгалуулах үйл ажиллагааг зохион байгуулах

8.2.6.2 Гэрээний 3.4 дэх заалтад тусгасан тайлангуудыг заасан давтамжийн дагуу гаргах.

8.2.6.3 ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, хуульд заасан хугацаанд Татвар, Сангийн яам, СЗХ-нд холбогдох тайланг гаргаж хүргүүлэх

8.2.7 ХОС-ийн үйл ажиллагаа дуусгавар болсон өдрөөс эхлэн ХОМК нь ХОС-ийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах.

8.3 Энэхүү гэрээнд тусгагдаагүй зардлыг ХОС-ийн ТҮЗ-өөс баталсны үндсэн дээр ХОС-ийн хөрөнгөнөөс гаргуулж болно.

ЕС. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 9.1. ХОМК-д дараах үйл ажиллаа эрхлэх, гүйцэтгэхийг хориглоно. Үүнд:
- 9.1.1. Хөрөнгө оруулалтын бодлогод хамааралгүй, эсхүл илүү хэмжээгээр ХОС-ийн хөрөнгийг зарцуулах;
 - 9.1.2. Энэхүү журамд тусгасан активын шаардлага, хязгаарыг хэлцэл хийх;
 - 9.1.3. ХОС-ийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй шилжүүлэх;
 - 9.1.4. ХОС-д бүрэн шилжигдээгүй хөрөнгийг шилжүүлэх үүрэг хүлээсэн хэлцэл хийх;
 - 9.1.5. ХОС-ийн хөрөнгийг барьцаалах, баталгаа болгох;
 - 9.1.6. ХОС-ийн хөрөнгөөс бусдад зээл олгох;
 - 9.1.7. ХОС-ийн хөрөнгийг өөрийн болон гуравдах этгээдийн өр төлбөрийг төлөх барьцаа, баталгаа болгон ашиглах;
 - 9.1.8. Нэг сангийн хөрөнгөөр нөгөө санд хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг санд шилжүүлэх, өөрийн өмчлөлд шилжүүлэн авах.

АРВАН. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 10.1. ХОС нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 10.1.1. Гэрээний хэрэгжилт, үр дүнг тухай бүр шалгах, санал чиглэл өгөх,
 - 10.1.2. ХОС-ийн мэдээллийн нууцлалыг ХОС-ийн мэдээллийн журмын хүрээнд чанд хадгалахыг ХОМК-аас шаардах;
 - 10.1.3. Гэрээгээр тохиролцож тогтоосон хэмжээгээр Гэрээнд заасан хугацаанд үйлчилгээний хөлсийг төлөх;
 - 10.1.4. Гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай мэдээлэл зөвшөөрөл болон бусад баримт бичгийг ХОМК-ийн шаардлагын дагуу гаргаж өгөх;



- 10.1.5. Итгэмжлэн удирдах хөрөнгийн хадгалалтыг гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр түүгээр гүйцэтгүүлж болно.
- 10.2. ХОМК нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 10.2.1. Гэрээний үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүгийн мэдээлэл, бичиг баримтыг гарган өгөх, ажлын онцлогоос шалтгаалан тухайн цаг үе, нөхцөл байдалд шаардагдах бусад мэдээллийг гаргаж өгөхийг шаардах;
 - 10.2.2. Гэрээгээр тогтоосон хугацаанд Гэрээнд заасан төлбөр болон урамшууллыг төлөхийг шаардах;
 - 10.2.3. Гэрээнд заасан үйлчилгээний гүйцэтгэлийн явцын талаар мэдээллийг танилцуулах, ХОС-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр ХОС-ийн саналыг тусгах;
 - 10.2.4. ХОС-ийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх;
 - 10.2.5. Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын удирдлагыг хэрэгжүүлэх;
 - 10.2.6. ХОС-ийн хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журамд нийцүүлэн өөрийн хөрөнгийн бүртгэлээс тусад нь хөтлөх;
 - 10.2.7. Хөрөнгө оруулагчид шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх.
 - 10.2.8. Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.
- 10.3. ХОМК нь ХОС-тай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд дараагийн Менежментийн компаниитай гэрээ байгуулах хүртэл тухайн хөрөнгө оруулалтын менежментийн компани үүргээ хэрэгжүүлнэ.
- 10.4. ХОС-ийн нэгж эрхийг эзэмшигч нь энэ хуулиар тогтоосноос бусад тохиолдолд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа дуусахаас өмнө түүнийг дуусгавар болгохыг ХОМК-аас шаардахгүй болно.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

- 11.1. ХОС нь тухайн сангийн гишүүний болон тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн бусдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.
- 11.2. ХОМК болон түүнээс томилгдсон Сангийн менежер зүгээс санаатайгаар хүлээсэн үүргээ зөрчин гэмт хэргийн сэдэлтэйгээр ХОС-ийн хөрөнгөд хохирол учруулснаас бусад тохиолдолд ХОС-ийн хөрөнгө, нэгж эрх болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийн бууралт эсхүл үнэт цаас гаргагч компани дампуурсны улмаас учирсан алдагдлыг ХОМК болон түүнээс томилсон ХОС-ийн менежер хариуцахгүй.
- 11.3. Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол тухайн үүргийн зөрчлийг арилгах шаардлагыг хүргүүлнэ.



2020 -08- 24

АРВАН ХОЁР. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ

- 12.1. ХОС нь дараах тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг хугацаанаас нь өмнө цуцална. Үүнд:
 - 12.1.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
 - 12.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацааг хуульд заасан буюу Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дуусгавар болгоно.
 - 12.1.3. ХОС татан буулгах тохиолдолд татан буулгах ажиллагаа дуусгавар болсон.
- 12.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг цуцлах, дуусгавар болгох, уг гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх ажиллагааг хууль болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ.
- 12.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний нөхцөл, заалтыг дагаж мөрдөн, хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд, зохих ёсоор нь биелүүлж байгаа тохиолдолд Хөрөнгө оруулалтын сан нь гэрээг цуцлах болон өөр менежментийн компанийтай давхар гэрээ байгуулахгүй байхаар тохиролцов.

АРВАН ГУРАВ. САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАН

- 13.1. ХОМК нь хууль тогтоомжийг мөрдлөг болгон ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнэ.
- 13.2. Бүртгэлийг хөтлөхдөө өдөр бүрийн арилжааны эцэст тогтсон цагт сангийн цэвэр активын үнэлгээг өөрийн цахим хуудсаар мэдээлэх бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох журмыг дагуу уг мэдээллийг СЗХ-нд хүргэж ажиллана.
- 13.3. ХОС нь дансны үлдэгдлийн жагсаалтыг сараар бэлтгэн дараа сарын 10-ны өдрийн дотор СЗХ-нд хүргүүлнэ.
- 13.4. Аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайланг хөрөнгө оруулалтын сангийн хууль, холбогдох журмын дагуу нийтэд болон нэгж эрх эзэмшигчдэд толилуулна.
- 13.5. ХОМК нь ХОС-ийн нягтлан бодох бүртгэлийг эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ.



АРВАН ДӨРӨВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 14.1. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд гарсан маргааныг талууд ажлын 60 өдрийн дотор эвийн журмаар харилцан ашигтай байх, үнэнч шударга байх зарчмыг баримтлан шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв уг хугацаанд маргааныг шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харьяа шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

АРВАН ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 15.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт , үер, гол түймэр, далайн шуурга, хар салхи болон байгалийн бусад гэнэтийн аюулт үзэгдэл/ -ийн нөхцөл байдлын улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангаагүйтэй холбоотой хариуцлагаас чөлөөлөгднө.

АРВАН ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 16.1. Гэрээ нь Талуудын бүрэн эрхтэй удирдах этгээдүүд холбогдох зөвшөөрөл, шийдвэрийг гаргаж Талуудыг төлөөлөх эрхтэй төлөөлөгч нар гарын үсэг зурж, тэмдэг (тамга) дарснаар хүчин төгөлдөр болно.
- 16.2. Гэрээг 3 /гурав/ эх хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
- 16.3. Гэрээний аль нэг нөхцөл нь хүчингүйд тооцогдсон, эсхүл хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ нь бусад заалтын хүчин төгөлдөр байдлыг хөндөхгүй.
- 16.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, Гэрээнд заасан бол Үйлчлүүлэгчийн Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас баталж, Талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно.
- 16.5. Гэрээнд орсон өөрчлөлтийг ажлын 3 (гурав) өдрийн дотор Хороо болон Нэгж эрх эзэмшигчдэд мэдээлнэ.
- 16.6. Гэрээний хавсралт, нэмэлт өөрчлөлтүүд нь Гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС

“Ард Менежмент УЦК” ХХК



он... сар... одер
БҮРТГЭВ
№ 01



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

MONGOLIAN STOCK EXCHANGE

2020 -08- 24



МЕНЕЖМЕНТ
КОМПАНИИ



/гарын үсэг/

ТУЗ-ийн дарга: Ч.Ганхуяг

Утас: (976) 88117392

Хаяг: Монгол Улс, Сүхбаатар дүүрэг,
Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард
Санхүүгийн Нэгдэлийн байр

Per №: 6457983



/гарын үсэг/

Гүйцэтгэх захирал: Ч.Хандаа

Утас: (976) 88114679

Хаяг: Монгол Улс, Сүхбаатар дүүрэг,
Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард
Санхүүгийн Нэгдэлийн байр

Per №: 5510759



7.5. “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ, КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ, КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2020 оны 06 сарын 09

Дугаар: ГК-2020/12

Улаанбаатар хот

Энэхүү Гэрээг (цаашид “Гэрээ” гэх) нэг талаас “Голомт банк” ХХК (цаашид “Кастодиан” гэх), нөгөө талаас “Үндэсний хувьчлал хаалттай хамтын ХОС” ХХК-г төлөөлж “Ард менежмент ҮЦК” ХХК (цаашид “Харилцагч” гэх), (хамтад нь “Талууд” гэх) нь Монгол улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журмын дагуу харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гэрээний зорилго нь Талуудын хооронд үүсэх сангийн хөрөнгийг хадгалах, арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэх, гишүүдийн нэгж эрхийн бүртгэлийг хийх, нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоолох болон кастодианы үйлчилгээтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Талууд Гэрээний үүргээ хэрэгжүүлэх явцад бие биенийхээ хууль ёсны эрх, ашгийг хүндэтгэж, хамтран ажиллах зарчмыг баримтална.
- 1.3. Талуудын мэдээлэл:

	Кастодиан	Хөрөнгө оруулалтын сан
Нэр:	“Голомт банк” ХХК	“Ард менежмент ҮЦК” ХХК
Хаяг:	Улаанбаатар хот, Монгол улс, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, Парк Плэйс оффис, 11 давхар, Кастодиан банкны хэлтэс	УБ хот, СБД, 8-р хороо, Номын хишиг байр, 2-р давхарт
Регистрийн дугаар:	2075377	5510759
Утас/Факс:	+976-70111646 /1401/	88114679
И-мэйл:	custody@golomtbank.com	handaa.ch@ardmanagement.mn, info@ardmanagement.mn

Хоёр. Нэр томьёоны тайлбар

- 2.1. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:



- 2.1.1. “**Кастодиан**” гэж “Голомт банк” ХХК, түүнийг төлөөлөн кастодианы үйл ажиллагааг эрхлэх Кастодиан банкны нэгжийг;
- 2.1.2. “**Харилцагч**” гэж энэхүү Гэрээний үндсэн дээр Кастодианд Хөрөнгөө хадгалуулж, Кастодианы үйлчилгээ авч буй Хөрөнгө Оруулалтын Санг;
- 2.1.3. “**ХОМК**” гэж Харилцагчтай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд буюу Ард Менежмент УЦК ХХК-г;
- 2.1.4. “**Үйлчилгээний ерөнхий нохцол**” гэж энэхүү Гэрээгээр урьдчилан тохиролцсон үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцлийг;
- 2.1.5. “**Үйлчилгээний нэмэлт нохцол**” гэж Гэрээ байгуулснаас хойш Талуудын харилцан тохиролцож, хамтран баталгаажуулсан нэмэлт үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөлийг;
- 2.1.6. “**Данс**” гэж Сангийн нэр дээр нээсэн кастодианы дансыг;
- 2.1.7. “**Хөрөнгө**” гэж Сангийн өмчлөлийн үнэт цаас, бэлэн мөнгө, хуулиар хориглоогүй бусад санхүүгийн болон хөрөнгө оруулалтын хэрэгслийг;
- 2.1.8. “**Үнэт цаас**” гэж Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасан дараах санхүүгийн хэрэгслийг;
 - 2.1.8.1. Хувьцаат компанийн хувьцаа /цаашид “хувьцаа” гэх/
 - 2.1.8.2. Компанийн өрийн хэрэгсэл
 - 2.1.8.3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл
 - 2.1.8.4. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх
 - 2.1.8.5. Хадгаламжийн бичиг
 - 2.1.8.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
 - 2.1.8.7. Үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/
 - 2.1.8.8. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан санхүүгийн үүсмэл хэрэгслүүд
 - 2.1.8.9. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тодорхойлж өгсөн бусад санхүүгийн хэрэгслүүд.
- 2.1.9. “**Эрх бүхий албан тушаалтан**” гэж Харилцагчийн ТУЗ эсвэл гишүүдийн хурлын шийдвэрээр Данс болон Хөрөнгийг захиран зарцуулах, Харилцагчийг Кастодианы өмне бүрэн төлөөлөхөөр томилогдсон эрх бүхий этгээдийг;
- 2.1.10. “**Эрх бүхий байгууллага**” гэж Санхүүгийн Зохицуулах Хороо, Татварын Ерөнхий Газар, шүүх прокурор зэрэг төрийн зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагыг;
- 2.1.11. “**Хороо**” гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;
- 2.1.12. “**Хөрөнгийн бирж**” гэж үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- 2.1.13. “**Төвлөрсөн хадгаламжийн байгууллага**” гэж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийг;
- 2.1.14. “**Гишүүн**” гэж Харилцагчид хөрөнгө оруулж, нэгж эрхийг нь эзэмшиж буй иргэн хуулийн этгээдийг;
- 2.1.15. “**Нэгж эрх**” гэж Гишүүнээс Харилцагчид оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг.



Гурав. Кастодианы Харилцагчид үзүүлэх үйлчилгээ

- 3.1. Кастодиан нь сангийн хөрөнгийг хадгалах, арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэх, гишүүдийн нэгж эрхийн бүртгэлийг гүйцэтгэх, нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоолох болон кастодианы бусад нэмэлт үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Кастодиан нь хөрөнгө оруулалтын сангийн нэр дээр тусад нь Данс нээж түүний Хөрөнгийг хадгална.
 - 3.1.2. Хөрөнгө оруулалтын сан нь Данс нээлгэхийн тулд доорх баримт бичгүүдийг бүрдүүлж өгнө. Харилцагч Хуулбар материалыудыг нотариатаар батлуулсан байх бөгөөд шаардлагатай тохиолдолд Кастодиан эх хувьтай нь тулган шалгаж хүлээн авна. Үүнд:
 - 3.1.2.1. Байгууллагын данс нээх хүсэлт (Хавсралт 1);
 - 3.1.2.2. Кастодианы данс нээх хүсэлт (Хавсралт 2);
 - 3.1.2.3. Удирдлагын мэдээллийн анкет;
 - 3.1.2.4. Кастодианы данс нээлгэх тухай болон Голомт банкнаас үйлчилгээ авахыг хүсэж буй гүйцэтгэх удирдлагын албан бичиг;
 - 3.1.2.5. Эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаа;
 - 3.1.2.6. Эрх бүхий албан тушаалтан томилсон тухай ТУЗ эсвэл Гишүүдийн хурлын шийдвэр;
 - 3.1.2.7. Эрх бүхий албан тушаалтны цахим үнэмлэх (гадаадын иргэн бол гадаад паспорт ба оршин суух зөвшөөрөл);
 - 3.1.2.8. Эрх бүхий албан тушаалтны цээж зураг;
 - 3.1.2.9. Сангийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 3.1.2.10. СЗХ-ны санг бүртгэсэн тухай тогтоол;
 - 3.1.2.11. Сангийн дүрэм;
 - 3.1.2.12. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;
 - 3.1.2.13. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
 - 3.1.2.14. Бусад талуудтай байгуулсан үйлчилгээ авах гэрээ;
 - 3.1.2.15. ХОМК-н хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл;
 - 3.1.2.16. ХОМК-н улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 3.1.2.17. ХОМК-н тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;
 - 3.1.2.18. Хөрөнгө хадгалуулах, кастодианы үйлчилгээ авах хүсэлт;
 - 3.1.2.19. Харилцагчийн улирлын санхүүгийн тайлан (сүүлийн 1 жил хэрэв байгаа бол);
 - 3.1.2.20. Харилцагчийн жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан (сүүлийн 3 жил) хэрэв байгаа бол;
 - 3.1.2.21. Нэгж эрхийн танилцуулга, проспектус (хэрвээ байгаа бол);
 - 3.1.2.22. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.1-д заасан багц журмууд;
 - 3.1.2.23. Кастодианы шаардсан бусад баримт бичиг.
 - 3.1.3. Кастодиан нь хууль ёсны хүчин төгөлдөг баримт, бичгээр өмчлөх эрх баталгаажсан, эрх зүйн ямар нэгэн зөрчилгүй, гуравдагч этгээдэд шаардах эрх үүсээгүй, төлбөр тооцоо нь эцэслэн гүйцэтгэгдсэн Хөрөнгийг хүлээн авч хадгалах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй Хөрөнгийг хадгалахаас татгалзах эрхтэй.



- 3.1.4. Кастодиан нь сангийн Хөрөнгийг бусад харилцагчийн хөрөнгөөс тусгаарлаж, сангийн нэр дээр тусгайлан нээсэн кастодианы Дансанд хөрөнгө тус бүрээр бүртгэж, найдвартай хадгална. Үнэт цаас бүрийн ангилал, төрлийг тодорхой зааж, хадгалалтын нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангаж хадгална.
- 3.1.5. Кастодиан нь Харилцагчийн Хөрөнгийг төрлөөс нь хамааруулж доорх байдлаар бүртгэж хадгална. Үүнд:
- 3.1.5.1. Дотоодын бүртгэлтэй Үнэт цаас: Кастодиан нь өөрийн нээсэн Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд хадгалж, систем дээр бүртгэл хөтөлнө.
 - 3.1.5.2. Мөнгөн Хөрөнгө: Кастодиан нь Харилцагчийн нэр дээр нээсэн Голомт банкны дансанд хадгалж, систем дээр бүртгэл хөтөлнө. Өөр банкны хугацаатай хадгаламжинд байршуулж болох ба хөрөнгийн бүртгэлийг кастодиан дээр бүртгэнэ.
 - 3.1.5.3. Гадаадын Үнэт цаас: Кастодиан нь Харилцагчийн гаргаж өгсөн мэдээллийг үндэслэн Харилцагчийн нэр дээр бүртгэнэ. Гадаад улсын Төвлөрсөн хадгаламжийн байгууллага, кастодиан банкны хуулга, swift мессеж эсвэл үйлчилгээ авч буй гадаад улсын үнэт цаасны компанийн мэдээлэлд үндэслэж Харилцагчийн нэр дээр бүртгэнэ.
 - 3.1.5.4. Бусад төрлийн Хөрөнгө: Харилцагчийн өмчлөх эрх баталгаажсан, эрх зүйн ямар нэгэн зөрчилгүй, гуравдагч этгээдэд шаардах эрх үүсээгүй, төлбөр тооцоо нь эцслэн гүйцэтгэгдсэн бусад төрлийн Хөрөнгийг хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичгийг үндэслэн бүртгэж хадгална.
- 3.2. Кастодиан нь Харилцагчийн Хөрөнгө худалдах эсхүл худалдан авах үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцоог эцслэн гүйцэтгэнэ.
- 3.2.1. Кастодиан нь нээлттэй арилжаалагддаг Үнэт цаасны төлбөр тооцоог Хөрөнгийн биржийн баталгаажсан хэлцэлд үндэслэж тухайн үед мөрдөгдөж байгаа төлбөр тооцооны горимын дагуу гүйцэтгэнэ. Хөрөнгө оруулалтын сан арилжаа хийсэн өдрийн 16 цагаас өмнө холбогдох төлбөрийн даалгаврыг Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж Кастодиан руу цахим шуудангаар ирүүлэх үүрэгтэй. 7 хоног бүрийн ажлын эцсийн өдөр Кастодиан руу биетээр хүргүүлэх үүрэгтэй.
 - 3.2.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчийн сангийн нэгж эрхийн арилжаа хийсэн тохиолдолд баталгаажуулалтын файл (Contract note)-г үндэслэж төлбөр тооцоог гүйцэтгэн, харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр санд мэдээлэл хүргүүлнэ.
 - 3.2.3. Харилцагч нь нээлттэй арилжаалагддаг Үнэт цааснаас бусад төрлийн Хөрөнгө худалдах, худалдан авах тохиолдолд холбогдох гэрээ болон төлбөрийн даалгаврыг Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж Кастодианы данс нээх хүсэлтэд заасан цахим шуудангаар ажлын өдрийн 16 цагаас өмнө Кастодианд ирүүлнэ.
 - 3.2.4. Харилцагч нь мөнгөн Хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх тохиолдолд холбогдох гүйлгээний маягтыг Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж Кастодианы данс нээх хүсэлтэд заасан цахим шуудангаар ажлын өдрийн 16 цагаас өмнө Кастодианд ирүүлнэ.
 - 3.2.5. Кастодиан нь Харилцагчийн Хөрөнгө худалдан авах эсхүл худалдахтай холбоотой



брокер, зохицуулагч байгууллага болон арилжааны банкны шимтгэлийг холбогдох гэрээг үндэслэн Харилцагчийн Данснаас суутган төлүүлэх эрхтэй.

3.2.6. Харилцагч нь өөрийн Хөрөнгөтэй холбоотой аливаа төлбөр тооцоог Кастодианд мэдэгдээгүйн улмаас үүсэх бүртгэлийн алдааг Кастодиан хариуцахгүй болно.

3.3. Кастодиан нь Харилцагчийн Үнэт цаасны өмчлөх эрхийг тухайлсан байдлаар бүртгэнэ.
Үүнд:

3.3.1. Нээлттэй арилжаалагддаг үнэт цаасны хувьд Хөрөнгийн биржийн баталгаажсан хэлцэлд үндэслэж Харилцагчийн үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.3.2. Хөрөнгийн биржээс гадуур хийгдсэн хэлцлийн хувьд дор дурдсан баримтуудын бүрдлийг нягтлан шалгасны үндсэн дээр Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.3.2.1. Холбогдох гэрээний нотариатаар баталгаажуулсан эх хувь эсхүл нотариатын хуулбар;

3.3.2.2. Хэлцэлд оролцож буй нөгөө тал нь иргэн бол цахим үнэмлэхний хуулбар, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.3.2.3. Төлбөрийн даалгавар;

3.3.2.4. Гэрээнд заасан төлбөрийг төлсөн баримт;

3.3.2.5. Кастодианы шимтгэл төлсөн баримт;

3.3.2.6. Кастодианы шаардсан бусад.

3.4. Кастодиан нь Харилцагчийн эзэмшилд буй дотоодын бүртгэлтэй Үнэт цаасанд ногдох орлогыг хүлээн авч Харилцагчийн Дансанд бүртгэж хадгална.

3.4.1. Кастодиан нь Харилцагчийн эзэмшилд буй Үнэт цаасны орлоготой холбоотой аливаа мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор Харилцагчид мэдэгдэнэ.

3.4.2. Кастодиан нь тухайн орлогыг хүлээн авсан өдрөө багтаан Харилцагчид ногдох хэсгийг тооцоолж тулгалт хийсний үндсэн дээр Харилцагчийн Дансанд бүртгэж хадгална.

3.4.3. Тулгалт хийх явцад зөрүү гарсан тохиолдолд Кастодиан шалтгааныг тодруулж, зөрүүг арилгах арга хэмжээ авах ба Харилцагчид тайлбар хүргүүлнэ.

3.5. Кастодиан нь доор дурдсан тайлангуудыг заасан давтамжийн дагуу цахим шуудангаар Харилцагчид хүргүүлнэ. Харилцагчийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор Кастодиан нь Харилцагчид мэдээлэл хүргүүлэх бүртээ тулгалт хийж байна.

№	Тайлангийн нэр	Давтамж
1	Нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл /Unit Holder Statement by Fund/	Өдөр бүр
2	Нэгж эрхийн цэвэр үнэлгээний тайлан /Net Asset Value for Fund/	Өдөр бүр



3	Цэвэр хөрөнгийн үнэлгээний тайлан /Portfolio Report/	Өдөр бүр
4	Дансны дэлгэрэнгүй хуулга /Monthly Customer Statement/	Сар бүр
5	Хөрөнгө оруулалтын багцын тайлан /Client Portfolio Report/	Өдөр бүр
6	Арилжааны тайлан /Customer Trade Report/	Тухай бүр
7	Гүйлгээний тайлан /Transaction Report/	Тухай бүр
8	Компанийн үйл ажиллагааны мэдэгдэл /Corporate Notification Report/	Тухай бүр

3.6. Кастодиан нь нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийг хийсэн тохиолдолд доор дурдсан тайлангуудыг заасан давтамжийн дагуу цахим шуудангаар Гишүүдэд хүргүүлнэ.

№	Тайлангийн нэр	Давтамж
1	Дансны хуулга /Monthly Customer Statement/ - сар бүр	Сар бүр
2	Арилжааны тайлан /Customer Trade Report/	Тухай бүр

3.7. Кастодиан нь сангийн хүсэлтээр дотоодын бүртгэлтэй компанийн үйл ажиллагаанд төлөөлөн оролцно.

- 3.7.1. Кастодиан нь тухайн компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор цахим шуудангаар Харилцагчид мэдэгдэнэ.
- 3.7.2. Зайлшгүй хэрэгжүүлэх (mandatory) компанийн үйл ажиллагааг Кастодиан нь Харилцагчаас зөвшөөрөл авахгүйгээр хэрэгжүүлэх эрхтэй.
- 3.7.3. Сонголтоор хэрэгжүүлэх (voluntary) компанийн үйл ажиллагааны хувьд Харилцагч өөрийн саналыг заасан хугацаанаас 7 хоногийн өмнө Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж Кастодианы данс нээх хүсэлтэд заасан цахим шуудангаар ирүүлнэ.
- 3.7.4. Харилцагч хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлүүлэх хүсэлтээ хурал болохоос хамгийн багадаа 14 хоногийн өмнө Кастодианы данс нээх хүсэлтэд заасан цахим шуудангаар эсхүл албан бичгээр ирүүлнэ.
- 3.7.5. Харилцагч нь Кастодианаас ирүүлсэн саналын хуудсыг үнэн зөв бөглөж, хурал болохоос 7 хоногийн өмнө Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж Кастодианы данс нээх хүсэлтэд заасан цахим шуудангаар ирүүлнэ.
- 3.7.6. Кастодиан нь Харилцагчийг зөвхөн түүний өмчлөлд буй дотоодын бүртгэлтэй Үнэт цаасны номиналь эзэмшигчийн хувьд төлөөлнө.

3.8. Кастодиан нь сангийн Нэгж эрхийг жагсаалтаар бүртгэх үйлчилгээ үзүүлнэ.

- 3.8.1. УЦТХТ нь Кастодиантай шаардлагатай холболтыг хийсний үндсэн дээр нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийн мэдээллийг холбогдох эрх бүхий албан тушаалтны





- гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан Кастодианд хүргүүлэх үүрэгтэй.
- 3.8.2. Кастодиан Нэгж эрх хуваарилах даалгаврыг шалган хүлээн авч, баталгаажуулсны үндсэн дээр ажлын нэг өдрийн дотор Гишүүдийн нэгж эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 3.8.3. Кастодиан нь санг Гишүүн тус бүрийн нэгж эрхийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлт хөдөлгөөнийг харах боломж бүхий онлайн интерфэйсээр хангана.
- 3.8.4. Кастодиан нь нэгж эрхийг жагсаалтаар бүртгэж байгаатай холбоотой гишүүдээс үйлчилгээний шимтгэл хураамж авахгүй.
- 3.8.5. Кастодиан нь нэгж эрхийг жагсаалтаар бүртгэхдээ хөрөнгө оруулагч бүрт данс нээнэ.
- 3.8.6. Нэгж эрх эзэмшигч нь Данс нээлгэхийн тулд доорх баримт бичгүүдийг УЦК-д бүрдүүлж өгөх ба УЦК нь харилцагчаас бүрдүүлж авах материалын бүрдлийг бүрэн ханггуулж авах үүрэгтэй. Сан үүнд хяналт тавих үүрэгтэй ба харилцагчийн материалын бүрдэл дутуу тохиолдолд Кастодиан нэгж эрх эзэмшигчийн дансыг нээхгүй болно. Үүнд:
- 3.1.3.1. Харилцагчаар бүртгүүлэх хүсэлт (Хавсралт 1);
 - 3.1.3.2. Кастодианы данс нээх хүсэлт (Хавсралт 2);
 - 3.1.3.3. Цахим үнэмлэх эсвэл гадаад паспорт
 - 3.1.3.4. Цээж зураг;
 - 3.1.3.5. Кастодианы шаардсан бусад баримт бичиг.
- 3.8.7. УЦК нь нэгж эрх эзэмшигчийн бүрдүүлж өгсөн материалыудыг тухай бүрт нь скандэн и-мэйлээр Кастодианд хүргүүлэх шаардлагатай ба 5 дах өдөр бүр дээрх материалыудыг Кастодианд эх хувиар нь хүргүүлэх шаардлагатай.
- 3.9. Кастодиан нь сангийн Нэгж эрхийн цэвэр үнэлгээг ажлын өдөр бүрийн 19:00 цагт тооцоолж санд и-мэйлээр мэдээлнэ.
- 3.9.1. Хөрөнгийн төрлөөс хамаарч зах зээлийн үнэлгээг доорх байдлаар тооцоолно. Үүнд:
- 3.9.1.1. Дотоодын бүртгэлтэй Үнэт цаас: Нээлттэй арилжаалагддаг бол Хөрөнгийн биржийн хаалтын ханшийг, бусад тохиолдолд худалдаж авсан өртөг буюу дансны үнийг үндэслэнэ. Бондын хувьд нэрлэсэн үнийг үндэслэнэ.
 - 3.9.1.2. Мөнгөн хөрөнгө: Төгрөгөөр илэрхийлэгдэж буй мөнгөн хөрөнгийг бодит дүнгээр нь, валютаар болон Монгол банкны албан ханшаар хөрвүүлж тооцно.
- 3.9.2. Сан өөрийн болзошгүй зардлын дээд хэмжээг хадгалуулж буй хөрөнгөд ногдох хувиар илэрхийлэн тайлант хугацааны эхэнд Кастодианд урьдчилж мэдэгдэх үүрэгтэй.
- 3.9.3. Кастодиан нь тухайн болзошгүй зардлыг тайлант хугацаан дахь өдрүүдэд тэнцүү дүнгээр хуваарилж Нэгж эрхийн үнэлгээг тооцоолно.
- 3.9.4. Сан өөрийн Хөрөнгөтэй холбоотой гарсан аливаа үнэ цэнийн өөрчлөлт, нэмэлт орлого, зардлыг Кастодианд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 3.9.5. Кастодиан нь зөвхөн сангийн хүлээн зөвшөөрсөн үйлчилгээг үзүүлж шимтгэл авах ба зарим үйлчилгээг сан авахгүй байж болно.
- 3.9.6. Сангийн хүсэлтээр хуулиар хориглоогүй бусад нэмэлт үйлчилгээг үзүүлж болно. Талуудын харилцан тохиролцож гарын үсэг, тамга тэдгээр баталгаажуулсан



Үйлчилгээний нэмэлт нөхцөл нь энэхүү гэрээний дагуу баталгаажиж, Гэрээний салшгүй хэсэг болно.

Дөрөв. Татвар

- 4.1. Сан нь өөрийн татвар төлөгчийн албан ёсны бүртгэлийг тодорхойлох баримт бичгийг Кастодианд хүргүүлэх үүрэгтэй.
- 4.2. Эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд Сангийн орлогод ногдох татварыг санд мэдэгдэж сангийн зөвшөөрлөөр Кастодиан суутган авч шилжүүлэх эрхтэй. Сангийн зүгээс холбогдох зөвшөөрлийг Банканд гаргаж өгөөгүйгээс шалтгаалан татварын өр төлбөрийн асуудлыг Сан хариуцна.
- 4.3. Дансан дахь Хөрөнгө нь татварын өр төлбөрийг төлж хүрэлцэхгүй тохиолдолд үлдэгдлийг Харилцагч өөрөө хариуцна.

Тав. Төлбөрийн нөхцөл

- 5.1. Сан нь Үйлчилгээний ерөнхий нөхцөл болон нэмэлт нөхцөлийн дагуу холбогдох шимтгэлийг Кастодианд төлнө.
- 5.2. Кастодиан нь өмнөх сарын төлбөрийн нэхэмжлэхийг дараа сарын эхний ажлын өдөрт багтаан Санд хүргүүлэх ба тухайн сарын 15-ны дотор Харилцагчийн Данснаас суутгаж авна.
- 5.3. Харилцагч сар бүрийн 15-ны өдрөөс өмнө Дансандаа төлбөрөө бүрэн байршуулаагүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцно.
- 5.4. Гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхэд бий болсон аливаа төлбөрийг Сан бүрэн төлж дуустал Кастодиан нь Сангийн хадгалуулж буй Хөрөнгийг төлбөрийн үлдэгдэлд тохирох хэмжээгээр битүүмжилж барьцаалах эрхтэй.

Зургаа. Гадаад валютын хөрвүүлэг хийх

- 6.1. Харилцагч нь өөрийн мөнгөн хөрөнгө байршуулах төгрөгийн болон валютын данстай байж болно. Дансын суурь валютыг тодорхойлж Кастодианд мэдэгдэх үүрэгтэй.
- 6.2. Тухайн дансны суурь валютаас өөр валютаар орж ирэх орлогыг тухайн өдрийн Голомт банкны авах ханшаар, тооцож хөрвүүлэг хийнэ.
- 6.3. Уг Дансны суурь валютаас өөр валютаар зарлага гаргах тохиолдолд тухайн өдрийн Голомт банкны зарах ханшаар тооцож хөрвүүлэг хийнэ.
- 6.4. Их хэмжээний гадаад валютын хөрвүүлэг хийхэд валютын ханшин дээр тохиролцож болно.
- 6.5. Харилцагч хүсэлт гаргасан тохиолдолд Кастодиан нь ханшийн эрсдлээс хамгаалах бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож болно.

Долоо. Үүрэг, хариуцлага

- 7.1. Кастодиан нь Гишүүдийн ашиг сонирхлын төлөө ажиллах нийтлэг үүрэгтэй байна.
- 7.2. Кастодиан нь Сангийн цэвэр активын өртөг, хэмжээ болон нэгж эрхийн тооцооны өртөг, олгосон болон буцаан худалдан авсан нэгж эрх тоог зөв тодорхойлсон эсэхэд хяналт



тавина.

- 7.3. Кастодиан нь Гишүүдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Харилцагчийн дүрэм, журам, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах ба зөрчил илрвэл Эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. Кастодиан нь Эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргүүлэхээс өмнө Харилцагчид мэдэгдэнэ.
- 7.4. Гэрээний 7.3-т заасан үүргийг биелүүлэхийн тулд Кастодиан нь Сангаас холбогдох хууль, журамд заасан мэдээлэл, баримт бичгийг тухай бүр шаардаж авах эрхтэй.
- 7.5. Сан болон ХОМК-ийн Кастодианд ирүүлсэн аливаа хүсэлт, даалгавар, зааварчилгаа нь холбогдох хууль, журам, дүрэм, гэрээний заалтыг зөрчихөөр байвал Кастодиан биелүүлэхээс татгалзах эрхтэй.
- 7.6. Гэрээнд заасан үйлчилгээнүүдийг үзүүлэхэд Харилцагчийн гаргаж өгөх мэдээлэл чухал ач холбогдолтой бөгөөд алдаатай, буруу мэдээлэл гаргаж өгснөөс үүдэн гарах сөрөг үр дагавар, хохирлыг Кастодиан хариуцахгүй.
- 7.7. Харилцагчийн Хөрөнгөтэй холбоотой үүсч болзошгүй зах зээлийн болон валютын ханшийн эрсдэлийг Кастодиан хариуцахгүй.
- 7.8. ХОМК болон Кастодиан нь Гэрээг байгуулахдаа хэн нэгнийг төлөөлж оролцсон нь Гэрээнд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.9. Кастодиан нь сан болон сангийн нэгж эрх эзэмшигчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.
- 7.10. Кастодиан нь санд үзүүлэх үйлчилгээ болон системийг байнга сайжруулж, үйлчилгээтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг цаг тухай бүрт нь шийдэж, боломжит системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийнэ.
- 7.11. Харилцагчийн хүсэлтээр уг гэрээг цуцлах хүртэл Кастодиан нь гэрээнд заасан үүргээ тасралтгүй хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд Харилцагч нь үйлчилгээ авсан өдрийг хүртэлх хугацааны хөлсийг Кастодианд төлнө.

Найм. Нөхөн төлбөр

- 8.1. Сан нь энэхүү Гэрээний хүрээнд Кастодианд учирсан аливаа алдагдал, хохирол, зардал (хуулийн үйлчилгээний төлбөр зэрэг), түүнчлэн гуравдагч этгээдийн зүгээс гаргасан нэхэмжлэл, шаардлагын дагуу үүсэх аливаа өр төлбөрийг хариуцах ба Кастодианд нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.2. Энэхүү нөхөн төлбөр олгох үүрэгт Кастодианы санамсаргүй алдаа, санаатай буруу үйл ажиллагаа, залилан мэхлэх шинжтэй үйлдлээс үүдэн гарсан аливаа алдагдлыг Кастодиан хариуцах ба Харилцагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.3. Кастодианы санамсаргүй алдаа, санаатай буруу үйл ажиллагаа, залилан мэхлэх шинжтэй үйлдлээс үүдэн гарсан аливаа алдагдлыг Кастодиан хариуцах ба Харилцагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.4. Кастодиан нь энэхүү Гэрээний хүрээнд Харилцагчид учирсан аливаа алдагдал, хохирол, зардал (хуулийн үйлчилгээний төлбөр зэрэг), түүнчлэн гуравдагч этгээдийн зүгээс гаргасан нэхэмжлэл, шаардлагын дагуу үүсэх аливаа өр төлбөрийг хариуцах ба Харилцагчид нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.5. Энэхүү нөхөн төлбөр олгох үүрэгт Харилцагчийн санамсаргүй алдаа, санаатай буруу үйл ажиллагаа, залилан мэхлэх шинжтэй үйлдлээс үүдэн гарсан аливаа өр төлбөрийг хариуцах ба Харилцагчид нөхөн төлөх үүрэгтэй.



- 8.6. Харилцагчийн санамсаргүй алдаа, санаатай буруу үйл ажиллагаа, залилан мэхлэх шинжтэй үйлдлээс үүдэн гарсан аливаа алдагдлыг Харилцагч хариуцах ба Кастодианд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.7. Кастодиан нь өөрийн буруутай үйлдлээс шалтгаалаагүй Харилцагчийн аливаа алдагдал, хохирлыг хариуцахгүй.
- 8.8. Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу Сангийн Данснаас үүргийн гүйцэтгэл хангуулах, төлбөр, хураамж, торгууль суутган авах тохиолдолд Кастодиан тухайн шийдвэрийг хуулийн дагуу биелүүлэх бөгөөд холбогдох ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Ес. Давагдашгүй хүчин зүйл

- 9.1. Хэрвээ Кастодиан нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон, саад учирсан, хугацаа хойшилсон бол үүнтэй холбоотой үүсэх хариуцлагаас давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл дуусгавар болох хүртэл хугацаагаар чөлөөлөгднө.
- 9.2. “Давагдашгүй хүчин зүйл” гэдэгт эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу хийгдэх нүүлгэн шилжүүлэлт, хязгаарлалт, онцгой байдал, сайн дурын бус шилжүүлэг, харилцаа холбооны системийн доголдол, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, гол түймэр, үер усны аюул, дэлбэрэлт, нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, бослого хөдөлгөөн, ажил хаялт, үймээн самуун, дайн байлдаан зэрэг Кастодианы хүсэл зоригтоос үл хамаарсан, удирдах боломжгүй хүчин зүйлийг ойлгоно.
- 9.3. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Кастодиан нь энэ гэрээнд заасан тодорхой төрлийн үйлчилгээг үзүүлж чадахгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Сан нь тухайн хугацааны туршид холбогдох үйлчилгээний хөлс төлөхгүй.

Арав. Эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх

- 10.1. Кастодиан нь Харилцагчийн Данстай холбоотой мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
- 10.2. Харилцагч нь Гэрээ, Үйлчилгээний ерөнхий болон нэмэлт нөхцөл, Кастодианы бусад мэдээллийг нууц мэдээлэл гэж үзэх бөгөөд Кастодианы бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.
- 10.3. Талуудын нууц хадгалах үүрэг нь Гэрээ дуусгавар болсон эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр үлдэнэ.
- 10.4. Эрх бүхий байгууллагаас хууль, журамд заасны дагуу шаардсан Харилцагчийн хөрөнгийн мэдээллийг Кастодиан гаргаж өгөх ба Харилцагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 10.5. Кастодиан нь Сангийн болон нэгж эрх эзэмшигчийн Хөрөнгийн талаар Хороо болон бусад Эрх бүхий байгууллагад хуульд заасан мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.
- 10.6. Кастодиан нь Хорооноос тогтоосон маягтын дагуу Сангийн тойм мэдээлэл, үйлчилгээ үзүүлж буй Хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дүнг сар бүр гаргаж дараа сарын 25-ны өдөр Хороонд хүргүүлнэ.
- 10.7. Кастодиан нь Харилцагчийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн Үнэт цаасны гүйлгээний мэдээллийг Хороонд хуанлийн сар дууссанаас хойш 2 (хоёр) долоо хоногийн дотор мэдээлж байх үүрэгтэй.





10.8. Кастодиан нь гэрээний 10.7-д заасны дагуу Хороонд мэдээлэл хүргүүлэхтэй холбогдуулан дор дурьдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 10.8.1. Мэдээлсэн мэдээллийн хамгаалалт болон нууцлалыг баталгаажуулах;
- 10.8.2. Гүйлгээний мэдээллийн алдааг засах болон тодорхойлох аргачлал болон механизмыг бий болгосон байх;
- 10.8.3. Гүйлгээний мэдээллийн эх үүсвэрийг баталгаажуулах аргачлал болон механизмыг бий болгосон байх;
- 10.8.4. Хороо болон Монголбанкнаас тавьсан мэдээлэх маягтын шаардлагын дагуу мэдээллийг гаргаж өгөх чадвартай байх.

10.9. Гэрээний 10.7-д заасан гүйлгээний мэдээллийн хамт үнэт цаастай холбоотой дараах мэдээлэл байна. Үүнд:

- 10.9.1. Кастодианы гүйцэтгэсэн гүйлгээг Хорооноос баталсан дүрмийн дагуу тодорхойлсон;
- 10.9.2. Өдөр болон цаг, хэзээ гүйлгээг гүйцэтгэсэн;
- 10.9.3. Кастодиан банкны мэдээлсэн гүйлгээний төрөл;
- 10.9.4. Кастодианы өөрийн ашигласан, эсхүл харилцагчийг төлөөлж тэдний данс ашигласны аль нь болохыг дурьдах;
- 10.9.5. Гүйлгээнд ашигласан санхүүгийн хэрэгслийн талаарх тодорхойлолт;
- 10.9.6. Гүйлгээнд ашигласан санхүүгийн хэрэгслийн төрөл;
- 10.9.7. Гүйлгээ хийгдсэн үнэт цаасны нэгж бүрийн зах зээлийн үнэ (хураамж болон төлөгдсөн хүүг хасч тооцох ба өрийн бичгийн хувьд үнэ нь валют, эсхүл хувиар тодорхойлогдож болно);
- 10.9.8. Үнийн дүнг илэрхийлсэн мөнгөн тэмдэгт, өрийн бичгийн үнэ нь хувиар илэрхийлэгдсэн бол тодорхий хувь;
- 10.9.9. Хувьцааны тоо ширхэг; бондын нэрлэсэн үнэ;
- 10.9.10. Гүйлгээнд оролцогч талуудын тодорхойлолт;
- 10.9.11. Гүйлгээг гүйцэтгэсэн газрын тодорхойлолт;
- 10.9.12. Гүйлгээг цуцласан талаар мэдээлэл.

Арван нэг. Харилцагчийн хөрөнгийг өөр кастодианд шилжүүлэх

11.1. Кастодиан нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, дампуурсан, өөрөө хүсэлт гаргасан, Гэрээний 12.4. заалтын дагуу гэрээ дуусгавар болсон тохиолдлуудад Харилцагчийн Хөрөнгийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх өөр этгээдэд шилжүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- 11.1.1. Шилжүүлж буй Хөрөнгийн жагсаалт;
- 11.1.2. Шилжүүлж буй баримт бичгийн жагсаалт;
- 11.1.3. Харилцагчийн Дансан дахь Хөрөнгийн жагсаалт;
- 11.1.4. Харилцагчтай байгуулсан гэрээ;
- 11.1.5. Хөрөнгө болон баримт бичгийг хүлээлцэн тухай акт;
- 11.1.6. Бусад шаардлагатай баримт бичиг.

11.2. Шилжүүлж буй Хөрөнгийн жагсаалтад Кастодианы бүртгэл, хадгалалтад байгаа Харилцагчийн нийт Хөрөнгө хамаарна. Шилжүүлж буй баримт бичгийн жагсаалтад дараах баримт бичиг хамаарна:





- 11.2.1. Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь болон Кастодианы дотоод бүртгэл дэх Харилцагчийн Дансны хуулгууд Хөрөнгө шилжүүлэх өдрийн байдлаар;
- 11.2.2. Кастодиан нь Төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон Харилцагчтай Хөрөнгө шилжүүлэх өдөр тулгалт хийсэн тухай акт, тулгалт хийхэд ашигласан баримт бичгүүд;
- 11.2.3. Нэгж эрх эзэмшигчдийн данс нээх хүсэлт, иргэний үнэмлэхний хуулбар, кастодиантай байгуулсан гэрээ зэрэг баримт бичгүүд.

- 11.3. Харилцагчийн Хөрөнгийг өөр кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шилжүүлэхдээ Хөрөнгө болон баримт бичгийг хүлээлцсэн тухай акт үйлдэх ба дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 11.3.1. Хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн огноо;
 - 11.3.2. Харилцагч, түүнд шинээр үйлчлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулсан огноо;
 - 11.3.3. Хөрөнгийг нь хүлээлцэж буй Харилцагчийн талаарх мэдээлэл;
 - 11.3.4. Хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн өдрийн кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд дэх харилцагчийн дансан дахь бэлэн мөнгө, Үнэт цасны үлдэгдэл;
 - 11.3.5. Шинээр кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээдэд шилжүүлэх бичиг баримтын жагсаалт;
 - 11.3.6. Талуудын холбогдох мэдээлэл, гарын үсэг;
 - 11.3.7. Бусад шаардлагатай мэдээлэл.

- 11.4. Кастодиан болон шинээр кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээдийн тэмдэг, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажсан харилцагчийн хөрөнгийг шилжүүлэх тухай актыг 4 хувь үйлдэх ба Харилцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээд, Кастодиан болон шинээр кастодианы үйлчилгээ үзүүлэх этгээд, Төвлөрсөн хадгаламжийн байгууллага тус бүрд нэг нэг хувийг олгоно.

Арван хоёр. Бусад нөхцөл

- 12.1. Гэрээ нь Талуудыг төлөөлөх бүрэн эрхтэй этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 12.2. Энэхүү гэрээ нь Сангийн дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах 10 хүртэлх жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.3. 2 жил тутамд Сан болон Кастодиан нь гэрээний нөхцлүүдтэй холбогдуулан талуудаас гарсан саналыг хэлэлциж гэрээнд өөрчлөлт оруулна.
- 12.4. Дараах тохиолдолд энэхүү гэрээ хугацаанаасаа өмнө дуусгавар болно. Үүнд:
 - 12.3.1. Харилцагчийг татан буулгах тохиолдолд татан буулгах ажиллагаа дуусгавар болсноор;
 - 12.3.2. Кастодианы тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон эрх бүхий байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсноор;
 - 12.3.3. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаар;
 - 12.3.4. ХОМК-ийн шийдвэрээр;





- 12.3.5. Гэрээний 3.8.1.-д заасан 2 этгээд шаардлагатай холболтоо хийх тохиролцоонд хүрэгүй,
- 12.5. Гэрээ нь Монгол Улсын хуулийн хүрээнд зохицуулагдана.
- 12.6. Гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг Талууд хамtran хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцоонд эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүнэ.
- 12.7. Гэрээнд зөвхөн Сан ба Кастодианы хооронд бичгэн хэлбэрээр байгуулсан нэмэлт гэрээ, Үйлчилгээний нэмэлт нехцэлд үндэслэж өөрчлөлт оруулна.
- 12.8. Гэрээний аливаа заалт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль бус, хүчин төгөлдөр бус болсон эсхүл заавал биелэгдэх хуулийн хүчин чадлаа алдсан тохиолдолд, үлдсэн заалтууд нь хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.
- 12.9. Талууд Гэрээгээр хүлээсн үүргээ ба хариуцлагыг негөө талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлхийг хориглоно.
- 12.10. Гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэх бөгөөд Гэрээний эх хувиуд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ТАЛУУД өөрсдийн бүрэн эрх бүхий албан тушаалтаар дамжуулан ут ГЭРЭЭГ байгуулж баталгаажуулав.

КАСТОДИАН-г төлөөлж

Овог: Галсан

Нэр: Ганболд

Албан тушаал: Ерөнхийлөгч

Гарын үсэг:

МОНГОЛ УЛС
Овог: Гонгоржав
Год: 1975.02.2015

ГОЛОМТ БААН
Нэр: Зоригт

Албан тушаал: Кастодиан банкны
хэлтсийн захирал

Гарын үсэг:

**АРД МЕНЕЖМЕНТ УЦК ХХК-г
төлөөлж**

Овог: Чулуунбаатар

Нэр: Хандав

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:





7.6. ARIMA загварын үнэлгээний аргачлал

Хувьцаа болон индексийн үнийг оновчтой таамаглахын тулд шинжээчид маш олон загварчлал хэрэглэж, туршдаг. Аливаа үзүүлэлтийг таамаглахад ашиглаж буй загваруудыг ерөнхийд нь бүтцийн хандлага (ARIMA, VAR, VAC), хагас бүтцийн хандлага (SVAR, FAVAR, SVEC) болон бүтцийн хандлага (SEM, DSGE) хэмээн ангилж болно. Эдгээр загваруудаас индекс, хувьцааны үнэ таамаглахад хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргачлал бол ARIMA (Autoregressive Integrated Moving Average) загварчлал юм.

ARIMA ЗАГВАР

Энэхүү загварыг анх 1971 онд Жорж И.П.Бокс болон Гвилым Жэнкинс нар анх гаргаж ирсэн бөгөөд өөрөөр Box-Jenkins аргачлал ч гэж нэрлэгддэг. Энэхүү загвар нь санхүүгийн таамаглал хийхэд тулхүү ашиглагддаг бөгөөд ялангуяа богино хугацааны таамаглалыг маш оновчтой хийдгээрээ алдартай. Аргачлалын хувьд ерөнхийдөө тухайн нэг хувьсагчийн ирээдүйн утгыг өнгөрсөн утгууд болон алдаануудаас нь үнэлж таамагладаг юм. ARIMA загвар нь AR(p), I(d), MA(q) гэх гурван хэсгээс бүрддэг.

Авторегрессив (AR)

Аливаа санхүүгийн хувьсагч нь өмнөх үеэсээ өндөр хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл хувьцааны ханшийн өсөж буй эсвэл үнаж буй инерц нь ирээдүйн ханшуудыг тодорхойлоход их нөлөөлдөг гэсэн үг. Үүнийг ашиглаж хувьсагчийг хугацааны хоцрогдоор тайлбарладаг процесийг AR загвар гэдэг. AR загварыг дараах байдлаар тодорхойлдог.

$$y_t = c + \sum_{i=1}^p \varphi_i y_{t-i} + e_t$$

Энд φ_i нь параметрууд, с нь тогтмол тоо, e_t нь санамсаргүй хувьсагч (white noise) юм.

Гулсах дундаж (MA)

Бидний таамаглахыг хүссэн хувьсагчинд маш олон зүйл нөлөөлж болох бөгөөд тэр бүгдийг AR процесст 'e' буюу санамсаргүй хувьсагч гэж үздэг. Үүнийг өөрөөр загварын алдаа буюу хамаарах хувьсагчийг тайлбарлаж чадах олон хүчин зүйлсийг оруулаагүйн алдаа гэж үздэг. Харин MA процессоор энэхүү өнгөрсөн алдаануудаар нь хувьсагчаа тайлбарлах гэж үздэг.

$$y_t = \mu + \sum_{i=1}^q \theta_i e_{t-i} + e_t$$

Энд θ_i нь параметрууд, μ нь тогтмол тоо, e_t нь санамсаргүй хувьсагч буюу цагаан шуугианы алдааны нөхцөл (white noise) юм.

ARIMA процесс

AR болон MA процессууд нэгдэн ARMA загварыг үүсгэдэг. Томъёолбол:




$$y_t = c + \sum_{i=1}^p \varphi_i y_{t-i} + \sum_{i=1}^q \theta_i e_{t-i} + e_t$$

Энэхүү загвар нь хугацааны цуваа стационар байх нөхцлийг шаарддаг ба үнэлгээнд ашиглах цуваа стационар байвал шүүд ARIMA загварт шинжилгээ хийдэг. Харин санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийн түүхэн өгөгдөл ихэвчлэн стационар бус буюу тогтвортой бус байдаг. Тийм учраас ARIMA загварыг ашигладаг. Өгөгдлүүд стационар бус байдаг учраас стационар болгохын тулд ARIMA загварт 'I' (integrated) процесс нэмж ARIMA загвар болгодог. Стационар бус хугацааны цувааг дараалсан ялгавар авах замаар стационар цуваанд шилжүүлдэг. Хугацаан цуваа y_t -гээс дараалсан ялгавар d үдаа авсаны дараа цуваа стационар цуваанд шилждэг бол y_t ARIMA процесс гэнэ. Энд r нь авторегрессийн нөхцлийн тоо, d нь ялгаврын эрэмбэ, q нь магадлалын загвар дахь таамаглалын алдааны хоцрогдлын тоо юм.

ARIMA загвараар ТОП 20 индексийн ханшийг таамагласан нь



ТОП 20 индексийн ирээдүйн 10 жилийн ханшийн таамаглалыг ARIMA загвараар хийсэн. Ингэхдээ 2004 оны 1-р сараас 2019 оны 12-р сар хүртэлх 16 жилийн сар бүрийн дундаж ханшийг ашиглаж, R програм дээр үнэлгээ хийв. Оруулсан түүхэн өгөгдлийн хувьд хангалттай урт хугацааны өгөгдөл тул үнэлгээний үр дүн бодитой гарахад сайнаар нөлөөлнө. Ерөнхий трэндийг харавал өсөлттэй байна.



ADF тест

Шинжилгээний эхний алхам бол хугацаан цуваан өгөгдөл стационар эсэхийг шалгах юм. Хугацаан цуваа стационар эсэхийг ADF (augmented Dickey-Fuller test) тестээр шалгадаг ба R програм дээр adf.test функцээр шалгадаг. ADF тест нь тухайн хугацаан цуваа 'Unit root'-тэй эсэхийг шалгадаг бөгөөд 'unit root'-тэй байвал энэ нь хугацаан цуваа стационар бус буюу таамаглах боломжгүй

Хугацаан цуваанаас бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж харвал ингэж дүрслэгдэж байна. Энд доороосоо санамсаргүй (random), улирлын (seasonal) болон трэндийг (trend) харуулж байна.





гэсэн үг. Энэхүү тестийн тэг таамаглал нь 'unit root'-тэй гэж үзээд тооцоолол хийсний дараа p-value нь 0.05-с бага байвал тэг таамаглалыг няцаах буюу стационар байна гэж үздэг.

Топ 20 индексийн түүхэн өгөгдөл дээр ADF тест хийхэд p-value нь 0.3719 гарсан нь тэг таамаглалыг няцааж чадаагүй буюу энэхүү хугацаан цуваа стационар бус байна. Тийм учраас дараагийн алхам буюу өгөгдлөө стационар болгоё. Ингэхдээ хамгийн энгийн алхам болох хугацаан цуваагаас нэг удаагийн ялгавар авч стационар эсэхийг шинжихэд p-value нь ойролцоогоор 0.01 гарсанаар тэг таамаглалыг няцааж стационар болсоныг батлав.

ACF / PACF

Анхны хугацаан цувааг нэгдүгээр эрэмбийн ялгавар аван стационар болгосоноор бид ARIMA загварын I(d) процесийн эрэмбэ буюу d-g 1 гэдгийг тодорхойлж чадсан. Харин одоо AR(p), MA(q) процессуудын эрэмбийг (p,q) тодорхойлох ёстой. Ингэхдээ ACF/PACF (autocorrelation function) графикууд байгуулж тодорхойлдог.



ACF график нь MA(q)-ийн эрэмбийг тодорхойлоход шаардлагатай. Хэрхэн эрэмбийг тодорхойлдогийг энгийнээр тайлбарлавал | lag 1, 2 дээр ACF огцом дээшлээд lag 2 дээр доошоо хасах болж байгаа учир q нь lag 1 буюу 1 болж байна. Өөрөөр хэлбэл lag 1-н аутокорреляцийг тооцсон байхад түүнээс хошиг lag нөлөө багатай юм.

Харин PACF буюу partial ACF нь AR(p)-ийн эрэмбийг тодорхойлоход ашиглагддаг. PACF графикаас харахад AR(0) эрэмбэ тохиромжтой байна.


ARIMA (0,1,1) загвар

Хугацаан цувааг стационар болгож, ARIMA (p,d,q) эрэмбүүдийг тодорхойлсноор бидний хамгийн тохиромжтой загвар бол ARIMA (0,1,1) гэдгийг гаргаж авлаа. Улмаар 'forecast' функцээр таамаглал хийв. Мөн R програмд тухайн хугацаан цуваан дээр шууд ARIMA үнэлгээ хийдэг auto.arima функц байдаг бөгөөд энэхүү функц нь 'unit root', 'AIC', 'MLE' шалгууруудаар



боловжит хамгийн сайн ARIMA загварыг тодорхойлдог. Энэхүү үнэлгээгээр мөн ARIMA (0,1,1) загварыг хамгийн тохиромжтой загвар гэж үзсэн.

Топ 20 индексийн 10 жилийн таамаглал, 2020-2029



түвшинд 2029 он гэхэд 72,243 болох буюу 2019 оны 12-р сарын дундаж ханшинаас 3.8 дахин өсөх боломжтой байна.

Энд arima(value, c(0,1,1), seasonal (0,1,1)) томьёоллоор үнэлэв. Seasonal (0,1,1) буюу улирлын нөлөөг оруулж тооцсон болно. Учир нь Топ 20 индексийн улирлын буюу бидний жишээн дээр сарын нөлөө байсан. Энэхүү таамаглалаар Топ 20 индекс нь цаашид тогтмол өсөх магадлалтай байгаа бөгөөд 95 хувийн итгэх магадлалын

7.7. "ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ҮҮСГЭН БАЙГУУЛАХ" ТУХАЙ 19/05 ТООТ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ARD МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд, Амарын гудамж-2,
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт
И-мэйл: info@ardholdings.com Утас: 7707 8080

019 он 17 сар 19/05

Дугаар 19/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хаалттай хамтын хоронго
оруулалтын сан үүсгэн байгуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг болон 2019 оны 7 сарын 17-ны өдрийн ТҮЗ-ийн хурлыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ Нь:

1. "Үндэсний хувьчлалын сан" (цаашид "Хамтын ХОС" гэх) оноосон нэргтэй тусгай зориулалтын компанийг хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр үүсгэн байгуулсугай.
2. "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС-гийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь 10 (арван) жил байхаар шийдвэрлэсүгэй.
3. "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000,000 (тавин сая) ширхэг нэгж эрхээс бүрдэх нийт 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсүгэй.
4. Үүсгэн байгуулагч "Ард Менежмент ҮЦК" ХХК-иас "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС-д 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийг оруулахаар шийдвэрлэсүгэй.
5. "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС-гийн эргэлтэд гаргасан нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) ширхэг нэгж эрхээс бүрдэх нийт 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийн нэгж эрхийг "Ард Менежмент ҮЦК" ХХК эзэмшихийг дурдсугай.
6. "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС-гийн Дүрмийг энэхүү шийдвэрийн нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. "Үндэсний хувьчлалын сан" Хамтын ХОС-гийн гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийг "Ард Менежмент ҮЦК" ХХК /Ч.Хандаа/-д олгож, сангийн менежерээр "Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хандааг томилсугай.
8. Хамтын ХОС нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар хаягт албан ёсоор байрлан үйл ажиллагаа явуулахаар тогтсугай.
9. Хамтын ХОС-г үүсгэн байгуулахтай холбоотой үйлдэгдэх үүсгэн байгуулах бичиг баримт, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, Хөрөнгө хадгалах гэрээ болон холбогдох бүхий л бичиг баримтад "Ард Менежмент ҮЦК" ХХК болон Хамтын хөрөнгө оруулалтын санг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг "Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Ч.Хандаа/-д олгосугай.



10. Шинээр хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулахад шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах болон Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлж (i) Санхүүгийн зохицуулах хороо; (ii) Оюуны эмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар; (iii) Татварын ерөнхий газар болон (iv) холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх бүрэн ерхийг “Ард Менежмент УЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Ч.Хандаа/-д даалгасугай.

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
 “АРД МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК-ИЙН

ТУЗ-ИЙН ДАРГА АТАР ХОТ



Ч.ГАНХУЯГ

7.8. "ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн саидын 2016 оны
A/204 дүгээр тушаалдаа

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000189174

2019.08.07
/Бүртгэсэн он, сар, өдөр /

9011801136
/Хувийн хэргийн дугаар /

6457983
/Регистрийн дугаар /

Үндэсний хувьчлалын сан хамтын ХОС
Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/Үүсээн байдгуулах баримт бичие /

Шийдвэр
/шийдвэрийн нэр /

01
/дугаар /

2019.07.08
/он, сар, өдөр /

6630
/код /

Хөрөнгө оруулалт
/Үндсэн эрхлэх ўл ажиллагааны чиалзл /

/код /
/Туслах эрхлэх ўл ажиллагааны чиалзл /

19.08.07~29.08.07
/хувацаа /

1
/шишүүдийн тоо /

250,000.0
/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар, Утас1:
77078080, Утас2: , Факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн өрөхийг газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар

/бүртгэсэн байгууллагын нэр /
5296722
ГСТБ115 1115261561

СМОЛДАЛЫН САН ХАМТЫН ХОС ХАК
ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН





Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгасэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Чулуунбаатар овогтой Хандаа-г Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2019.08.07	С.Мөнхсанчир

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл
Хуулийн бүртгэлийн төслийн эзэнтүүлэлтэй, ижилдэй болж болох ёстой.



* 0 0 0 1 8 9 1 7 4 *



7.9. "УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХОС-ИЙН ДҮРЭМ

"Ундэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС-
нээж эрх эзэмшигчдийн 2019 оны 7 сарын 17-ны одрийн хурлын
1905 тоот шийдвэрийн 1 дүгээр хадсрагд

"УНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХАМТЫН ХӨРӨНГО
ОРУУЛАЛТЫН САНГИЙН
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үзүүлэлт

1. "Ундэсний Хувьчлалын Сан" Хамтын хөрөнгө оруулалтын сан (цаашид "Сан" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, эдгээр хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "Хороо" гэх)-ны холбогдох журам болон энэхүү Дүрмийг үйл ажиллагаандaa удирдлага болгон ашгийн төлөө хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зориулалтын компани байна.

Хоёр. Сангийн оноосон иэр, хаяг

- 2.1 Сангийн оноосон иэр:
 - 2.1.1 Монголоор: "Ундэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС;
 - 2.1.2 Англиар: "National Privatization Fund" Closed end fund
- 2.2 Сангийн оршин байгаа газар, албан ёсны хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар;
Утас: 77078080;
- 2.3 Сан нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн иэр бүхий тэмдэг хэрэглэнэ.
- 2.4 Сан нь өөрийн "Ундэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС гэсэн иэрийг бүх үйл ажиллагаандaa ашиглана.
- 2.5 Сан нь үүсгэн байгуулах баримт бичиг болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Гурав. Сангийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хугацаа

- 3.1 Сан нь хамтын хөрөнгө оруулалтын сан (Хамтын ХОС)-гийн хэлбэртэй байна.
- 3.2 Сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр нэгж эрх гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан нэгж эрхийг

Хуудас 1 | 13





Эргүүлэн худалдаж авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан байна.

- 3.3 Сан нь зөвхөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой байна.
- 3.4 Сан нь үйл ажиллагаагаа 10 (арв) жилийн хугацаатай явуулна.
- 3.5 Сан нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллаж, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.
- 3.6 Сан нь Хорооноос тусгай зөвшөөрөл авч, Сангийн үйл ажиллагааг эхлүүлснээр зөвхөн хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зориулалтын компани байна.

Дөрөв. Сангийн хөрөнгө, санд хөрөнгө оруулах хэрэгсэл, активыг байршуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрийн эрдээлийн удирдлага

- 4.1 Сан нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000,000 (тавин сая) ширхэг зарласан нэгж эрхтэй байна.
- 4.2 Санд төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байна.
- 4.3 Сан нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) ширхэг нэгж эрхийг эргэлтэд гаргасан бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгө нь 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөг болно.
- 4.4 Сангийн 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) ширхэг эргэлтэд гаргасан нэгж эрхийг Ард Менежмент УЦКХ эзэмшинэ.
- 4.5 Сангийн нэгж эрх тус бүр нь сангийн гишүүдийн хуралд саналын нэг эрхтэй оролцох ба нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд тус бүрийн саналын эрх нь тэдгээрийн тус бүрийн өмчлөл, эзэмшил дэх нэгж эрхийн тоогоор тодорхойлгодно.
- 4.6 Сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл активын бүтэцдээ оруулахыг хориглоно.
- 4.7 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд:
 - 4.1. Засгийн газрын өрийн хэрэгсэл;
 - 4.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
 - 4.3. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
 - 4.4. Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагдаг компанийн өрийн хэрэгсэл;
 - 4.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.
- 4.8 Сан нь энэхүү Дүрэмд зааснаас өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.

Хуудас 2 | 13



- 4.9 Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигтэй байна. Уг бодлогын баримт бичигт Дүрмийн 4.7-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах зарчим, аргачлал, хязгаарлалт, тооцоолол болон эрсдэлийн удирдлагыг зэрэг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журамд тусгасан бусад асуудлыг тусгаж өгнө.

Тав. Сангийн нэгж эрх эзэмшигч

- 5.1. Сангийн нэгж эрхийг Сангаас шууд худалдан авсан эсхүл Сангийн гаргасан нэгж эрхийг хоёрдогч зах зээл дээрээс өөрийн хууль ёсны өмчлөлд шилжүүлэн авч нэгж эрх эзэмшигчийн бүртгэлд бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийг нэгж эрх эзэмшигч гэнэ.
- 5.2. Сан нь түүний нэгж эрхийг эзэмшигч хуулийн этгээдийн өмчлөл дэх сангийн нэгж эрхийн хувь, хэмжээнээс үл хамаарч тухайн нэгж эрхийг эзэмшигч хуулийн этгээдээс хараат бус байх бөгөөд Компанийн тухай хуульд заасан охин болон хараат компани, толгой компанийн хоорондын эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй.
- 5.3. Сангийн нэгж эрхийг эзэмшигч хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээсэн үүргийг зөвхөн тухайн хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгөөр хариуцна. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь сангийн өр төлбөр болон аливаа үүргийг өөрийн хөрөнгөөр хариуцахгүй.
- 5.4. Сан нь нэгж эрхийг эзэмшигч болон санд үйлчилгээ үзүүлж байгаа Хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид “Менежментийн компани” гэх), кастодианы бусдын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.
- 5.5. Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 5.5.1. Сангийн төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед өөрийн эзэмшиж буй нэгж эрхэд ондох ногдол ашиг авах;
- 5.5.2. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй нэгж эрхийн тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- 5.5.3. Бусад нэгж эрх эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа нэгж эрхээ чөлөөтэй захиран зарцуулах;
- 5.5.4. Санг татан буугдах үед энэхүү дүрмийн 17 дугаар зүйлд заасан дарааллын дагуу үлдсэн хөрөнгийг худалдсанаас олсон орлогос өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;
- 5.5.5. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй нэгж эрхээ энэхүү Дүрэмд заасан зохицуулалтын хүрээнд захиран зарцуулах (худалдаа, бэлэглэх, барьцаалах, өв залгамжуулах болон хуулиар зөвшөөрсөн бусад хэлбэр);
- 5.5.6. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь Сангаас нэмж гаргаж буй нэгж эрхээс өөрийн эзэмшиж буй хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд

Хуудас 3 | 13





худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

- 5.5.7. Сангийн нэгж эрхийг эзэмшигч нь хөрөнгө оруулалтын сангийн талаарх тохиорох мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- 5.5.8. Нэгж эрх эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа нэгж эрхийн тоог нэгж эрх эзэмшигчний бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх үүргээ хүлээн.
- 5.5.9. Энэхүү 5.5.8-т заасны дагуу бүртгүүлснээр нэгж эрх эзэмшигчийн эрх үүснэ.
- 5.5.10. Сангийн нэгж эрх эзэмшигч нь Сангийн үйл ажиллагаатай холбоотой бизнесийн болон үйл ажиллаацаны нууцад хамаарах мэдээллийг бусад дамжуулах, задруулах, дэлгэхийг хориглоно.
- 5.5.11. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон здгээр хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн Зохицуулах Хорооны журамд заасан бусад эрх, үүргээ.

Зургаа. Хөрөнгө оруулалтын менежментийн компани

- 6.1 Менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь Санг үүсгэн байгуулах, Санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр хөрөнгө удирдах үйлчилгээ үзүүлэх, түүний үйл ажиллагааг эрхлэх, төлөөлөх ажиллагаа байна.
- 6.2 Санг үүсгэн байгуулагч Менежментийн компанийн нэр, оршин байгаа газрын хаяг:

№	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	Регистрийн дугаар, Тусгай зөвшөөрлийн дугаар	Хаяг	Утас, Цахим хуудас
1.	“Ард Менежмент УЦК” ХХК	5510759 №: 380/09	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амараин гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар	77078080 ardmanagement.mn

- 6.3 Менежментийн компани нь Санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн Сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зерчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна.
- 6.4 Менежментийн компанийтай байгуулах “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” нь энэхүү Дүрмийн 3.4-д заасан хугацаатай адил хугацаанд хүчин төгөлдөр үйлчилэх бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг дуусгавар болгож болно.

Хуудас 4 | 13



- 6.5 Менежментийн компани нь энэхүү Дүрмийн 6.4-д заасны дагуу Сантай байгуулсан гэрээ дуусгавар болсон эсхүл цуцлагдсан тохиолдолд дараагийн Менежментийн компанийтай гэрээ байгуулах, уг гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл гэрээнд заасан үүргээ тасралтгүй хэрэгжүүлнэ.

Долоо. Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд

- 7.1. Сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага сантай байгуулсан “Хөрөнгө хадгалах гэрээ”-ний дагуу эрхэлнэ.
- 7.2. Санд Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг:

№	Кастодианы нэр	Регистрийн дугаар	Хаяг	Утас, Цахим хуудас
1.	Голомт Кастодиан ХХК	2075377	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Очир Төв, Голомт Кастодиан, 503 тоот	custody@golomtbank.com

- 7.3. Кастодиан нь Санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна.
- 7.4. Кастодиан нь энэхүү Дүрмийн 7.1-д заасны дагуу Сантай байгуулсан гэрээ дуусгавар болсон буюу цуцлагдсан тохиолдолд дараагийн Кастодиантай гэрээ байгуулах, уг гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл гэрээнд заасан үүргээ тасралтгүй хэрэгжүүлнэ.

Найм. Сангийн нэгж эрхийг арилжих

- 8.1. Сан нь нэгж эрхээ нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлж бегоод нэгж эрхээ анхдагч зах зээлд худалдаа арилжааг унэт цаасны Арилжаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртгүүлэх замаар зохион байгуулж болно.
- 8.2. Сангийн нэгж эрх нь хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжаалагдах бегоод нэгж эрхийн хоёрдогч зах зээл дэх арилжааны үнийг тогтооход Сан үүрэг хүлээхгүй.
- 8.3. Сан нь Арилжаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртэлтэй бол сангийн нэгж эрхийн арилжаа нь Арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмын хүрээнд арилжаалагдана.
- 8.4. Сан нь арилжаа эрхлэх эрх бүхий байгууллагад бүртгэлгүй бол нэгж эрхийг арилжаалах, бүртгэх журмыг дотооддоо баталж мөрднө.
- 8.5. Сан нь гүйлгээнд гаргасан нэгж эрхээ буцааж худалдаж авах үүрэг хүлээхгүй.
- 8.6. Сан нь нийтээс хөрөнгө оруулалт татах ажиллагааг сангийн нэгж эрхийн танилцуулгад үндэслэн хэрэгжүүлнэ.

Хуудас 5 | 13



Ес. Сангийн удирдлага

- 9.1. Сангийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байна.
- 9.2. Сангийн төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хөрөнгө оруулалтын сангийн эрх барих байгууллага байна.
- 9.3. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага эрхлэх бөгөөд уг бүрэн эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр Менежментийн компани өөрөө эсхүл уг Менежментийн компаниас томилсон эрх бүхий Сангийн менежер хэрэгжүүлнэ.

Арав. Нэгж эрх эзэмшигчдийн хурал

- 10.1. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэг адил хамаарна.
- 10.2. Дараах асуудлыг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 10.2.1. Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Сангийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 10.2.2. Санг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;
 - 10.2.3. Сангийн ерийг нэгж эрхээр солих, нэгж эрх нэмж гаргах, нэмж гаргах нэгж эрхийн тоог тогтоох;
 - 10.2.4. Сангийн нэгж эрхийг хуваах болон нэгтгэх;
 - 10.2.5. Санг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 10.2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдний сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 10.2.7. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй их хэмжээний хэлцлийг батлах;
 - 10.2.8. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан, ТУЗ-өөр шийдвэрлэж чадаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 10.2.9. Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлайгийн талаарх ТУЗ-ийн болон менежментийн компанийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 10.2.10. Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
 - 10.2.11. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ-аас оруулсан асуудлууд;
 - 10.2.12. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн Зохицуулах Хорооны журамд заасан бусад асуудлууд.
- 10.3. Нэгж эрх эзэмшигчдийн хурал нь эзлжит болон эзлжит бус байна.

Хуудас 6 | 13





- 10.4. Нэгж эрх эзэмшигчдийн эзлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дервөн сарын дотор зарлан хуралдуулна.
- 10.5. Сангийн нийт гаргасан нэгж эрхийн 50 хувиас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн гэж үзж тухайн хурал хүчин төгөлдөр болно. Хуралд оролцогсдын энгийн олонх асуудлыг баталснаар хэлэлцэж буй асуудал батлагдана.
- 10.6. Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, шийдвэр гаргах, ирц бүрдээгүйтэй холбоотой хойшлуулах болон дахин хуралдуулахтай холбоотой харилцаанд Компанийн тухай хуулийн холбогдо заалт болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн холбогдо заалт нэг адил ўйлчилийн.
- 10.7. Нэгж эрх эзэмшигчдийн хуралд цахимаар санал хураалт явуулж болох бөгөөд цахимаар санал хураах журмыг ТУЗ батална.
- 10.8. Дараах тохиолдолд Нэгж эрх эзэмшигчдийн эзлжит бус хурлыг заавал зарлан хуралдуулна:
 - 10.8.1. Сангийн цэвэр активын хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид сан ўйл ажиллагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь эсхүл түүнээс илүү хуви хэмжээгээр буурсан;
 - 10.8.2. Менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанийд хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн;
 - 10.8.3. Кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;
 - 10.8.4. Сангийн бусдын өминө хүлээсэн төлбөрийн үүрэг нь энэхүү дүрмийн 10.7.1-д заасан хэмжээнээс буурах нөхцөл байдал үүссэн;
 - 10.8.5. Компанийн тухай хуулийн эзлжит бус хурал хуралдуулахтай холбоотой бусад заалт.

Арван нэг. Төлөөлөн удирдах зөвлөл

- 11.1. ТУЗ-ийн бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл нэг адил хамаарна.
- 11.2. ТУЗ нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 11.2.1. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эзлжит болон эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 11.2.2. Гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - 11.2.3. Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 11.2.4. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 11.2.5. Аудитын байгууллагыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох;
 - 11.2.6. Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 11.2.7. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

Хуудас 7 | 13



- 11.2.8. Сангийн нэгтгэх, нийлуулэх замаар өөрчлөн байгуулах талаар сангийн нэгж эрх зэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 11.2.9. Сангийн дотоод хяналтын хорооны гишүүдийг томилох;
- 11.2.10. Энэхүү Дүрэмд заасан зарласан нэгж эрхийн тоонд багтаан нэгж эрх гаргах;
- 11.2.11. Энэхүү дүрэм болон сангийн нэгж эрх зэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.
- 11.2.12. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн Зохицуулах Хорооны журамд заасан бусад асуудлууд.
- 11.3. Сангийн ТУЗ нь 5 (таван) гишүүнтэй байх ба тэдгээрийн 1/3-аас багагүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан байна.
- 11.4. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 (хоёр) жил байх бөгөөд улируулан сонгож болно.
- 11.5. ТУЗ-ийн гишүүн нь удаан хугацаагаар (зургаан сараас дээш) үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдхөн хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нохөн сонгууль хүртэл ТУЗ түр томилно.
- 11.6. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
- 11.7. ТУЗ нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд ТУЗ энээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 11.8. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоох бөгөөд ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх удирдлагын санаачилгаар хуралдууна.
- 11.9. ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 11.10. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурна.
- 11.11. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 11.12. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

Арван хоёр. Гүйцэтгэх удирдлага

- 12.1. Гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Хуудас 8 | 13





- 12.2. Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг Менежментийн компани өөрөө эсхүл Менежментийн компанийас томилсон эрх бүхий менежер сангийн дүрэм болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.
- 12.3. Менежментийн компани нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Энэ гэрээнд Менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, үйлчилгээний зардал, төлбөр, гүйцэтгэлийн урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна. Энэхүү гэрээнд ТУЗ-ийг төлөөлж ТУЗ-ийн дарга гарын үсэг зурсан байна.
- 12.4. Менежментийн компани нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 12.4.1. Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу Сангийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах;
 - 12.4.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд тухайн хөрөнгө оруулалтын санг төлөөлөх бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулах;
 - 12.4.3. Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагаанд тухайн Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаагаа явуулах;
 - 12.4.4. Сангийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой хэлцэл хийх;
 - 12.4.5. Сангийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хадгалах;
 - 12.4.6. Хорооноос тогтоосон хугацаанд холбогдох журмын дагуу тайлан мэдээ гаргах, хүргүүлэх;
 - 12.4.7. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын Санхгийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан бусад.
- 12.5. Менежментийн компани нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалт хийх, хэлцэл хийх, гэрээ байгуулах, төлөөлөх зоргээр Сангийн үйл ажиллагааг удирдан явуулна.
- 12.6. Менежментийн компани нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээнээс давсан хөрөнгө оруулалт, хэлцэл хийх, гэрээ байгуулах тухай бүрдээ ТУЗ-өөс бичгээр зөвшөөрөл авна.
- 12.7. Сангийн едер тутмын үйл ажиллагааг Менежментийн компанийас томилсон Сангийн менежер удирдана. Сантай байгуулсан Менежментийн компанийн гэрээний эрх, үүрэг менежерт нэгэн адил хамаарна.
- 12.8. Менежер нь гэрээний үндсэн дээр нэгж эрх эзэмшигчийн бүртгэлийг үнэт цаасны төлбөр, тооцоо гүйцэтгэх эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж болно.

**Арван гурав. Сангийн орлого, зардал,
ногдол ашиг хуваарилах**

- 13.1. Сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 13.1.1. Хөрөнгө оруулалтын орлого;

Хуудас 9 | 13





13.1.2. Бусад орлого.

- 13.2. Хөрөнгө оруулалтын орлогод Сангийн худалдан авч эзэмшиж буй санхүүгийн хэрэгслийн ханшийн зөрүүний орлого, хүү, ногдол ашгийн орлого болон хууль, журамд заасан бусад орлого хамаарна.
- 13.3. Сангийн ногдол ашгийн хуваарилах талаар Менежментийн компанийтай харилцан тохиолцсоны дараа ТУЗ-оос шийдвэрлэнз.
- 13.4. Сангийн хөрөнгийг захиран зарцуулахаа Сангийн үйл ажиллагаанд хуулиар оролцохыг зөвшөөрсөн этгээдүүдэд төлөх үйлчилгээний хөлс, Сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэвийн, тасралтгүй, тогтмол үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардлагатай зардал дээр үндэслэгдэх зарчим баримтална.
- 13.5. Сангийн хөрөнгийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
 - 13.5.1. ТУЗ-ийн гишүүдийн хараат бус үр дүнтэй үйл ажиллагааг хангуулах зорилготой цалин хөлс;
 - 13.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын менежментийн компанийд төлөх төлбөр, гүйцэтглийн урамшуулал;
 - 13.5.3. Хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр кастодианд төлөх төлбөр;
 - 13.5.4. Банкны үйлчилгээний шимтгэл, хураамжууд;
 - 13.5.5. Брокерийн үйлчилгээний шимтгэл, хураамж;
 - 13.5.6. Аудит болон нягтлан бодох бүртгэл хетгэх төлөх үйлчилгээнд төлөх төлбөр;
 - 13.5.7. Хуулийн үйлчилгээний зардал;
 - 13.5.8. Сангийн актив хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомжид заасан улсын тэмдэгтийн бүх төрлийн хураамж;
 - 13.5.9. Сангийн актив хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомжид заасан бүх төрлийн татвар;
 - 13.5.10. Сангийн нэгж эрхийн эзэмшигчдийн хурлын зардал;
 - 13.5.11. Нэгж эрхийг хөрөнгө оруулагчдад санал болгох, худалдахтай холбоотой гарсан Сангийн менежерийн үйл ажиллагааны зардал;
 - 13.5.12. Хууль тогтоомжид Сан хариуцахаар заасан бусад зардал.
- 13.6. Сангийн зардлын гүйлгээ нь гүйцэтгэх удирдлага эсхүл түүнийг орлох этгээд. Нэгж эрх эзэмшигчдийн хурал эсхүл ТУЗ-оос шийдвэрлэсэн бол хурлаас зөвшөөрсөн этгээдийн гарын үсэг болон сангийн тэмдэг (тамга)-ээр баталгаажсан байна.
- 13.7. Сангийн хөрөнгөнөөс Менежментийн компанийн болон Сангийн менежерийн бусдын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтглийг хангахгүй.
- 13.8. Энэхүү Дүрмийн 13.5.2, 13.5.3-д заасан зардлын нийлбэр дун нь Сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 3 хувиас хэтрэхгүй байна.
- 13.9. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны гэрээнд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтглийн урамшуулал егехеөр тохиолцсон тохиолдолд хэмжээ нь сангийн ашгийн 30 хувиас хэтрүүлэхгүйгээр тусгана.

Арван дөрөв. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл

- 14.1. Сангийн нягтлан бодох бүртгэлийг бүртгэлийн олон улсын стандартын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хотөлине.

Хуудас 10 | 13





- 14.2. Сангийн нягтлан бодох бүртгэлийг Менежментийн компани гүйцэтгэх бөгөөд эсхүл хуульд заасан эрхтэй хуулийн этгээд болон мэргэшсэн нягтлан бодогчоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
- 14.3. Сангийн нягтлан бодох бүртгэлийг хетлэх этгээд нь тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан, аудитын компани, түүний ажилтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

Арван тав. Хөрөнгө оруулалтын сангийн хяналтын тогтолцоо

- 15.1. Сан нь тухайн санхүүгийн тайлангийн жил дусах тухай бур санхүүгийн үйл ажиллагаанд аудитийн шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитийн дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.
- 15.2. Сангийн ТҮЗ аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд сангийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудитын байгууллагад төлөх хөлс, аудит хийлгэх хугацаа зэргийг заана.
- 15.3. Сангийн ТҮЗ эсхүл түүнээс томилогдсон хяналтын хороо нь Сангийн үйл ажиллагаа хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг хангаж байгаа эсэх болон нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилт зэрэгт хяналт тавьж ажиллана.
- 15.4. Хяналтын хороо нь ТҮЗ-өөс томилогдсон З гишүүний бүрэлдхүүнтэй байх бөгөөд дотоод хяналтыг Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ны холбогдох журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Арван зургаа. Санг татан буулгах

- 16.1. Санг дараах тохиолдолд татан буулгана. Үүнд:
 - 16.1.1. Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;
 - 16.1.2. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас санг сайн дурын үндсэн дээр хугацаанаас өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;
 - 16.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулсан бөгөөд Сангийн нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонх санг татан буулгах шийдвэр гаргасан;
 - 16.1.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу онцгой нехцэл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдер болсон;
 - 16.1.5. Сан дампуурсан;
 - 16.1.6. Төлбөрийн чадваргүй болох;
 - 16.1.7. Хууль тогтоомжид заасан бусад.

Хуудас 11 | 13



- 16.2. Хөрөнгө оруулалтын санг татан буулгах шийдвэрийг дараах этгээд гаргана:
- 16.2.1. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал;
 - 16.2.2. Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий бусад этгээдийн хүсэлтийг үндэслэн шүүх;
 - 16.2.3. Энэхүү дүрмийн 16.1.1-16.1.3-д заасан үндэслэлээр санг татан буулгах шийдвэрийг нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гаргана.
 - 16.2.4. Энэхүү дүрмийн 16.1.4-16.1.5-д заасан үндэслэлээр санг татан буулгах шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий этгээдийн хүсэлтээр Монгол Улсын шүүх гаргана.

Арван долоо. Сангийн хөрөнгийг хуваарилах

- 17.1. Татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг дараах дарааллын дагуу хуваарилна. Үүнд:
- 17.1.1. Сангийн төлөх татварын ер, төлбөр;
 - 17.1.2. Санд үйлчилгээ үзүүлсэн бусад этгээдэд төлөх ер, төлбөр;
 - 17.1.3. Санг татан буулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа төрийн болон эрх бүхий байгууллагад төлөх төлбөр;
 - 17.1.4. Хөрөнгө хадгалах гэрээний дагуу кастодианд төлөх үйлчилгээний төлбөр;
 - 17.1.5. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний төлбөр.
- 17.2. Энэхүү Дүрмийн 23.2-д заасны дагуу хөрөнгийг хуваарилж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сангийн нэгж эрх эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь мөнгөн хөрөнгөөр хувь тэнцүүлэн олгоно.

Арван найм. Сангийн дүрэм хүчин төгөлдөр болох

- 18.1. Энэхүү Дүрмийг 4 [дерев] хувь үлдсэн бөгөөд үүсгэн байгуулагч нэг хувийг, Санхүүгийн зохицуулах хороо нэг хувийг, Оюуны ёмч, Улсын бүртгэлийн өрөөхийн газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газар нэг хувийг, үлдсэн нэг хувийг Сан өөртөө хадгална.
- 18.2. Энэхүү дүрэм нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батлагдах, Оюуны ёмч, Улсын бүртгэлийн өрөөхийн газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 18.3. Энэхүү Дүрэм нь Сангийн үндсэн баримт бичиг байна.
- 18.4. Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Хуудас 12 / 13





----ooOoo----

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"АРД МЕНЕЖМЕНТ УЦК" ХХК



Хуудас 13 | 13

